



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

# ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2023 оны 10 дугаар сарын 18-ны өдөр, Лхагва гараг**

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-4</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>4-50</i>
<hr/>	
<i>1. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.10.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	<i>6-50</i>

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы  
2023 оны 10 дугаар сарын 18-ны өдөр /Лхагва гараг/-ийн  
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 72 гишүүнээс 37 гишүүн хүрэлцэн ирж, 51,4 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 10 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

*Томилолттой: А.Адъяасүрэн, Б.Баттөмөр, С.Бямбацогт, Б.Дэлгэрсайхан, Б.Жаргалмаа, Л.Мөнхбаатар, Ц.Мөнх-Оргил, Ц.Туваан, Ж.Эрдэнэбат;*

*Чөлөөтэй: Ё.Баатарбилэг, Л.Оюун-Эрдэнэ, Д.Өнөрболор, Ч.Ундрэм, Б.Чойжилсүрэн;*

*Эмнэлгийн чөлөөтэй: С.Батболд, Х.Болорчулуун, Г.Дамдинням, Ж.Чинбүрэн;*

*Тасалсан: Ц.Анандбазар, Д.Ганбат, Х.Ганхуяг, Ш.Раднаасэд;*

*Хоцорсон: Ц.Даваасүрэн-12 минут, Б.Жавхлан-1 цаг 31 минут, Г.Мөнхцэцэг-07 минут, М.Оюунчимэг-04 минут, Д.Сарангэрэл-04 минут, Ц.Сэргэлэн-01 минут, Н.Учрал-06 минут, Д.Цогтбаатар-02 минут, Т.Энхтүвшин-05 минут.*

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибалаас ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибал үг хэлэв.

***Нэг. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.10.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Улсын ерөнхий прокурорын орлогч, Төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга О.Мөнхбаатар, Цагдаагийн ерөнхий газрын Захиргаа удирдлагын газрын дарга Л.Нямдаваа, мөн газрын Зөрчлийн хэрэг бүртгэл, мэргэжил арга зүйн хэлтсийн дарга Б.Уртнасан, Тээврийн цагдаагийн албаны Зөрчил шалган шийдвэрлэх хэлтсийн дарга Ц.Чинзориг, Хууль зүй, дотоод хэргийн сайдын зөвлөх Д.Мөнх-Эрдэнэ, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч Ш.Цолмон, мөн газрын шинжээч Т.Нарантунгалаг, мэргэжилтэн Ц.Лхагвацэнд, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах, Эрүүгийн хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах, боловсронгуй болгох чиг үүрэг бүхий Байнгын ажлын хэсгийн гишүүн Б.Гантуяа, Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн захирал С.Гантулга нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ч.Батбямба, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөхийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Золжаргал, референт П.Хулан нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, төслийг хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, О.Цогтгэрэл, С.Одонтуяа, Ж.Бат-Эрдэнэ, Г.Амартүвшин, М.Оюунчимэг, Д.Тогтохсүрэн, Б.Баярсайхан, Г.Ганболд, Ж.Сүхбаатар, Ж.Батсуурь, Ц.Сандаг-Очир, Ж.Батжаргал, Ш.Адьяа, Б.Саранчимэг нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах, Тээврийн цагдаагийн албаны Зөрчил шалган шийдвэрлэх хэлтсийн дарга Ц.Чинзориг, Хууль зүй, дотоод хэргийн сайдын зөвлөх Д.Мөнх-Эрдэнэ, Цагдаагийн ерөнхий газрын Захиргаа удирдлагын газрын дарга Л.Нямдаваа, Эрүүгийн хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах, боловсронгуй болгох чиг үүрэг бүхий Байнгын ажлын хэсгийн гишүүн Б.Гантуяа, Улсын ерөнхий прокурорын орлогч М.Чинбат нар хариулж, тайлбар хийв.

*Улсын Их Хурлын дэд дарга С.Одонтуяа 16 цаг 26 минутаас хуралдааныг даргалав.*

Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяа, Б.Саранчимэг нар үг хэлэв.

**С.Одонтуяа:** Байнгын хорооны саналаар Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27

Татгалзсан: 13

Бүгд: 40

67.5 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэж үзсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 18 цаг 21 минутад хэлэлцэж дуусав.*

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайхан Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг дараагийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлье гэсэн горимын санал гаргав.

**С.Одонтуяа:** Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайханы гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21

Татгалзсан: 19

Бүгд: 40

52.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг дараагийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхээр тогтов. /18:24/

**Бусад.** Сант сургуулийн 7г ангийн багш, сурагчид Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Мөнхцоож, шинжээч С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

Хуралдаан 3 цаг 15 минут үргэлжилж, 72 гишүүнээс 50 гишүүн хүрэлцэн ирж, 69.4 хувийн ирцтэйгээр 18 цаг 25 минутад өндөрлөв.

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧИЙН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН

2023 оны 10 дугаар сарын 18-ны өдөр,  
Лхагва гараг  
Төрийн ордон “Их хуралдай” танхим  
15 цаг 10 минут

### НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Гишүүдийн ирц бүрдсэн тул Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сарын 18-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 2 асуудал хэлэлцэнэ.

1. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

2. Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдааныг нэмэлтээр зарлаж байгаа. Маргааш төсөв, маргааш, нөгөөдөр 2024 оны улсын төсөв, Нийгмийн даатгалын төсөв, Эрүүл мэндийн даатгалын төсөв хэлэлцэнэ. Мөн төсөвтэй хамт өргөн мэдүүлсэн олон хуулийн төслүүд байгаа. Энэ хуулийн төслүүдийг хэлэлцэх учраас өнөөдөр Засгийн газраас яаралтай горимоор өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Хүүхэд хамгааллын тухай хуулийн төслүүдийг хэлэлцэхээр өнөөдрийн чуулганыг хуваариас гадуур нэмж зарласан гэдгийг тодотгоод, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны

дэгийн тухай хуулийн дагуу Улсын Их Хурлын гишүүн Дэгийн тухай хуулийн 9.5-д заасан хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах, дараалал өөрчлөх, асуудал нэмэх горимын санал гаргах бол Улсын Их Хурлын даргад нэгдсэн хуралдаан эхлэхийн өмнөх өдрийн 17 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Наянтайн Ганибалаас албан бичиг ирүүлсэн байна. Наянтайн Ганибал гишүүн маань 18-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцэх асуудлын дараалалтай холбоотойгоор үг хэлэх зөвшөөрөл олгоно уу гэсэн байна. Ингээд Наянтайн Ганибал гишүүн үг хэлнэ.

**Н.Ганибал:** Та бүхэндээ өдрийн мэнд хүргэе. Өнөөдөр бас хүүхэд хамгааллын асуудлаар яаралтайгаар асуудлыг оруулж ирж хэлэлцүүлэх гэж байгаа Засгийн газартаа бас баяр хүргэе. Болж байна. Гэхдээ өөр олон асуудлууд бас орхигдож байна. Олон асуудлууд орхигдож байна. Сүүлийн 7 жилийн хугацаанд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль байгаа. Энэ хуулийг бол үнэхээр бас олон янзаар зөрчиж, олон төрлөөр бүр зөрчиж, төрийн мөнгийг шамшигдуулсан асуудлууд бол хэрээс хэтэрсэн. Саяхан ногоон автобусны асуудал Монголын ард түмнийг цочирдуулсан байгаа. Төрийн өмчөөр капитал автобус худалдаж авах энэ асуудлыг төрийн нууцад оруулж байгаад зохион байгуулсан зохион байгуулалттай бараг гэмт хэргийн шинжтэй энэ үйлдлийг өнөөдөр бид нар яагаад хэлэлцэхгүй байна вэ. Энэ асуудал байна. Дээрээс нь нүүрсний оффтейк гэрээ байна. Монгол төрийн хамгийн том худалдан авалтуудыг төрийн өмнөөс хийх ажил, үйлчилгээг бүгдийг нь нууцад оруулж байгаад 17 их наядоор нууц гэрээ байгуулж, зохион байгуулалттай бас үйл ажиллагаа явуулчихсан. Энэ болгоныг бид бүхэн ард түмэндээ ил тод болгож, яагаад өнөөдөр Монгол төрийн хөрөнгө мөнгийг шамшигдуулсан, хуулийг буруу

ашигласан энэ асуудлыг бид яаралтайгаар яагаад хэлэлцэж олон нийтэд ил тод мэдээллийг өгөхгүй байгаа юм бэ.

Энэ дээр Их Хурлын гишүүн миний бие Түр хороо байгуулах санаачилгыг гаргаад явж байгаа. Ардчилсан намын бүлгийн бүх гишүүд зурсан байгаа. Мөн ХҮН намын сонгогдсон Их хурлын гишүүн Доржханд гишүүн маань зурсан байгаа. Энэ дээр бас Ардын намынхаа гишүүдийг, бүлгийн гишүүдийг бас энэ түр хороо дээр бас гарын үсэг зурж өгөөч ээ. Энэ түр хороог яаралтай байгуулж, цөөнхөөр ахлуулаад олон нийтэд төрийн худалдан авах энэ тендерийн хуулийг яаж буруу ашиглаж Монголын төрийг завхруулж байгаа талаар олон нийтэд мэдээллийг ил тод болгоё гэсэн ийм санал гаргаад явж байгаа. Та бүхэн маань энэ чуулганы танхимын үүдэнд манай ажлын албаныхан гарын үсэг зуруулах үйл ажиллагаа зохион байгуулж байгаа. Та бүхэн маань бас энийг дэмжиж, гарын үсэг зураасай гэж хүсэж байна.

Ер нь Монгол төрийн хулгай зэлгий үнэхээр хэрээс хэтэрсэн байдлыг хэдүүлээ нийтдээ таслан зогсоё. Хэн нэгний засгийн газрыг Их Хурлын гишүүд нь манай намынх гэж өмгөөлж хамгаалж болохгүй. Үүнээс болж бид нар өнөөдөр Монгол төрийнхөө энэ их хулгайг төрийн мөнгө төсвийн мөнгөний хулгайг бид нар хаацайлсан ийм байдалтай байгаад байна. Тэгэхээр энэ дээр бүгдээрээ санал нэгдэж, санаагаа нэгтгэж ажиллая гэж уриалж байна.

**Г.Занданшатар:** Наянтайн Ганибал гишүүн үг хэллээ. Уриалга дэвшүүлээ. Хэлэлцэх асуудлаар санал хураах зүйлгүй.

**Одоо хэлэлцэх асуудалдаа орёё. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн**

**төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ ээ.**

Хууль санаачлагчийн илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр танилцуулна. Индэрт урьж байна.

**Б.Энхбаяр:** Улсын Их Хурлын эрхэм дарга, гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2020 оны 10 дугаар сарын 13-ны өдөр нэн яаралтай горимоор Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлснийг та бүхэнд танилцуулъя.

Дараах үндсэн 4 асуудал дээр төвлөрч, ялын бодлогыг чангатгах асуудлыг оруулж байна.

1.Авлига, албан тушаалын гэмт хэрэгт ял шийтгэгдсэн хорих ял эдэлж байгаа этгээдийг хугацаанаас нь өмнө суллахгүй, магадлангаар оруулахгүй,

2.Бага насны хүүхдийн эсрэг үйлдэгдэж байгаа ялангуяа бэлгийн эсрэг үйлдэгдэж байгаа ял, шийтгэлийн бодлогыг чангалж, хөөн хэлэлцэх хугацааг тооцохгүй буюу зарим тохиолдолд 30 хүртэл жилийн хугацаагаар тооцох өөрчлөлт, мөн энэ төрлийн гэмт хэрэгт өршөөл үзүүлэхгүй.

Хорих ялаас хугацаанаас өмнө суллахгүй, магадлангаар оруулахгүй,

Бага насны хүүхдийг алах, бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэгт оногдуулах ялын дээд хэмжээ 20 байгааг 25 жил болгож нэмэгдүүлэх.

Сүүлийн 5 жилийн байдлаар хүчиндэх гэмт хэрэгт хохирсон нийт хохирогчдын 62,7% нь хүүхдүүд байна. Шүүхээс энэ төрлийн гэмт хэрэгт ял шийтгэл ноогдуулж байгаа байдлыг сүүлийн үеийн статистикаар авч үзэхэд

хамгийн ихдээ 50-54% нь 10-15 жилийн хорих ял ноогдуулж байна. Энэ төрлийн ял шийтгэл эдэлж байгаа хүмүүсийн 22,7% нь урьд нь мөн энэ төрлийн гэмт хэрэгт ял шийтгэгдэж байсан этгээдүүд байна.

Өршөөл, уучлал, магадлангаар оруулахгүй гэдэг асуудал дээр судалгаа хийж үзэхэд сүүлийн 10 жилийн байдлаар бусдыг санаатай алах, бага насны хүүхдийг хүчиндэх, авлига, албан тушаалын гэмт хэргээр ял эдэлж байсан 3879 этгээд хугацаанаас өмнө суллагдсан байна. Эдгээр хүмүүсээс 6 хүн дахин гэмт хэрэг үйлдсэн байна. 3873 нь дахин гэмт хэрэг үйлдээгүй байна гэдгийг хэлье. Нийт энд суллагдсан хүмүүсээс 52,9% нь хүнийг санаатай алах гэмт хэрэгт, 45,4% нь хүчиндэх гэмт хэрэгт, 13,7% нь бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэгт, 1,6% нь авлига, албан тушаалын гэмт хэргээр ял шийтгэл эдэлж байсан, суллагдсан хүмүүс байна. Эдгээр суллагдсан хүмүүсийн 77,5% нь шүүхийн магадлангаар орж, шүүгчийн захирамжаар суллагдсан байна. Хорих ялын хугацаа нь дуусаж суллагдсан хүн 12,2%-ийг нь эзэлж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэгт ял шийтгэгдсэн этгээдэд уучлал үзүүлж байгаагүй байна. Энэхүү ялыг чангалахтай холбоотойгоор мөн Эрүүгийн хуульд байгаа бага насны хүүхэд гэдэг насны ангиллыг 14 байгааг 16 нас болгох өөрчлөлтийг оруулах саналыг мөн дэвшүүлж байна. Ингэснээр 14-16 насны хүүхдийн алах, хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар авах, бэлгийн мөлжлөг хийх, аюултай байдалд орхих, тусламж үзүүлэхгүй байх, садар самууныг сурталчлах, хулгайлах, эрүүл мэндэд нь хөнгөн, хүндэвтэр, хүнд гэмтэл санаатай учруулах гэсэн 10 орчим зүйл ангид байгаа Эрүүгийн хуулийн ялын бодлого 14-16 хүртэлх насны хохирогчтой хэргийн тухайд хүнд ангилал руу шилжиж, 20-25 жилийн хорих ялтай, бүх насаар хорих ялтай

болж ялын бодлого чангарч байна. Манай улсын тухайд эрүүгийн ял шийтгэлийн бодлогодоо бага насны хүүхдийн эсрэг үйлдэгдэж байгаа хүчирхийллийн гэмт хэргийн ялын бодлого сул биш. Бусдыг санаатай алах гэмт хэргээс хүүхдийн эсрэг үйлдэгдэж байгаа гэмт хэргүүдэд оногдуулж байгаа ялын тоо 2 дахин чанга байдаг гэдгийг та бүхэнд хэлье.

Энэ удаагийн өөрчлөлтийг хийснээр хүүхдийн эсрэг аливаа үйлдэгдэж байгаа хүчирхийллийн шинжтэй гэмт хэрэг тэр дотроо хүчиндэх гэмт хэргүүд ялын хамгийн дээд хэмжээндээ тулна гэсэн үг. Үүнээс цааши бид ялыг чангалах Эрүүгийн хуулийн заалт байхгүй болно гэсэн үг.

Дараагийн нэг зарчмын асуудал бол согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох үйлдлийг Зөрчлийн хуулиас авч гэмт хэрэгт тооцох саналыг дэвшүүлж байна. Манай улсын тухайд жилд дунджаар 30 гаруй мянган зөрчил согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох үйлдэлд шийдэгдэж байна. Жилд дунджаар 110 хүн амь насаа бас согтуу жолоочийн улмаас алдаж хохирч байгаа гэсэн харамсалтай дүн мэдээ гарсан. Хэдий тийм боловч өнгөрсөн онд Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хуралд согтууруулахтай тэмцэх хуулийн өөрчлөлтийг өргөн мэдүүлж, Улсын Их Хурал мөн хуулийг баталсан байгаа.

Мөн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлогыг бас урьдчилан сэргийлэх тухай хуулийг Улсын Их Хурлаас шинэчлэн баталсан байдаг. Энэхүү хуулийн өөрчлөлт үр дүнгээ өгч байгаа нь дараах байдлаас харагдаж байна. Тухайлбал:

Сүүлийн 1 жилд согтуугаар үйлдэгдэж байгаа гэмт хэргийн тоо 1 жилийн хугацаанд 15%-аар буурсан байна. Мөн архины борлуулалт сүүлийн 1 жилийн хугацаанд 1,3 сая литрээр буурсан байна. Хэдий тийм боловч согтуугаар тээврийн хэрэгслийг



жолоодох үйлдэлтэй хатуу гараар тэмцэхээс өөр аргагүй боллоо. Энэ бол санаатай үйлдэл гэж бид үзэж байгаа. Энэ бол болгоомжгүй гэмт хэрэг огт биш ээ. Сogтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож байгаа хүн өөрийн үйлдлийн хор уршиг, үр дагаврыг мэдэж байгаа. Энэ бол буруу дадал, буруу зуршил. Тийм учраас энэ үйлдэлтэй хатуу тэмцэж тогтвортойгоор бид 5 жилийн хугацаанд энэ асуудлыг барьж чадвал тээврийн хэрэгслийн cogтуугаар үйлдэх энэ үйлдэл байхгүй болохыг ч гэсэн үгүйсгэх аргагүй ээ.

Бид сайн үйлдлийг хуулиар дамжуулж бас хийдэг байх учиртай. Өнгөрсөн 7 хоногт Засгийн газраас энэхүү хуулийн өөрчлөлтийг дэмжсэний дараа хийсэн хэвлэлийн бага хурлын дараа сүүлийн 7 хоногт улсын хэмжээнд cogтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчил 42-47% буурсан сайн үзүүлэлттэй байгааг та бүхэнд танилцуулъя.

Улсын Их Хурлын эрхэм дарга, гишүүд ээ

Засгийн газраас өргөн барьсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлүүлж өгөхийг та бүхнээс хүсье. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Төслийн талаар Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн асуудал эрхэлсэн түр хорооны дарга Энхтайвангийн Бат-Амгалан танилцуулна. Индэрт урьж байна. Монгол Ардын намын бүлгийн дэд дарга.

**Э.Бат-Амгалан:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт

өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2023 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч хүүхдийн эсрэг зарим гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг нэмэгдүүлэх, бага насны хүүхдийг алах, бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэгт оногдуулах ялыг чангатгах, бага насны хүүхдийн насны хязгаарыг нэмэгдүүлэх, мөрдөн шалгах ажиллагааны нууцыг албаны үүргийн дагуу олж мэдсэн албан хаагч, ажилтан мөрдөн шалгах ажиллагааны нууцалсан баримт мэдээллийг зориуд задруулж нууцалсан гэрчийг илчилж хэрэг шалган шийдвэрлэх ажиллагаанд саад учруулсан үйлдэлд оногдуулах ялыг чангаруулах, cogтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон үйлдэлд оногдуулах ялын бодлогыг чангаруулах зорилгоор хуулийн төслийг боловсруулсан бөгөөд уг хуулийн төсөл батлагдсанаар материаллаг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа тул зардал үүсэхгүй гэж хууль санаачлагч үзсэн байна.

Хууль зүйн төслийг D-parliament.mn цахим хуудаст байршуулан олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Алтанхуяг хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж байгаагаа илэрхийлж, хуулиар мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулах гэмт хэргийг зөвхөн шүүгч, прокурор, хууль сахиулагч, өмгөөлөгч гэсэн хүрээнд хамааруулж байсныг хавтгайруулан тухайн мөрдөн шалгах ажиллагааны нууцыг олж авч мэдсэн хүн гэдэг агуулгаар томьёолсон нь зөв эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Адышаа бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн гэмт хэрэгт оногдуулах ялыг чангатгах хуулийн төслийг нэн яаралтай горимоор өргөн мэдүүлж хэлэлцэхийг дэмжиж байгаагаа илэрхийлж, cogтуугаар тээврийн хэрэгсэл

жолоодохтой холбоотой зөрчил, гэмт хэрэг, мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулах гэмт хэргийн талаарх асуудлыг нэн яаралтай оруулж ирж байгаа үндэс шаардлагын талаар, Улсын Их Хурлын гишүүн Сэргэлэн хүчиндэх гэмт хэрэг болон бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн ялын бодлогын ялгаатай байдал болон энэ гэмт хэрэг үйлдсэн этгээдийн зураг мэдээллийг олон нийтэд нээлттэй мэдээлэх боломжтой эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Раднаасэд согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож зөрчил гаргаж байгаа хүмүүсийн нас, хүйсийн талаар судалгаа байгаа эсэх, бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн гэмт хэрэг, эцэг эх байх, халамжлах үүргээ гүйцэтгээгүй бага насны хүүхэдтэй зүй бусаар харьцсан, хүүхдийг хүчээр хөдөлмөрлүүлэх гэх мэт асуудлыг бүрэн тусгаж цогцоор оруулж ирэх боломж байгаа эсэх, хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгасан торгох шийтгэлийн хэмжээг хөнгөрүүлэх, нэмэгдүүлэх үндэслэлийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар архидан согтуурахтай тэмцэх ажлыг эрчимжүүлж, архинд донтох эмгэгтэй хүнд үзүүлэх эмчилгээ үйлчилгээний үндэсний чадавхыг бэхжүүлэх тухай асуудлыг Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусган батлуулж байсан талаар онцлоод, хууль санаачлагчаас согтууруулах ундаа хэрэглэсэн, түүнийг шалгаж тогтоох ажиллагааны үр дүнд шалгуулагчийн амьсгал болон цусан дахь спиртийн агууламжийг хэрхэн тооцон гаргадаг талаар, Улсын Их Хурлын гишүүн Мөнхцэцэг уг хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж байгаагаа илэрхийлээд, гэрч хохирогчийг хамгаалах асуудлыг анхаарч Тахарын албыг дахин байгуулах, хууль, эрх зүйн боломж байгаа эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ганбат сэтгэцийн эмгэгтэй хүн бага насны хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд авах арга

хэмжээний талаар, Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар бага насны хүүхдийн насны дээд хязгаарыг нэмэгдүүлж байгаа шалтгаан нөхцөл, 14-16 насны хүүхдийг бага насны ангилалд оруулахад иргэний хууль болон бусад хууль, тогтоомжид заасан иргэний эрх зүйн бүрэн чадамжтай нийцэж байгаа эсэх талаар, тэдгээр хүүхдийн эрх хумигдаж байгаа эсэх, мөн нэн яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн хуулийн төслийн дагаж мөрдөх хугацааг 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тусгасан нь зөв эсэх талаар тус тус асуулт, асууж, хариулт авсан болно.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 72,7% нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөх оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх талаар Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье ээ. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Хууль зүй, дотоод хэргийн сайдын зөвлөх Дэмбэрэлцэрэнгийн Мөнх-Эрдэнэ, Улсын ерөнхий прокурорын орлогч Максимын Чинбат, Улсын ерөнхий прокурорын

туслах прокурор, Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга Отгонбаярын Мөнхбаатар, Цагдаагийн ерөнхий газрын Захиргаа удирдлагын газрын дарга Лхамдоржийн Нямдаваа, Тээврийн цагдаагийн албаны Зөрчил шалган шийдвэрлэх хэлтсийн дарга Цолмонгийн Чинзориг, Цагдаагийн ерөнхий газрын Зөрчлийн хэрэг бүртгэл мэргэжил, арга зүйн хэлтсийн дарга Болдбаатарын Уртнасан, Хууль зүйн Үндэсний хүрээлэнгийн захирал Хүрэлбаатарын Эрдэм-Ундрах, Эрүүгийн хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах боловсронгуй болгох чиг үүрэг бүхий байнгын ажлын хэсгийн гишүүн Базаргүрийн Гантуяа, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч Чагдарсүрэнгийн Цолмон, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын шинжээч Төмөрчөдөрийн Нарантунгалаг, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын мэргэжилтэн Цэрэнсүрэнгийн Лхагвацэнд.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ бүртгүүлнэ. Ширнэнбандийн Адьшаа гишүүнээр тасаллаа. Эрхэм гишүүн Норовын Алтанхуяг асуулт асууна.

**Н.Алтанхуяг:** Өдрийн амгаланг айлтгая. Өчигдрийн Байнгын хороо дээр би бас зарим нэг асуулт, саналуудаа хэлчихсэн. Ер нь бол энэ орж ирж байгаа Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай зарим хэрэг дээр нь энэ ялыг нь чангатгах тухай, өршөөл үзүүлэхгүй байх тухай, магадлангаар оруулахгүй байх гээд энэ саналуудыг бол дэмжиж байгаа юм. Миний нэг өчигдрөөс хойш би бас эргэлзээд л асуугаад л яваад байгаа юмыг би дахиж тодруулах гээд байгаа юм. Энэ бол мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулах гэмт хэргийн ялын бодлогын тухай. Энэ дээр бол хууль хяналтын

байгууллагынхан өөрөө энэ мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулаад байдгийг хааж байгааг бол би бол зөв гэж байгаа юм. Одоо хаах юу байх вэ. Ялыг нь чангатгаж байгааг зөв гэж үзэж байгаа юм. Гэтэл одоо энэ амьдрал дээр нэг ийм юм байна. Энэ Энхбаяр сайд хариулах юм болов уу, хэн нь хариулах юм. Одоо ингэсэн тэр 2014 онд, 2013 онд ч билүү өгсөн хууль дээр ингээд энэ нууцын тухай ярихгүй бол болохгүй. Одоо ингэнэ шүү дээ та нар. Баримт мэдээллийг задруулсан гээд байгаа юм. Тэгэхээр одоо би саяын Хөгжлийн банкны шүүх хурал дээр хэдэн сар суухдаа юу харав гэхээр ерөөсөө ямар нэгэн хэрэгт холбогдонгуут нь ерөөсөө энэ юм ярих гэхээр мөрдөн шалгах ажиллагааны нууц задруулж байна гээд. Мөрдөн шалгах ажиллагааны нууц гэж юу юм бэ. Хавтаст хэрэг нь бараг тэр чигтээ хавтаст хэрэг дотор Засгийн газрын тогтоол явж байхад тэрийг жишигээр юм бол нууц гэж үзэх юм уу. Тэгэхээр энийг нэг учрыг нь гаргаж тайлбарлаж, чаддаг бол энэ хуульд оруулчихмаар санагдаад байгаа юм. Нууцлагдвал зохих зүйлс юу юм бэ. Би одоо энэ дээр та нарт бүр нэг юм сонсох гэж бодож ирлээ. Би одоо их бас олон юм ярихаар ойлгогдохгүй байх даа. Би одоо энэ автобусны хэрэгт холбогдсон гээд байгаа хүний нэг юмыг би сонсож байгаад та нарт сонсоё гэж аваад ирлээ. Би нэг ийм л юм хүсээд байгаа юм. Тэр маань хаачсан юм. Би одоохон уучлаарай. Тэгэхээр энэ бид нарын хуучин тэр нөгөө нууцлагдвал зохих баримт мэдээлэл гэдэг чинь өөрөө энийг ингэж хааж өгөх ёстой юм байхгүй юу. Одоо ерөөсөө бүх юм нууц боллоо. Төсвийн хөрөнгөөр барьсан байшин сав, зам, бүх юм нууц. Худалдаж авсан автобус чинь нууц. Үгүй ээ, одоо ийм байх юм бол одоо энэ нууц задална гэдэг чинь шал буруу юм руу явах гээд байна. Тэгэхээр энэ дээр хэдүүлээ зөв болгоодохвол яадаг юм бол доо.

Та бүхэн маань би энийг сонсгоодохъё доо. Та нар нэг сонслоо.

*/-Ажлын хэсгийн протокол харсан юм.*

*-Протокол дээр харин таны хэлсэн үгийг уншаад тэгээд нэмж тодруулах гээд залгаж байгаа юм.*

*-Аан за. Тэр одоо нөгөө мөрдөн байцаалт, хэрэг бүртгэл дээрээ шат нь явж байгаа болохоор би энэ илүү нэг их юм яриааргүй байх юм.*

*-Аанхан.*

*-Тэр нь одоо тэгээд нөгөө бас янз янзын юманд яагаад байвал дараа нь мөрдөн байцаалтын нууц задруулсан юм болбол яах юм. Тэгээд би чинь нөгөө эрх бүхий байгууллагад нь өгөх юмаа өгчихсөн, хэлэх юмаа хэлчихсэн, мэдүүлгүүдийг нь өгчихсөн болохоор надад нэг их одоо яриад байх юм алга байна шүү дээ./*

*Ийм л юм амьдрал дээр болчихоод байна. Одоо тэр хуралд нь суугаад саналаа хэлсэн хүнээс 1 хүн нь ингээд эсэргүүцээд энэ чинь буруу байна шүү. Энэ автобусны чинь асуудал гээд хэлсэн хүн маань өөрөө ингээд тэр хэрэгт холбогдогч болоод оччихоор үнэнээ ч хэлж чадахаа больчихсон. Тэр хурал дээр бол зөндөө юм ярьчихсан байна лээ шүү дээ. Тэгэхээр би юу гэж хэлээд байна вэ гэхээр нууцлагдвал зохих баримт мэдээлэл гэдэг юмыг жаахан тодруулж өгмөөр байна. Нууцлагдсан.../минут дуусав/*

**Г.Занданшатар:** *Эхлээд хариулна. Тэгээд хариулт хангалтгүй болж тодруулж асууна. Баттөмөрийн Энхбаяр сайд хариулна. Хууль зүй, дотоод хэргийн сайд хариулна. Тэр хариултаа их товч тодорхой болгож байгаад дараа нь энэ хариулт дээр нь тулгуурлаж байгаад их сайн томъёолоод асуучихъя.*

**Б.Энхбаяр:** *Мөрдөн шалгах ажиллагааны нууцыг дэлхийн бүх улс*

*оронд задруулахыг гэмт хэрэгт тооцдог. Манай улсын тухайд 1926 оноос энэ төрлийн гэмт хэргийг*

*бүх Эрүүгийн хуулиуддаа гэмт хэрэгт тооцоод 100 жил болж байгаа. Энэ гэмт хэргийн субъект нь тусгай субъектүүд байдаг. Өөрөөр хэлбэл тухайн гэмт хэргийг шалгаж буй мөрдөн байцаагч, хэргийн материалтай танилцаж байгаа өмгөөлөгч, шүүгч, прокурор. Эдгээр 4 хүнээс гадна Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бусад оролцогч гэж ойлголт байдаг. Энэ хүмүүс нь юу байна вэ гэхээр тухайн хэрэгт жишигээр оролцож байгаа хэлмэрч, шинжээч, орчуулагч, иргэний хариуцагч, иргэний нэхэмжлэгч, хөндлөнгийн гэрч гэсэн ийм хүмүүс мөн мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулахгүй байх үүрэг хүлээж, урьдчилан сануулагдаж, бичгээр нууцын баталгаа гаргасан байдаг.*

*Монгол Улсын Дээд шүүхийн тайлбар ёсоор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа урьдчилан сануулагдсан нууцын баталгаа зурсан энэ хүмүүс мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулбал энэ гэмт хэргээр зүйл анги ял сонсгож, шийтгэгдэг байгаа. Тэрнээс бус үүнийг энэ хүрээнд шалгаж байгаа талаар хэргийн үйл баримтыг олон нийтэд түгээсэн, хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлч иргэдийг энэ гэмт хэргийн субъект болдоггүй 100 жил болсон. Үүний нотолгоо нь 2015 оны Эрүүгийн хууль 2017 оны 7 сарын 1-ээс хүчин төгөлдөр болсон. Сүүлийн 6 жилийн хугацаанд энэ хууль үйлчилсэнээс хойш энэ зүйл ангиар ял шийтгэгдсэн 1 ч сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллага байхгүй. Тэгээд энэ нь өөрөө энэ зүйл ангийн хангалттай нотолгоо болж байгаа юм аа 1.*

*2.Энэ зүйл анги нь тэр иргэд, тэр дотроо иргэдийн мэдэх эрхийг хангах энэ хулгай луйвартай холбоотой мэдээллүүдийг түгээж байгаа, шүгэл үлээж байгаа асуудлыг хязгаарладаг зүйл*

анги огт биш. Мөрдөн шалгах ажиллагааны нууцыг яриад байгаа юм. Энэ бол тухайн гэмт хэргийг илрүүлэх, тухайн гэмт хэргийн улмаас хохирсон гэрч, хохирогчийг хамгаалах, амь насанд нь халдаж болзошгүй шүү дээ. Үйл баримтыг харчихсан хохирогчийг чинь эсвэл гэрчийг амь насанд нь халдаж болзошгүй байхгүй юу. Тэрийг хамгаалах зорилгоор нууцалдаг. Нөгөө талаар илрүүлэх зорилгоор мөрдөн шалгах ажиллагааны тактикийн асуудал байгаа юм. Тактикийн асуудал. Энэ тактикийг задруулах нь эсрэгээрээ гэмт хэргийг илрүүлэхэд садаа болдог. Тухайлбал иргэн Бадамжунайг барих гэж байгаа гээд л хэвлэлээр шүү зарлаад л, зарлаад л, нөгөөдөх нь хэвлэлээс олж мэдээд л 2 хоногийн дараа Замын-Үүдээр гараад зугтчихсан. Одоо энэ асуудлыг энэ 8 жилийн дараа 5 шүгэл ажиллагааны хүрээнд бөөн хүч, хөдөлмөр болж байж авчирч байна шүү дээ. Эндээс улбаалж хохирогч амь насаа алдаж байсан тохиолдлууд зөндөө байна. Хэрэг илрэхгүй болдог, замхардаг, төөрөлддөг, санаатай санаагүй. Тийм учраас энэ мөрдөн шалгах ажиллагаа гэдэг бол саяын ойлгож байгаа хүрээнд гэрч, хохирогчийн амь насыг хамгаалах, эрүүл мэндэд халдахаас сэргийлэх, хэргийг шуурхай илрүүлэх зорилгын хүрээнд тавигддаг ийм тусгай гэмт хэрэг байгаа гэдгийг та бүхэнд хэлье.

**Г.Занданшатар:** Норовын Алтанхуяг гишүүн тодруулж асууна.

**Н.Алтанхуяг:** Энэ би жаахан буруу, ойлгогдохгүй л яриад байх шиг байгаа юм. Хэн нэгэн хүн гэмт хэрэгт холбогдонгуут нь байцаалт юмаа аваад тэр байгууллагууд чинь ингээд мөрдөн шалгах үйл ажиллагааны нууцыг задруулахгүй шүү гээд байгаа байхгүй юу. Тэгээд юу нь нууц юм бол гэж би асуугаад, энэ нууц гэж байгаа юмаа ингээд зааглаад өг л дөө. Тэр Тэмүүжингийн үед бичсэн нууцлагдсан гэрч, нууц мөрдөн шалгах ажиллагааг явуулж цуглуулсан нотлох баримт нь л

нууц, бусад юм нь нууц биш гэдгийг ингэж зааж өг л дөө л гээд байгаа юм л даа. Сая тэр Хөгжлийн банкны хурал дээр би олон хүнтэй уулзаад юм ярихаар, нууц задруулж болохгүй гэсэн шүү дээ. Үгүй ээ, чи Засгийн газрын тогтоолын нууц гэж юу байдаг юм. Ил байгаа шүү дээ гэхээр болохгүй, ерөөсөө ингээд гар, хөлийн үсэг авчихсан шүү дээ. Одоо саяын хүн ярьж байна шүү дээ. Автобусны хэрэг дээр ганцаараа эсрэг санал өгсөн чинь одоо энэ нөхрийг нөгөө хэрэгт нь татчихсан учраас энэ хүн чинь хэвлэлийн хүн асуухаар болохгүй, би мөрдөн байцаалтын нууц задалсан хэрэгт орно гэсэн ийм л нөхцөл байдал байна гэж би хэлж байгаа.

**Г.Занданшатар:** Баттөмөрийн Энхбаяр гишүүн.

**Б.Энхбаяр:** Би Алтанхуяг гишүүнтэй бас санал нэг байгаа. Хэрвээ хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал дэмжих юм бол мэргэжлийн Байнгын хороо дээр Алтанхуяг гишүүний хөндөж байгаа асуудлаар бас тодотгох ийм хэрэгцээ шаардлага байгаа гэдэгтэй би санал нэгддэг. Яагаад гэхээр Үндсэн хуульд зааснаар хүн өөрөө өөрийгөө өмгөөлөх эрхтэй, хууль зүйн туслалцаа авах эрхтэй. Энэ нь юу хэлж байна вэ гэхээр тухайн хэрэгт шалгагдаж байгаа хүн өөрийнхөө гэм буруугүйг нотлох бас эрхтэй байхгүй юу. Гэм буруугүйгээ нотлох. Тэгэнгүүт тэр шалгаж байгаа хүнийг чи юу ч ярьж болохгүй гэдэг бол хэрэг дээрээ бас хонгилоор чирэх, өөрийгөө өмгөөлөх тэр үндсэн эрхийг зөрчиж байгаа ийм асуудал мөн. Би бол үүнтэй санал нийлдэг. Тийм учраас хуулийн байгууллагынхан нь болохоор тухайн хүний гэм буруутайг нотлох мэдээллийг л санаатай, санаагүй цацаад байдаг. Нөгөө хүн өөрийгөө гэм буруугүйг нотлох гээд ярих гэхээр чи хууль зөрчинө шүү, ялтай шүү гээд давхар яллаад байдаг бол буруу.

**Г.Занданшатар:** Одоо Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууна.

**О.Цогтгэрэл:** Эрүүгийн хуульд ялын бодлогыг чангатгах чиглэлээр 3 зүйлд багц зүйл рүү нэмэлт хийх гэж байгаа юм байна.

1 дүгээрт нь энэ хүүхдийн хүчирхийллийн эсрэг асуудлаар, дараа нь тэр согтуу жолоочийн асуудлаар, мөн мэдээж мөрдөн шалгах ажиллагааны нууц гээд ийм 3 багц асуудлаар. Эдгээрийг ингээд үзэхээр мэдээж нийгэм дээр нэлээн л хэлэлцүүлэг болсон. Үнэхээр бас энэ дээр авах арга хэмжээ, саяын орж ирж байгаа асуудлыг зарчмын хувьд бас харахаар үнэхээр дэмжихээс өөр аргагүй ийм нөхцөл байдал харагдаж байна. Гэхдээ энийг дэмжихийн тулд цаана нь бас тийм тодорхой үндэслэлүүд хэрэгтэй байх. Ер нь манай Монгол Улс өөрөө ялын бодлого хэр чанга, султай орон бэ. Дахиад дээрээс нь ялын бодлогыг чангатгахад нөгөө талд нь гэмт хэргийн гаралт буурдаг гэдэг яг ийм албан ёсны судалгаа, статистик байдаг уу. Энэ яг ямар хамааралтай вэ. Ялын бодлогыг л чангатгаад байвал нөгөө талд нь гэмт хэрэг буураад байдаг уу. Ер нь бид нар инг нийтээрээ ийм нийгмийн асуудлууд гарч ирэхээр ялын бодлого руу ордог. Энэ нь явсаар байгаад энэ улс орон нэг тийм эрүүдсэн, ялдсан орон болж бас хувирах тал руу алхах юм биш биз дээ гэдэг болгоомжлол байгаа учраас энийг асуугаад байгаа юм. Тэгэхээр 1 дүгээрт нь тэр саяын үнэхээр ял чангараад байхаар л нөгөө талд нь гэмт хэрэг буураад байдаг гэдэг тийм судалгаа, нотолгоо яг юун дээр байдаг вэ. Энийг нэг ийм онолын үндэслэлтэй талаас нь бас хэлж өгөөч. Тэгээд ер нь өөрөө манай ялын бодлогыг дэлхийн улс орнуудыг ангилсан, ялгасан, эрэмбэлсэн, ранкласан ийм зүйл байдаг уу. Манайх ер нь хаана нь явдаг юм.

2 дугаар хэсэг асуудал нь болохоор ер нь энэ цээрлүүлэх замаар ер нь тэгээд ял гэдэг чинь өөрөө гарсныг

цээрлүүлэхээсээ урьдаар энэ өөрөө бага гарах ёстой байх л даа. Урьдчилан сэргийлэх. Тэгэхээр энд урьдчилан сэргийлэх гэдэг асуудал гарна. Тэгэхээр цээрлүүлэх замаар урьдчилан сэргийлэхээс өөр ямар зүйл заалт энэ хуулиудад, одоо энэ өргөн барьж байгаа хуулиудад орсон бэ. Урьдчилан сэргийлэх, энэ угаасаа гэмт хэрэг гарчихсан хойно нь цээрлүүлэхээсээ гадна ер нь өмнө нь бага гарах чиглэлээр ялын бодлого чангатгахаас гадна өөр ямар бодлого чиглэл энд орсон бэ. Мөн тэгээд Хууль Хууль зүйн яамнаас барьж байгаа бодлого дээр энэ дээр ямар зүйл, заалтууд байна вэ. Ямар бодлогын шинэчлэл энэ дээр хийгдэх вэ буюу улс орныг ялжуулж, эрүүжүүлэлгүйгээр гэмт хэрэггүй, гэмт хэрэг багатай, тайван амгалан чиглэлд л энэ улс орон өөрчлөгдмөөр л байна шүү дээ. Тэгэхээр энэ чиглэлд юу хийгдэх вэ гэдэг ийм 2 л багц асуултад тодруулмаар байна.

**Г.Занданшатар:** Баттөмөрийн Энхбаяр Хууль зүй, дотоод хэргийн сайд хариулна.

**Б.Энхбаяр:** Би Цогтгэрэл гишүүний санаа чилээж байгаа асуудалтай санал нэг байдаг. Сэтгэл хөөрлөөр ялангуяа Эрүүгийн хуулийн ял шийтгэлийн бодлогод хандаж болохгүй гэдэгтэй би бол хатуу зарчим баримталдаг. Эрүүгийн хуульд энэ оруулж ирж байгаа асуудал дээр бол сэтгэл хөөрлөөр хандаагүй. Сошиал давллагаанд автаагүй. Тэр тусмаа Хууль зүйн сайдын хувьд бол энэ асуудалд зөвхөн судалгаа шинжилгээ, гэмт явдал судлалын үүднээс асуудалд хандсан. Манай улс 2002-2017 оны хооронд өөрөөр хэлбэл хуучин Эрүүгийн хуулиар бага насны хүүхдийн эсрэг ял шийтгэлийн бодлого чанга байсан.

Бага насны хүүхдийг хүчиндсэн, алсан гэмт хэрэгт шүүхээс оногдуулж байсан ялыг авч үзэхэд дунджаар 22 жил байсан. Өөрөөр хэлбэл энэ төрлийн гэмт хэрэг үйлдэж байсан хүмүүст 22 жил

шоронд хорих ял шийтгэдэг байсан байна. 2015 оны хуулиас хойш 2023 оны байдлаар би сая та бүхэнд танилцуулсан. Манай ялын бодлого өмнөх хуультай харьцуулахад суларчээ. Яах аргагүй. Ингээд 22 жилийн хорих ял ноогдуулж байсан этгээдүүд 10-15 жилийн шүүхээс ял ноогдуулдаг ийм болсон байна. Яг бага насны хүүхдийн хүчиндэх гэмт хэргийн тухайд энэ эрүүл хүнээс гарамгүй үйлдэл. Энэ өвчтэй хүн. Энэ бол манъяк байхгүй юу. Дахин давтан үйлдэгддэг өндөр магадлалтай. Сая хэлсэнчлэн 20 гаруй хувь нь дахин энэ гэмт хэргээ үйлддэг. Үүний нотолгоо юу вэ. Сая бид нар 7 хоног харамсалтай үйл явдлын дараа нийгмээрээ амьсгалж, олон эхчүүд, олон аавууд, олон ээж нар нойргүй хонолоо. Ний нуугүй хэлэхэд. Хамт хохирсон. Над руу нэг эх ярьсан. 2 хоног унтаж чадсангүй, миний бие муудаад байна. Энэ хүнийг алаад өгөөч ээ гэж хэлж байсан. Нийгмээрээ хохирсон. Энэ асуудлаар шуугьсан. Үр дүнд нь яг тэр 7 хоногт хүчиндэх гэмт хэрэг 78,9 хувиар огцом өссөн. Сая өнгөрсөн 7 хоногт хүчиндэх гэмт хэрэг харин 60 хувиар буурлаа. Би юу хэлэх гээд байна вэ гэхээр, бага насны хүүхдийн эсрэг гэмт хэргийн хохирогчдыг гаргах, энийг сурталчлах бол реалити шоу биш шүү гэдгийг би хатуу хэлээд байгаа юм. Та үнэхээр хайрлаж байгаа, үнэхээр үүнд эмзэглэж байгаа бол бага ярь. Үнэхээр. Яагаад гэвэл та дараагийн хохирогч болох тэр үйлийг дэврээхгүй байгаад тусалж байна гэсэн үг. Энэ өвчтэй хүмүүст сэдэл өгөөд байна. Тийм учраас энэ өвчтэй хүмүүсээс урьдчилан сэргийлэх хүрээнд бага насны хүүхдүүдээс ийм үйлддэг хэргүүд дээр хорих ялаас гарснаас нь дараа 50 хувьтай нь дүйцэхүйц цахим гав зүүнэ. Жишээлбэл бага насны хүүхдийг хүчиндээд, 20 жил шоронд ял эдэлсэн этгээд гарах юм бол 10 жил цахим гавтай явна дахиад. Тэр үйлдэгдсэн этгээдийг олон нийтэд зурагтай хөрөгтэй нь гаргаж сануулна. Энэ бол урьдчилан сэргийлэх бодлогын хүрээнд. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд хэд хэдэн өөрчлөлт оруулж байгаа. Тийм учраас

таны хэлсэн энэ ял шийтгэлийн бодлогыг ганцхан чангаруулах биш, урьдчилан сэргийлэх хүрээнд бодлого гаргаж ажиллана. Ер нь цагдаагийн байгууллага дээр миний хувьд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудлыг тэргүүн эгнээнд тавина гэсэн бодолтой байгаа.

**Г.Занданшатар:** Зочид танилцуулъя. Дараа нь Цогтгэрэл гишүүн тодруулж асууна. Парламентын боловсрол хөтөлбөрийн хүрээнд Нийслэлийн ерөнхий боловсролын Сант сургуулийн 7г ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Хүндэт сурагчид та бүхэнд сурлага, хөдөлмөрийн өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Одонгийн Цогтгэрэл гишүүн тодруулж асууна. Нэг минут.

**О.Цогтгэрэл:** Би түрүүн асуухдаа болохоор ялын бодлогын чангарал гэмт хэргийн бууралт 2-ын хооронд ямар харилцаа хамаарал байдаг вэ л гэж асуусан л даа. Тэгээд энэ дээр бас та дахиад нэг тодруулж өгөөч.

2 дугаарт нь энэ өргөн барьж байгаа энэ ялын бодлоготой холбоотой зүйл заалтуудын хажуугаар тэр урьдчилан сэргийлэх чиглэлийг нь байж болох тийм хатуу биш уян зохицуулалтуудыг илүү нэмж хамтдаа орж ирсэн бол илүү зохистой байлаа гэдэг үүднээс л би бас түрүүн саналаа хэлсэн юм шүү.

**Г.Занданшатар:** Баттөмөрийн Энхбаяр сайд. Уялдаа холбооны талаар.

**Б.Энхбаяр:** Тийм ээ. Ер нь урьдчилан сэргийлэх асуудал дээр одоо анхаарна. Жишээлбэл, Тамхины хуулийг анх баталж байхад энэ жсоохон хуурай хууль гарах нь, энэ чинь ингээж чангалж болдог юм уу гэдэг асуудал бас яригдаж байсан. Гэтэл энэ хууль маань бол урьдчилан сэргийлэх тамхины хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх үүргээ их

сайн биелүүлсэн. Хүмүүст дадал болдог юм байна лээ. Зөв зүйлийг хуулийн хатуу аргаар чангалаад, 5 жил бид тогтвортой мөрдөж чадвал энэ нийгэм хүмүүст зөв дадлыг бас төлөвшүүлнэ. Хуулийн үүрэг бол 2 аргатай шүү дээ. Манай Үндсэн хууль мэдэгтүн, сахигтун гэж дуусдаг. Яагаад гэвэл, Мэд гэдэг нь ухамсарлуулах гэж байна гэсэн үг. Өөрөө ойлгохгүй бол сахь гэдэг нь албадах гэж байна гэсэн үг. Тийм учраас Эрүүгийн хуульд энэ 2 арга.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Салдангийн Одонтуяа гишүүн.

**С.Одонтуяа:** Тэгэхээр хуулийн үзэл баримтлалыг бол дэмжиж байна. 2, 3 зүйл асууя. Бид бол энэ урьдчилан сэргийлэх дээр нэлээд анхаарья гэж ярьж байгаа. Одоо энэ урьдчилан сэргийлэх дээр онцгой анхаарахгүй бол энэ тоонууд бол үнэхээр аймшигтай байна л даа. Хохирогчдын тоо сүүлийн 3 жилд огцом өссөн. Энэ гэмт хэргийн улмаас хүүхэд хохирсон гэдэг дээр аймаар их тоонууд байгаа байхгүй юу. 2019 онд 481 гэмт хэргээс 169, ингээд гэмт хэргүүд явж байгаад 2022 онд 550 гэмт хэргээс 362 хүүхэд тус тус хохирчээ гэж. Ингээд энэ сүүлийн 3, 4 жилийг нэмэх юм бол энэ чинь хэдэн мянган хүүхэд хохирч байгаа байхгүй юу. Энэ чинь үнэхээрийн аюултай тоо. Тэгэхээр та манай бүлгийн хурал дээр орж ирэхдээ ярьж байсан шүү дээ. Бас зарим хүнд бол энэ ялын бодлого чангатгаад бас үйлчилдэггүй тийм хэсэг байдаг. Хүн гэмт тэрийг үйлдэж байхдаа энэ хуулийн заалтыг ч юм уу, ер нь ялын бодлогыг бодох сөхөөгүй тийм юу гэдэг юм сэтгэцийн өвчтэй ч юм уу, маньяк ч юм уу ийм хүмүүс байдаг гэж. Тэгэхээр энэ бусад орнуудад тэр бэлгийн хүчирхийлэл хийдэг хүмүүст зориулсан нэг ийм тариа хийдэг гэж байдаг. Жишээлэхэд Герман энийг хэрэглэдэг. АНУ зарим хүмүүст олон жил суугаад гарч ирсэн хүмүүст электрон гав энэ тэр зүүдэг. Тэгэхээр энэ чиглэлээр ер нь та судалж үзсэн үү. Одоо ингээд ерөөсөө

архинаас гардаггүй хүнд юу ч хэлээд нэмэргүй байгаад, гэтэл тэр архины эсрэг эмчилгээ хийдэг, тариа хийдэг, янз бүрийн арга байдаг. Кодолдог. Тэгээд тэр хүн бүр архи амсахаа больчихдог шүү дээ. Тэгэхээр тийм энэ төрлийн туршилагыг та судалж үзсэн үү. Энэ манай улсад ер нь энийг хэрэглэвэл тохиромжтой зүйл байна уу. Энэ тал дээр яам судалсан, үзсэн харсан юмаа хэлж өгөөч гэж хэлэх гэсэн юм.

Тэгээд урьдчилан сэргийлэх гээд бас чухал асуулт. Тэгэхээр энэ 2024 оны төсөвт чинь яг энэ бага насны хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дээр чинь ер нь төсөв хөрөнгүүд нь хэр тавигдсан юм бэ. Бид нар баахан хууль яриад л байдаг, хууль яриад л байдаг. Тэгээд л төсөвгүй энэ хууль чинь бүгдээрээ гацаад зогсчихдог шүү дээ. Тэгээд гэрч хохирогчийг хамгаалах чиглэлээр юу хийх юм бэ гээд ийм асуудлууд байгаа. Одоо тэр Монголхүү гээд залуу анх яагаад хэрэгт татагдсан юм бэ гэхээр ерөөсөө энэ Монгол Улсад чинь хүүхдийн эсрэг гэмт хэрэг маш их байна гээд тэр нас барсан хүүхдийн тоогоор гутлууд шуудайнд хийгээд талбай дээр аваачаад, хүмүүст үзүүлж, хүмүүсийг сэртхийлгээж, энэ чиглэлээр шийдвэр гаргах түвшнийхнийг л ажиллуулах гэж хэдэн гутал чирч яваад, сүүлдээ бүүр хэрэгтэн болоод, одоо тэгээд л гавтай ингээд л явж байгаа шүү дээ. Дөнгөж сая хэрэг нь дууссан. Тэгэхээр бид нар энэ чиглэлээр ерөөсөө ингээд ажиллахгүй, дэмжихгүй, үгээ хэлсэн хүмүүсийг ингэж барьж, хорьдог энэ асуудал чинь сүүлдээ ийм зүйл рүү бас даамжрахад хүргэж байгаа шүү дээ. Нийтээрээ энэ хүүхдийн эсрэг гэмт хэрэгт бид нар хүчин зүтгэх ёстой байгаа. Тэгэхээр энэ саяын миний асуусан тэр тариа, эм хэрэгсэл энийг судалж үзсэн үү.

**Г.Занданшатар:** Баттөмөрийн Энхбаяр сайд. Хууль зүй, дотоод хэргийн сайд хариулна.



**Б.Энхбаяр:** Энийг бас судалж үзсэн. Зарим улсуудад бол бас байна. Зарим хүмүүс ч бас ярьдаг. Өчигдөр бас Байнгын хорооны хуралдаан дээр Ганбат гишүүн ер нь тариа хийгээд заримыг нь огтлоод хаячихвал яасан юм эд нар гэсэн юмнууд бас ярьж байсан. Тэгэхээр Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 1-д хүнийг хүйсээр нь ялгаварлан гадуурхахыг хориглоно гэсэн ийм заалт байдаг. Энэ нь өөрөө юу гэсэн үг вэ гэхээр хүйсээр нь ял шийтгэлийн бодлого ялгамжтай байж бас болохгүй гэсэн үг. Бид 2015 оны Эрүүгийн хуулиар хүчиндэх гэмт хэргийн тухайд хохирогч нь аль ч хүйсийн хүн байж болно гээд хуульчилчихсан байгаа. Анх удаа. Урьд нь энд зөвхөн эмэгтэй хүнийг хохирогчоор тооцдог Улсын Дээд шүүхийн тайлбартай явж ирсэн. Эрэгтэй хүн, эрэгтэй хүүхэд хүчиндүүлбэл манай Эрүүгийн хуульд байхгүй байсан байхгүй юу. Бид нар ийм ялгамжтай, хүйсээр нь бүр ялгачихсан хуультай байсан. Ингээд 2015 оны Эрүүгийн хууль дээр аль ч хүйсийн хүн хохирогч байна гэдэг асуудлыг заагаад, ял шийтгэлийн бодлого дээр нь хүйсээр нь ялгасан ийм асуудлыг зохицуулаагүй. Тийм учраас энэ огтолж тайрахтай холбоотой асуудал дээр эрэгтэй хүүхдийг хүчиндсэн нөгөө эсрэг хүйсийн хүнийг яах юм бэ юуг нь гэдэг асуудал бас гарна. Тийм учраас Эрүүгийн хуулийн ялын бодлого дээр энэ өөрөө зарчим болохгүй. Өөрөөр хэлбэл Үндсэн хуулийн эх ундаргатай гэдгийг бас ойлгож хандахыг бас хүсье. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Салдангийн Одонтуяа гишүүн тодруулъя. 1 минут.

**С.Одонтуяа:** Тэгээд энэ Улсын Их Хурлын танхимд албаны хүмүүс энэ янз бүрийн юу гэдэг юм шог болгох гэж байгаад энэ янз бүрийн үг хэллэг хэрэглэмээргүй байна. Одоо тайрч майраад гэж. Би тэгж асуугаагүй шүү дээ. Одоо энийг чинь сошиал дээр сэвээд л эргээд ийм асуудал ярилаа гээд ингээд бичихийг үгүйсгэхгүй. Зүгээр хуулийн хэллэгээрээ л ярья. Би бол тэгсэн шүү

дээ. Бусад орнуудад ийм урьдчилан сэргийлдэг тэр бэлгийн дур хүслийг нь буулгадаг ийм эм тариа байдаг юм байна гэхэд тэгж хариулж бол хэрэггүй ээ. Илүү дутуу юманд ороогдохын нэмэр.

2 дугаарт би танд 1 албан бичиг явуулсан байгаа. Тэр бол нөгөө 3 настай хүүхдийг зодоод, тэр хүүхэд амь насаа алдаагүй, гэхдээ бараг үхсэнээс өөрцгүй маш хүнд байгаа. Тэгэхээр энэ зүйл дээр энэ ялын бодлого энэ хуульд орж ирж байгаа юу эсвэл зөвхөн бэлгийн хүчирхийлэл орж ирж байгаа юу.

**Г.Занданшатар:** 87. Ажлын хэсэг Эрдэм-Ундрах уу.

**Х.Эрдэм-Ундрах:** Одонтуяа гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсгийн гишүүн Эрдэм-Ундрах байна. Энэ талаар бид гадаад орнуудын харьцуулсан судалгааг хийж үзсэн байгаа. Тухайлбал АНУ, Их Британи, Канад, мөн Европын Холбооны орнуудыг судалж үзсэн. Азиас Солонгос орныг сонгон судалж үзсэн байгаа. Ялангуяа бага насны хүчирхийлэл үйлдэгч Фидофилууд гэж ярьдаг. Энэ төрлийн хүмүүс 1 дүгээрт ялын бодлого бол эдгээр улс орон бүрд маш чанга байгаа. Хамгийн хатуу ял шийтгэлийг оногдуулдаг ийм нийтлэг жишиг ажиглагдаж байна. Мөн хорих ял буюу бүх насаар хорих ял голдуу оногдуулдаг. Үүнээс гадна зарим улс орнуудад бэлгийн хүчирхийлэл үйлдэгчдийн тусгайлсан бүртгэлийг хөтөлдөг. Энэ бүртгэлийнхээ дагуу ял.../минут дуусаа/

**Г.Занданшатар:** Гүйцээгээд хариулчих. 87.

**Х.Эрдэм-Ундрах:** Энэ бүртгэгдсэн этгээдүүдийг бас дотор нь 1, 2, 3 дугаар шатлалын гэж ангилаад, ял эдэлж дууссанаас хойш хуульд заасан тодорхой хугацаагаар цахим гав зүүлгээж, хяналтдаа байлгадаг. Энийгээ бол хамгаалалтын арга хэмжээ гэж авч үздэг. Германд тухайлбал бүх насаар хорих ялаар шийтгүүлж дуусаад, 15

жилийн дараа жил тутам дахин тухайн этгээдийг магадлангаар оруулж, нийгэмд аюултай хэвээр байна гэж үзвэл үргэлжлүүлэн хорих бас хамгаалалтын арга хэмжээ авдаг гэх мэтчилэн ийм туршилага байна.

**Г.Занданшатар:** Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн.

**Ж.Бат-Эрдэнэ:** Энхбаяр сайдаас 2 асуулт байна. Энхбаяр сайд аа, энэ орж ирж байгаа хууль бол маш яаралтай ингээд сайхан засаад ороод ирж байгаа нь сайшаалтай байна. Энэ дээр хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой асуудал чинь алга харагдаад байх юм. Ер нь бол одоо жишээ нь бид нар мэдэж байгаа шүү дээ. Хөгжингүй орнуудад Америк, Япон, хаана ч байдаг юм. Өөрсдөө бид нар ярьж байдаг шүү дээ. Хүүхдүүддээ хэлэх үг үгүй болчихлоо гээд. Жоохон загначихаар цэцэрлэгийн багш нь дуудаад эсвэл 911 дуудчихлаа эд нар гээд байдаг шүү дээ. Тэгээд нөгөө хүүхдэдээ хэлэх үг үгүй болчихлоо гэдэг шиг гэр бүлийн хүчирхийллийн хүрээнд хүүхдүүдийг, эмэгтэйчүүдийг, эхчүүдийг хүчирхийлдэг энэ юм дээр ер нь ямархуу арга хэмжээ авах юм бэ. Энэ чинь бас нэг хэлбэр нь явж байгаа шүү дээ. Тэгээд энэ чинь ерөөсөө харагдахгүй байгаад байгаа юм. Ер нь нийгэм даяараа бол энийг ерөнхийдөө бид нар мэдээд байдаг. Тэр тусмаа нөгөө багийн дарга, хорооны дарга нар чинь энийгээ ерөнхийдөө мэдээд байдаг. Нэг удаа баривчилгаа хийгээд байдаг. Тэгээд буцаагаад авчирдаг. Нөгөөдөх нь улам заналхийлээд, улам дарамтлаад, хүчирхийлээд байдаг ийм асуудал дээр ер нь яах юм бэ. Бид нар энийг мэдээд л яваад байдаг, мэдээд л яваад байдаг. Тэгээд цаашаагаа өөгшүүлээд, тэгээд 1 өдөр л 1 хүн амины хэрэг гараад л, 1 хүчирхийлэл гараад л явчихдаг шүү дээ. Энийгээ гаргаж ирэхгүй юм уу гэсэн асуудал байна.

2 дугаарт нөгөө сая нийгмээр нэлээн л талцаж ярилаа л даа. Хэрвээ жоохон юм уучих юм бол тэгээд л

ерөөсөө шууд баривчлагдаад явчих юм байна. Ял аваад явах юм байна гээд. Ер нь яах вэ, энэ салбар дээр ажиллаж байсны хувьд бол яг архи уусан үедээ жолоо барих асуудал дээр нэлээн хатуу байж байгаад бид нар энэ чинь 2013, 2014 оноос эхлээд ер нь гайгүй болсон шүү дээ. Яагаад гэхээр шууд эрхийг нь хасаад явчихсан байхгүй юу. Тэгэнгүүт л эрхийг нь хассан нөгөө 30 хоногийн баривчилгаа ч билүү хийгээд явангуут л ерөөсөө огцом өөрчилсөн шүү дээ. Тэр хүртэл бид нар бүүр арга хэмжээ авах гээд барахгүй л явсан. Ер нь замын цагдаадаа өчнөөн арга хэмжээ аваад л байсан, яваад л байсан. Тийм болохоор энэ тал дээр ялын бодлого дээр жишээ нь жолоо барих гэдэг асуудал дээр бол жишээ нь миний хувьд яг салбарт ажиллаж байсны хувьд дэмжиж байгаа юм. Гэхдээ жоохон асуудал байгаад байгаа юм. Одоо жишээ нь хөдөө айргаа уучхаад давхиж байгаа малчдаа яах вэ. Бүгдийг нь аваачаад шууд суулгаад байх уу гэж. Тэгэхээр энэ дотор нэг зүйл харагдаад байх юм. Сogтууруулах үедээ жолоо барьсан эсхүл хөнгөн гэмт хэрэг бие организмд хөнгөн гэмт хэрэг учруулсан гэсэн ийм 2 зүйл байгаад байх юм. Тэгэхээр ерөөсөө миний санаа бол нэг удаа байх юм уу. Уучихсан байх юм бол энд нь шууд торгуулийн арга хэмжээ авдаг. Хөнгөн гэмт хэрэг учруулсан гэж байвал дараагийнхаа арга хэмжээ рүү. Ёстой тэр 6 сараас хэдэн сар, жил байдаг юм, эрхээ хасуулдаг ч байдаг юм уу. Эсвэл эрх хасахаас нь эхэлье л дээ. Ингээд зүгээр хөдөө хээр явж байгаад цагдаа тааралдаад айраг уучихсан явж байгаад мэдээж тэр айраг уучихсан жолооны ард суух ёсгүй л байхгүй юу даа. Тэр айргаас жишээ нь хэд гардаг юм. Тэрийг бас тодорхойлох хэрэгтэй байна. Тэгээд жоохон амсчхаад хөдөө хээр ч байдаг юм уу, хаана ч байдаг юм явж байгаад цагдаа тааралдаад, тэгээд тэр чигээрээ том арга хэмжээндээ орох юм уу, яах юм гэдэг шатлал байх хэрэгтэй юм шиг харагдаад байна. Тэгж байж бид нар шат шатад нь энийг чинь өөрөө сайжруулаад, чангаруулаад явах

арга хэмжээ, цааш цаашидаа бол хуулийн арга хэмжээ авах ёстой. Ер нь бол яг жолоо барих үедээ хүнд гэмт хэрэг үйлдсэн үү, хөнгөн гэмт хэрэг үйлдсэн үү, эсвэл яг зүгээр жолоо барихдаа архи уучихсан, согтууруулах ундаа хэрэглэсэн үү гэдэг 3 ангилал руу оруулбал яасан юм бэ гэсэн ийм санал байгаад байгаа юм. Тэгээд энэ дээр нэг хариулт өгөөч. Тэр бусад зүйлүүд нь бол ерөнхийдөө олон л зүйл байна л даа. Энд торгуулийн асуудлууд байх шиг байна. Энэ дээр нэг тодруулж өгөөч. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Баттөмөрийн Энхбаяр сайд хариулна.

**Б.Энхбаяр:** Өнгөрсөн 7 хоногийн даваа гарагт бол би 2 намын бүлэгт бас танилцуулсан. Ингээд 3 дахь өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд согтуурлын хэмжээн дээр бусад улс орны хууль тогтоомжид байгаа бас доод хэмжээг тавьж өгөх ёстой юм байна гэдэг асуудал яригдаад ингээд доод хэмжээ тавьсан байдлаар орж гэж байгаа. Бусад улс оронд бол цусанд гарч байгаа 0,5 промилл гэдгээр ихэнх улс орнуудын хэмжээ тавьчихсан байна. Энэ 0,5 промилл гэдэг нь 100гр цагаан архи, эс үгүй бол 200гр вино, шампанск, эсвэл эмэгтэй хүний тухайд 330 гр пиво, эрэгтэй хүний тухайд 0,5 литр пиво уувал гардаг хэмжээ байгаа. Өөрөөр хэлбэл саяын миний хэлсэн энэ хэмжээнээс дээшилбэл асуудалд орох нь байна л гэсэн үг. Гэмт хэрэгтэн болох нь байна шүү л гэдэг ийм хэмжээ. Тэгэхээр би бол яг айргийн градусыг сайн мэдэхгүй байна. Одоо Булганы айраг бол бас нэлээн намрын айраг бол ер нь л чанга байдаг шиг л би өөрөө хэрэглэж үзээгүй. Та сайн хэлэх байх даа. Булганыхан бол ер нь нэлээн хорио цээрт орох л байдалтай. Ер нь больё л гэж байгаа юм. Тээврийн хэрэгсэл жолооддоогоо л боль гэж байгаа юм. Яагаад гэхээр энэ таны асуудал биш, таны эрх чөлөөний асуудал биш. Бусад хүний эрүүл мэнд, аюулгүй байдалд хохирол учрах гэж байна л гэж үзээд байгаа байхгүй юу. Таны хэлсэн

ямар нэгэн бусдад хохирол учруулаагүй үйлдэлд бол саяын хэмжээгээр гэмт хэрэг болно. Ингээд согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодоод бусдын бие махбодод хөнгөн гэмтэл учруулах, хүндэвтэр гэмтэл учруулах, хүнд гэмтэл учруулах, энэ үйлдлийн улмаас бусдын амь нас хохирох, 1-ээс дээш хүний амь нас хохирох гэсэн ийм 5 шатлалтайгаар ялын бодлого нь чангарч явна. Мөн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасах нь саяын 5 шатлалаар бас чангарч явна. Тухайлбал согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсоны улмаас бусдын амь нас хохирох юм бол тухайн хүний тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг бүх насаар нь хязгаарлана. Хүнд гэмтэл учруулбал 5-8 жилийн хугацаагаар жолоодох эрхийг нэмж хасна гэсэн ийм шатлалтай байдлаар холбогдох хуулийн төслийг оруулж ирсэн байгаа.

Мэдээж бид бол бас бодож үзсэн юм. Хөдөө орон нутгийн тухайд, хот суурин газрын тухайд энэ ял шийтгэлийн бодлогыг ялгамжтай зохицуулж болох уу, үгүй юү гэж. Гэтэл хууль бол тэгж гардаггүй. Хууль бол Монгол Улсын хууль гэж л гарна. Монгол Улсын хууль бол хөдөө юм уу, хот байхаас үл хамаарч яг адилхан үйлчилнэ. Ийм асуудал бол байдаг. Манайх бол нэгдмэл улс байдаг. Тийм учраас ер нь энэ асуудал дээр ер нь эвлэрэхгүй байя. Энэ буруу зурилаа дээрээсээ эхлээд үлгэрлээд ер нь манлайлаад явъя. Яагаад гэхээр үүний хохирогчид нь хүн, хүүхдүүд байна гэдгийг л хэлээд байгаа юм. Би ч гэсэн өөрөө ... энийг ч яриад яах вэ дээ.

**Г.Занданшатар:** Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя. 1 минут.

**Ж.Бат-Эрдэнэ:** Та нэлээн өндөр түвшиний хуульч байх. Би бас уг нь хуулийн сургууль төгссөн л юм. Тэгээд мэтгэлцээн хийж байгаа юм шиг айхтар том том гүн ухаанд хэдүүлээ ярьж яах вэ. 2 асуудал дээр байна.

*1 дүгээрт орон нутгийн хэмжээнд үзэх хэрэгтэй, үзэх хэрэгтэй шүү. Бид нар зүгээр тэнгэрээс бууж ирсэн аятай иймэрхүү зан үйлдэл бас гаргаж болохгүй ээ. Бид орон нутаг дээр ямар байдаг билээ. Тэгээд магадгүй зүгээр би хэлээд байгаа шүү дээ. Зүгээр энэ дотор чинь согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ жолоо барих эсвэл хүнд, хөнгөн хохирол учруулсан гэж 2-ыг чинь нийтлэгдчихээд байгаа байхгүй юу даа. Тэгэхээр жолоо барьсан үед нь тодорхой хэмжээний нэг санхүүгийн, өшөө бүүр жолоо бариад, тэгээд хүнд гэмтэл учруулсан. Хөнгөн байна уу, хүнд байна уу гэмтэл учруулсан дараагийн санхүүгийн байх ёстой шүү. Энийгээ салгаж өгөөрэй. Болохгүй бол энийг тэр ажлын хэсэг дээр орж байгаад бас.../минут дуусав/*

**Г.Занданиатар:** Баттөмөрийн Энхбаяр сайд хариулна. Та бас нэг юм дутуу хэлчихсэн билүү. Ганибалын Амартүвшин гишүүн асуулт асууя.

**Г.Амартүвшин:** Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт орж ирж байна. Ер нь бол ерөнхийд нь бол дэмжиж байна. Ялангуяа бага насны хүүхдийг алах, хүчирхийлэх энэ гэмт хэргийг хүнд санхүүгийн болгох нь маш зөв. Энийг бол цагаа олж орж ирж байна гэж бодож байна. Согтуу жолоочтой холбоотой би сая Бат-Эрдэнэ гишүүний хэлж байгаатай бас тодорхой хэмжээгээр санал нийлэх гээд байна л даа. Санхүүгийн торгууль, мөнгөн хэмжээг нь илүү өндөр тавимаар байна. Анх удаа үйлдэж байгаа хүнд бас мэдрүүлэх хөшүүрэг нь байх ёстой. Давтан үйлдэх юм бол ёстой жинхэнэ эрхийг нь бүх насаар нь жолоодох эрхийг нь хасаад, тэгээд осол гаргаж хүний амь насанд аюул учруулсан юм байвал хорих нь зөв байх. Жоохон ялгамжтай ял шийтгэл оногдуулах нь зөв байх л гэж би бодоод байна л даа  
Ер нь бол логикийн хувьд бол зөв. Яагаад гэвэл юу гэдэг юм 100 татчихаад 1 жилийн ял авах уу, 20 мянгаар дуудлагын жолооч дуудах уу л гэдэг сонголт хийх юм байна шүү дээ. Тэгэхээр энэ дээр

*хэдүүлээ бас нөгөө талаас урьд шөнө найз нөхөдтэйгөө гараад архи уучихдаг, маргааш өглөө нь гарч явж байгаад үнэртүүлээд нөгөөдөх нь улаан гэрэл асдаг. Тэгэхээр энэ яах вэ. Бас согтуугаар машин тээврийн хэрэгсэл жолоодож хорих ял сонсох тийм эрсдэл орж байгаа юу. Өөрөөр хэлбэл амьсгалын спиртийн агууламжийн хэмжээтэй уялдах юм уу. Энэ дээр яаж арай өөр санхүүгийн байх боломж байгаа юм. Энийг бас тодруулж өгөөч ээ.*

*Мөрдөн шалгах ажиллагааны нууц, яг нууц гэдэг чинь яг юу юм бэ гэдгийг бас илүү тодорхой болгомоор байна л даа. Хөгжлийн банкны хэрэг дээр тэгсэн шүү дээ. Бид нар чинь гарын үсэг зурж байгаа юм. Энэ хэрэгтэй холбоотой ямар нэгэн мэдээллийг гадагшаа гаргахгүй гэж энэ дээр баталгаа өгч байгаа. Гэтэл хэвлэлийнхэн мэдээллийг нь авчихсан байдаг. Гүйж ирээд л бүгд асуудаг. Би өөрийгөө хамгаалж, өмгөөлж юм ярья гэхээр боломжгүй байдаг. Дээрээс нь Хөгжлийн банкны удирдлагууд нь өөрсдөө мэдээд л хэвлэлийнхэн нууцаар нь гаргаад тавиад өгчихдөг. Тэгээд, яг үнэндээ хэлэхэд бол энэ дээр буланд шахагдаж байгаа байхгүй юу. Өөрийгөө хамгаалмаар байдаг. Юм хэлж болдоггүй. Жишээлбэл ямар мэдээлэл нь нууц байх юм гэдэг нь бол чухал байгаа байхгүй юу. Намайг чинь тэр нөгөө гишүүнтэй хамт ийш тийшээ аялсан, барьсан, яасан гээд л янз бүрийн байдлаар л хэлээд байсан. Яг шүүх хурал дээр очихоор тэгээд тэр нь нотлогдохгүй л болж байгаа байхгүй юу. Тэрнээс гадна шүүх хурал эхлэхээс өмнө зарим хэвлэл мэдээллийн сайтуудаар тэгээд энэ хэргийн бүр нарийн мэдээлэл нь гарчихсан, сайтуудаар нь явж байсан шүү дээ. Нөгөө яллагдагчаар татах тогтоол, тэрний бүх дүгнэлт, бүх юмны мэдээлэл нь гарчихсан байдаг. Тэгэхээр энэ орж ирж байгаа өөрчлөлт чинь бол хүчин төгөлдөр үйлчилж байгаа заалт биз дээ Энхбаяр сайд аа. Гэтэл яг энэ санхүүгийн өмнө нь ямар нэгэн ял шийтгэл авч байсан тохиолдол байсан юм уу. Яг*

энэ мөрдөн шалгах үйл ажиллагаанд оролцож байсан хүмүүст тийм ял шийтгэл оногдуулж байсан тохиолдол байсан юм уу, үгүй юм уу. Тэгэхээр энэ нууц гэдэг ямар материал, ямар мэдээлэл нь нууц байх юм гэдэг дээр илүү тодорхой баймаар байна л гэж хэлэх гээд байна л даа. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Ажлын хэсэг хариулъя. Хэн хариулах юм. Цолмон хариулъя. Нямдаваа хариулах уу. 86.

**Ц.Чинзориг:** Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчил нийт 2022 онд 54924 бүртгэгдсэн. 2023 оны эхний 9 сарын байдлаар нийт 33788 зөрчил өнөөдрийн байдлаар бүртгэгдсэн байгаа. Үүнээс Нийслэлд 16478, орон нутагт 17310 зөрчил буюу нийслэлээсээ бол орон нутаг нь илүү зөрчил бас гарсан, бүртгэгдсэн дүн мэдээ гарсан байгаа.

**Г.Занданшатар:** 87. Эрдэм-Ундрах Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал.

**Х.Эрдэм-Ундрах:** Өргөн мэдүүлсэн төсөл дээр энийг шатлалтайгаар оруулсан байгаа. Анх удаагаа согтууруулах ундаа болон мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон бол торгуулийн хэмжээ 450-аас 2700 нэгжээр торгохоор байгаа. Энийг дахин үйлдсэн бол гээд 27.10.2 дахь хэсэг дээр торгуулийн хэмжээг 3 дахин нэмэгдүүлэхээр оруулж ирсэн. 1350 нэгжээс 10 мянга хүртэлх нэгжээр торгоно гээд. Мөн энэ гэмт хэргийн улмаас бусдын биед хүндэвтэр гэмтэл учирвал болон хүнд гэмтэл учирвал тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 8 хүртэл жилээр хасах, 1 жилээс 3 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгүүлэхээр байгаа. Мөн энэ гэмт хэргийн улмаас 2 буюу түүнээс олон хүний амь нас хохирсон тохиолдолд тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг бүх насаар нь хасаж, 2 жилээс 8 жил

хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр төсөлд тусгасан байгаа.

**Г.Занданшатар:** Ганибалын Амартүвшин гишүүн тодруулж асууя. 1 минут.

**Г.Амартүвшин:** Мөрдөн шалгах ажиллагааны нууцтай холбоотой асуулт асуусан. Яг ямар мэдээлэл нь нууц байгаад энийг илүү тодорхой болгох шаардлагатай байна гэж би хэлсэн. Согтуу жолоочийн хувьд болохоор урьд шөнө архи уучаад маргааш нь үнэртүүлээд нөгөөдөх нь ногоон биш улаан асаад энэ чинь тэгээд согтуугаараа тээврийн хэрэгсэл жолоодсон болох уу. Энийг яаж ялгаж салгах вэ.

**Г.Занданшатар:** 89. Дэмбэрэлцэрэнгийн Мөнх-Эрдэнэ Хууль зүй, дотоод хэргийн сайдын зөвлөх хариулна.

**Д.Мөнх-Эрдэнэ:** Амартүвшин гишүүний асуултад хариулъя. Энэ мөрдөн байцаалтын нууцтай холбоотой асуудлаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 29.3 дугаар зүйл дээр маш тодорхой заасан байдаг. Энд бол 29 дүгээр зүйлийн 29.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт бол хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын төлөвлөлт, явц, үр дүнгийн нууцлал, нөгөө талаас мөрдөн байцаалтын явцад олж мэдсэн төрийн болон албаны нууц, хүний эмзэг мэдээллийг задруулахгүй байх, холбогдох баримт бичгийг хамгаалах гэж ингэж тодорхойлж бичсэн байдаг. Энэ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль бол сая энэ материаллаг хуулийн түрүүний мөрдөн байцаалтын үйл ажиллагаанд нууцлалыг хангахтай холбоотой харилцааг яг процессын хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрхэн хэрэгжүүлэх вэ гэдгийг тодорхойлж байгаа хуулийн зохицуулалт.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асуулт асууна.

**М.Оюунчимэг:** Ямар ч байсан зайлиггүй хэлэлцэх ёстой хуулийг цаг хугацаа шуурхайгаар оруулж ирж байна. Тэгээд мэдээж хэлэлцэх ёстой гэсэн байр суурьтай байгаа. Гэхдээ энэ дээр бас бид нар тодорхой маш сайн дүгнэлтүүд хийж байгаад судалгаа шинжлэх ухааны үндэслэлтэй асуудалд хандах нь зөв болов уу гэсэн би бодолтой байгаа. Энэ дээр яагаад хүүхдийн хүчирхийлэл харгис хэрцгийгээр, эсвэл хүүхдийг хүчирхийлсэн энэ үйлдэл дахин давтагдаад байгаа шалтгаан гэдэг дээр нэг зүйл бичсэн байна л даа. Бага насны хүүхдийг алах, хүчиндэх, бэлгийн мөлжлөг, гэмт хэрэг үйлдэж шүүхээс нөгөө оногдуулсан хорих ялыг биечлэн эдэлж байгаа хүнийг засарч хүмүүжээгүй байхад нь гаргасан. Энэ дээр цагдаагийн байгууллага бас хяналтаа сул тавьснаас энэ төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцөл болж байгаа нь цөөнгүй тохиолдол байна гэсэн байна л даа. Тэгээд эндээс би бас цагдаагийн хүмүүс байна, прокуророос байж байна. Яг ийм тохиолдлууд байгаа юм болов уу. Ер нь хүүхэд хүчиндээд хүүхдийн амь насанд хүрсэн хүн засарч хүмүүжнэ гэдэг ер нь байхгүй шүү дээ бараг. Тохиолдлуудыг хараад байхад яг тийм хүүхдийг хэрцгийгээр хүчирхийлсэн хүмүүс гарч ирээд дахиад энэ хэргээ үйлдсэн тохиолдлууд л ер нь давамгайлаад байна шүү дээ. Яагаад гэвэл энэ өөрөө бараг сэтгэцийн өвчин болоод байна гээд яриад байгаа шүү дээ. Тэгэхээр энэ дээр тэгж өмнө нь суллагдаад гарч ирээд саяын тохиолдол байна шүү дээ. Хүчиндсэн, хугацаанаас өмнө гарсан, дахиад энэ хүчингийн маш ноцтой амь насанд нь халдсан ийм аймшигтай хэрэг гараад л, бид өнөөдөр энэ хуулиа илүү аймар чангатгах түвшинд яриад сууж байна л даа. Тэгэхээр яг ийм асуудал байна уу. Энэ дээр цагдаагийн байгууллагаас хүмүүс байвал хэлж өгөөч ээ.

Ер нь бол ингэж хүүхдийн амь насанд хүртэл хүчирхийлэл гэмт хэрэг үйлдсэн хүнийг бүх насаар нь хорих ялыг шууд л өгөх ёстой. Тэрнээс энийг урьдчилаад магадлангаар гаргах ч юм уу, эсвэл нөхцөл байдлаас нь шалтгаалаад 20, 25 жил гээд л тоо тогтоогоод байх нь өөрөө асуудлыг улам л хүндрүүлээд байгаа юм биш үү. Хүүхэд хүчиндэж амь насанд хүрсэн л бол энэ хүн бүх насаараа хоригдох юм байна л гэдэг тэр ойлголт нь нийтэд нэг тодорхой байж байвал нэн чухал байна. Тэгэхээр энэ дээр хариулт өгөхийг би энэ хүсэж байна.

2-т нь ер нь бусад улс орон тэгдэг шүү дээ. Тэр хүн нөхцөл байдлаас нь шалтгаалаад 20 жилийн дараа, 25 жилээр гарч ирлээ гэхэд ёстой нөгөө цахим гавыг нь зүүгээд энэ бол хүүхэд хүчирхийлэгч гэдгийг нь бүр зурагтай нь энэ тэндгүй наагаад хүн бүхэн мэддэг, хүн бүхэн болгоомжилдог. Нөгөө хүүхдийн эрхийн байцаагч нь хүртэл энэ хүн хүүхэд хүчирхийлэгч шүү гэдгийг тэр хороо, дүүрэг бүгд мэдэж байдаг ийм зарчмаар хуульдаа бас тодорхой заагаад явчихвал ямар вэ. Энэ дээр хариулт хүсэж байна.

2 дахь зүйл нь сая хэлж байна л даа. Анх удаа согтуугаараа хэрэг үйлдвэл арай хөнгөн, 2 дахь удаагаа ингэвэл гээд. Анх удаа согтуугаар үйлдээд тэр хүний амь хөнөөчихвөл яах вэ. Ер нь согтуугаар машин барьж болохгүй юм байна гэдэг тэр сурталчилгаа, судалгаагаа л сайн хийгээд, анхнаасаа тийм ойлголттой болчихгүй бол хүн эрүүл байхдаа би дуудлагын жолооч дуудах уу, эсвэл машинаа өөрөө согтуугаар барьж явж байгаад жилийн ийм юм авах уу гээд бодохгүй шүү дээ. Санаандгүй байж байгаад л уугаад л бага ч бай, их ч бай уугаад л согтуу л бол тэгээд л хүн контролоо алдахад л мэдээж ойлгомжтой. Тэгэхээр анхнаасаа л би ууж болохгүй юм байна. Эсвэл бүр анхных нь тохиолдол байлаа ч гэсэн бүх насаараа тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй болох юм байна ч гэдэг

юм уу. Анхнаасаа тодорхой хатуу заалтаа оруулаад өгчихгүй бол хорих гээд л 2 жил, 3 жил, 5 жил гээд л байна. Энэ чинь өөрөө үр дүн өгөх үү, үгүй юу. Та бүхэн маань хууль хүчний байгууллагынхан яг энэ асуудлыг мэдэж байгаа хүмүүс та нарт ингэж чангатгаад үр дүн өгөх үү. Ийм статистик тоо судалгаа байгаа юу. Ер нь бол анхнаасаа л болохгүй гэдгийг нь л хийгээд л, тэр судалгааг нь хийгээд явчихвал ямар вэ гэж энд бас хариулт авахыг хүсэж байна.

3 дахь зүйл нь Энхбаяр сайдаас асуумаар байна. Энэ нөгөө нууц задруулгатай холбоотой таны бас нэг айхтар юу яваад байна л даа. Бүхэл бүтэн ийм цагдаа хүчний байгууллага дотор бүр ийм сүлжээ үүсчихсэн. Мэдээгээ цацдаг. Тэр нь өөрөө.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Эхлээд Баттөмөрийн Энхбаяр сайд хариулна. Дараа нь эхний 3 асуултад ажлын хэсэг бэлдэж байгаарай.

**Б.Энхбаяр:** Оюунчимэг гишүүний асуултад би бүгдэд нь хариулчихъя. Хүүхдийн хүчирхийлэлтэй бол ганцхан эрүүгийн ял шийтгэлийн бодлогоор тэмцээд үр дүн гарахгүй. Хүүхдийн хүчирхийллийн гэмт хэрэг нэмэгдээд байгаагийн шалтгаан нь цагдаа бол биш шүү. Муу л бол цагдаа гэдэг шиг, ер нь цагдаагаас болоод бараг энэ хүчирхийлэл нэмэгдээд байгаа гэдэгтэй би харин эвлэрэхгүй. Энэ цагдаагийн ганцхан ажил биш. Энэ бол томчууд бүгдийнх нь үүрэг. Хүчирхийлэл нэмэгдэж байгаа, хүүхдээ хайрлахгүй байгаа асуудал дээр хүн бүр өөрөө өөртөө дүгнэлт хийх ёстой. Бид ер нь хүүхдүүдээ тоглох орчин хэр үлдээсэн юм. Гадаа тоглох тоглоомын талбай байхгүй, орчин байхгүй. Бид хүүхдүүдээ ер нь хэр хайрласан юм. Хүүхдийн гэсэн бүх юмаа хувьчилчихсан шүү дээ. Хүүхдийн гэсэн. Ганц хүүхдийн паркаа яасан, байшин бариад л байж байна. Сургууль, цэцэрлэгийн хүртээмж

байхгүй. Энэ асуудлыг бол хүн болгон дор бүрнээ бодох ёстой. Хүүхдээ өөрөө хэр үлгэрлэсэн юм ер нь. Эцэг эхчүүд хэр манлайлав. Хүүхдийгээ та сайн хүн болгохын тухайд нөгөө Эммануэль Кантын асуудал байдаг байхгүй юу. Ёс суртахуунтай хүн гэж хэнийг хэлэх вэ гэж. Эммануэль Кант чинь багш хүн шүү дээ. Оюутнуудаасаа асуусан юм. Хүүхдээ хайрлаж байгаа хүнийг хэлэх үү гэж. Жинхэнэ ёс суртахуунтай хүн гэдэг бол хүүхдээ зөв хүн, сайн хүн болгохын тухайд ухамсартайгаар хүмүүжүүлж байгаа тэр хүнийг хэлнэ гэж хэлсэн байдаг байхгүй юу. Тэрнээс өөрийн хүүхэд учраас гэмт хэрэгтэн болсон ч тэр хайрлаж байгаа хайр бол Эрик Фромын хэлснээр энэ бол ухамсаргүй хайр. Хүн алчихсан байсан хүнийг ч эх хүн хайрлаад л байдаг шүү дээ. Тийм учраас бүх томчууд энэ асуудал дээр ухамсартайгаар хүүхдээ хүмүүжүүлэх дээр өөрөө үлгэрлэж, манлайлж ийм үүрэг хүлээх, хариуцлага хүлээх шаардлагатай. Тийм ч агуулгаар яг үүний дараа Хүүхэд хамгааллын тухай хуулийг бид хэлэлцэнэ. Ирэх 7 хоногт Гэр бүлийн тухай хуулийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэнэ. Энэ асуудал дээр эцэг эхийн хүлээх үүрэг юу вэ. Өнөөдөр би шүүхийн шийдвэрийн лавлагаа авахад л хүүхдийн тэтгэмжээ төлдөггүй шүүхийн шийдвэр гарчхаад байхад 50% нь төлдөггүй гэж байна шүү дээ. Энэ хайр мөн үү. Тийм учраас хүүхдийн тэтгэмжээ төлдөггүй энэ эцэг эхчүүдийг төлүүлэх дээр би бол бодлогын арга хэмжээ авна гэж бодож байгаа. Гэр бүлийн хууль дээр ч гэсэн энэ асуудал дээр нэлээн хатуу механизмуудыг оруулж ирнэ гэсэн бодолтой байгаа.

Ер нь засарч хүмүүжнэ ч гэж байхгүй ээ. Манай хуулиар бол ийм бага насны хүүхдийг хүчиндсэн эсэх дээр эрүүл эсэхийг үзээд ер нь албадан эмчилгээнд хамруулдаг юм. Угаасаа хуульд байгаа албадан эмчилгээ гээд. Энэ албадан эмчилгээнд хамрагдаад өвчин нь илаарьшсан хүн тохиолдол бол бараг байхгүй. Тэгэхээр энэ өөрөө давтагдах

аюултай ийм төрөл байдаг учраас тэгээд л нэгэнт ийм сэтгэцийн хувьд үнэхээр асуудалтай хүнийг бол тэгээд л дангинатал цоожлоод л гаргахгүй байхаас өөр арга байхгүй. Яг энэ бодлогоор бол эрүүгийн.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Оюунчимэг гишүүн тодруулах юм уу. Тодруулъя 1 минут.

**М.Оюунчимэг:** Хүүхэд хамгааллын асуудал бүх нийтийн асуудал гэдгийг бид бүгдээрээ мэдэж байгаа. Тийм учраас энийг бид нар энд ярих биш, харин дахин дахин давтагдаад байгаа шалтгаан 78% нь гэр бүлийн хүрээнд болоод байгаа учраас ингэж чангатгаад бид нар цаашидаа яаж заалт хийх юм бэ. Тэр нөгөө цахим гаваа зүүгээд явах юм уу гээд би тодорхой заалтыг 1 дүгээрт асууж байна л даа. Энэ чинь өөрөө гэмт хэрэг болоод байна шүү дээ.

2-т тэр согтуугаар жолоодохтой холбоотой би яг салбарын хүмүүсээс нь мэдээлэл асуулаа. Тэгээд энд байж байгаа. Яг түрүүн Энхбаяр сайдын нэг зүйлтэй би санал нэг байна. Ганц цагдаагийн байгууллагаас болоод хүүхэд хамгааллын асуудал ингээд байгаа юм биш шүү дээ. Үнэн хэрэгтээ Хууль зүй, дотоод хэргийн яам тэр нөгөө хороо дүүрэг дээр жинхэнэ цагдаа нар маань хөөрхий үнэхээр сайн ажилладгийг мэднэ. Гэхдээ энэ дээр та нар үндэслэлээ ингээд л оруулаад ирэхээр энэ чинь өөрөө сөрөг нөлөөлөл үзүүлээд явчихна шүү дээ. Энэ дээр тэгэхээр бид нар гаргахгүй байх ийм ийм заалтууд орж байгаа, гэхдээ ингэлээ гэ гээд үр дүнд хүрэх үү, хүрэхгүй юу. Бид илүү энэ дээр нь хууль, ажлын хэсэг гарахдаа анхаарах хэрэгтэй байна гэсэн энэ салбарын хүмүүсийн саналыг би сонсох гэсэн юм.

**С.Одонтуяа:** Хэн хариулах вэ. Микрофоныхоо юуг өргөчих. Ажлын хэсэг хариулаарай.

**Л.Нямдаваа:** Гишүүний асуултад хариулъя. Нямдаваа. Түрүүн бага насны

хүүхдийг хүчиндсэн этгээдээс эргээд хэд нь гэмт хэрэг үйлдсэн бэ гэдэг асуулт асуусан. Ер нь бол сүүлийн 10 жилийн байдлаар 14-өөс дээш насанд хүрсэн хүний эсрэг хорих ял эдлэгдээд...

**С.Одонтуяа:** 89. Мөнх-Эрдэнэ.

**Д.Мөнх-Эрдэнэ:** Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Яг таны асуусан энэ асуултын хүрээнд бид гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд тодорхой зохицуулалт оруулж ирсэн. Өөрөөр хэлбэл бага насны хүүхдийн эсрэг хүнд гэм тэрэг үйлдсэн этгээдүүд суллагдсанаас хойш бид цахим гав зүүлгэх энэ зохицуулалтыг оруулж ирсэн байгаа. Өөрөөр хэлбэл энэ бол гэмт хэрэг дахин үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэглэж байгаа. Энэ бусад өндөр хөгжилтэй орнуудын энэ чиглэлээр сайн туршилагыг судалсны үндсэн дээр харьцуулан судалсны үндсэн дээр энэ зохицуулалтыг оруулж ирж байгаа. Тэгээд манай эрүүгийн хууль тогтоомжид бол энэ цахим гавыг хэрэглэхтэй холбоотой зохицуулалт туршигдаад, хэрэглэгдээд амжилттай явж байгаа учраас бид энэ зохицуулалтыг оруулж ирж байгаа.

**С.Одонтуяа:** Согтууруулах ундаа дээр тодорхой хариулт өгчих. 89. Мөнх-Эрдэнэ. Сайдын зөвлөх.

**Д.Мөнх-Эрдэнэ:** Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Эрүүгийн хуулийн 27.10 дугаар зүйл. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих энэ зүйл анги дээр бид тээврийн хэрэгсэл согтуугаар жолоодсон, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэсэн үедээ жолоодсон энэ тохиолдлуудад бол сонгох санкцтайгаар хариуцлага хүлээлгэх зохицуулалт оруулж ирсэн байгаа. Мөн цаашиа энэ гэмт хэргийг дахин үйлдсэн тохиолдолд, дахин үйлдсэн тохиолдолд энэ санкцыг мөн чангаруулна. энэ гэмт хэргийн улмаас хүндэвтэр гэмт хэрэг учирсан, хүний амь нас хохирсон



тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг шатлалтайгаар оруулж ирсэн байгаа гэдгийг хэлье.

**С.Одонтуяа:** Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн асуултаа асууна.

**Д.Тогтохсүрэн:** Баярлалаа. Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл орж ирж байгаа. Нуулийн төслийг бол ерөнхийд нь дэмжиж байгаа юм. Ер нь бас энэ нийгэмд болж байгаа үйл явдалтай холбогдуулаад цаг үеийн нөхцөл байдалтай нь уялдуулаад орж ирж байгаа учраас энэ хуулийн төслийг дэмжиж байгаа юм. Энэ бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэгт оногдуулж байгаа ялыг чангатгая гэдэг л гол ийм зүйл нэгдэх гол зүйл нь энэ байгаа юм. Тэгэхээр энэ чангатгах нь бол зөв. Ийм арга хэмжээ авах ёстой болчихоод байгаа юм. Нөгөө талаас нь хамгийн гол нь үндсэн шалтгаантай холбоотой асуудал байгаа юм. Ерөөсөө энэ бага насны хүүхдийн гэмт хэрэгтэй холбоотой асуудал чинь бол 3 үндсэн шалтгаан л байгаа юм.

1 дүгээрт нь гэр бүл салалт, 2 дахь нь архидалт, 3 дахь нь хүүхдэдээ тавих анхаарал халамж байхгүй 3-аас л болж байгаа асуудал байхгүй юу. Тэгээд бид нар өөр юмнаас үндсэн шалтгаанаа хайгаад яваад байдаг байхгүй юу. Нийгмийн ажилтан байхгүйгээс боллоо, гудмын гэрэлтүүлэггүйгээс боллоо, такси үйлчилгээ муугаас боллоо гээд яах вэ энэ шалтгаан байгаа. Гэхдээ нөгөө үндсэн гол сэдэв чинь гэр бүлийн орчинд нийт гэмт хэргийн 70 хувь үйлдэгдэж байна гэж статистик нь гарчхаад байхад тэр рүүгээ чиглэснээс илүүтэйгээр өөр чиглэл рүү юм нь яваад байгаа байхгүй юу. Ингэхээр л бид нар буруу болдог байхгүй юу. Тийм учраас бол би Энхбаяр сайдаас асуух гэж байгаа юм. Эрүүгийн хуульд эцэг эхийн хариуцлагын тухай асуудал байна уу. Жишээлбэл тэр дагавар хүүхдийн асуудал байдаг. Нийгэмд хамгийн их өртөж байгаа хүүхдүүд эд нар. Гэтэл энийг хамгаалах үүрэг

хүлээчихсэн нөгөө эцэг нь юм уу, эх нь юм уу тэр нь яагаад үүргээ гүйцэтгэдэггүй юм бэ. Тийм учраас эцэг эхийн хариуцлагын асуудал үнэхээр хамгийн том асуудал байх ёстой гэж би 1 дүгээрт нь бодож байгаа юм.

2 дугаарт нь 0-16 насных байгаа юм. 14 насыг 16 болгосон. Гэтэл өнөөдөр нөгөө нийгмийн байдал маань жаахан өөр болоод байна. Энийг хэрхэн судалсан бол гэдэг асуудлыг би асуух гээд байгаа юм. Бодвол энэ дотор Үндэсний хүрээлэнгийн захирал эд нар байна лээ. Хууль зүйн хүрээлэнгийн захирал эд нар хариулах болов уу гэж бодож байна. 14, 16 хоёрын хооронд маш их ялгаа байгаа юм. 16-тай хүүхэд чинь хөдөлмөр эрхлэх асуудал байна. Энэ хүүхдүүдийн хоорондын хайр дурлалын асуудал байна. Нас бие, нийгмийн онцлогоосоо хамаараад үзэж байгаа харж байгаа юмнаасаа хамаараад нөхөн үржихүйн боловсролын асуудлууд байна гээд олон асуудлууд байгаа байхгүй юу. Тэгэхээр 16 болгосноороо бол энэ нэг тийм том үр дүнд хүрнэ гэж үзэж байгаа юу. Энийг ер нь би сайдаас биш би судлаачаас нь асуумаар байгаа юм. Энэ 14-ийг 16 болгосноороо ийм үр дүнд хүрэх гээд байна гэдэг асуудал байгаа юм. Бид нар 16 болгосноороо нөгөө залуучуудыг дөнгөж өсвөр үеийн олон залуучуудыг янз бүрийн гэмт хэрэг рүү аваачаад оруулчих вий гэдэг асуудал байгаа байхгүй юу. Тэгээд энэ дээр их болгоомжтой хандах ёстой гэдэг үүднээс нь би судалсан, тооцсон ийм зүйлийг би 2 дугаарт нь асуух гээд байгаа юм.

3 дугаарт нь согтууруулах буюу мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодохтой холбоотой асуудал байгаа юм. Энийг би 2 ялгаж авч үзсэн болов уу гэж бодож байна. Энхбаяр сайдаас асуух гэж байгаа юм. Мансуурсан буюу согтуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодож явж байгаа тохиолдолд би хорих гэхээс илүү торгууль, эрх хасах чиглэл рүү нь явбал ямар вэ гэж бодоод байгаа юм. Харин гэмт хэрэг үйлдчихсэн

бол ярих юм байхгүй эрхээ хасуулаад хорих руу явдаг ийм л чиглэлээр ялгавартайгаар авч үзвэл яасан юм бол гэдэг ийм л зүйл байгаа юм.

**С.Одонтуяа:** Хэн хариулах вэ. Сайд эхлээд хариулъя гэж байна.

**Б.Энхбаяр:** Би Тогтохсүрэн даргын сүүлийн асуулт буюу согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон үйлдэл дээр шууд хорих ял ноогдуулах нь бас арай чанга уу. Ер нь энийг бас авч үзэх боломж байна уу гэдэг асуудал дээр хариулъя. Яг энэ үйлдлийн тухайд бол нэгэнт гэмт хэрэгт тооцохоор оруулж ирж байгаа учраас Эрүүгийн хуульд байгаа ялын интервалын хамгийн бага ялыг бичсэн юм. Тэр нь бол хорих ялынх нь тухайд бол 1 жил хүртэл 6 сараас 1 жил хүртэл хорих ял байгаа. Мэдээж шүүх хэрэглэж таарна. Тухайн согтуурлын зэрэг, учруулж байгаа хохирол, давтамж, гэм буруугаа ухамсарлаж байгаа эсэх байдал, урьд нь ер нь энэ төрлийн зөрчлийг хэр зэрэг гаргаж байсан эсэх гээд олон хүчин зүйлийг хамаарч байгаад шүүх хэрэглэнэ. Би бол бодохдоо 1, 2 пиво уучихсан хүнийг шууд л 1 жилээр хориод байна гэж би бодохгүй байна. Шүүх. Гол төлөв торгох байх яг практикт бол. Мөн нийтэд тустай ажил хийлгэх 2 дээр л ер нь шүүх ял шийтгэл ноогдуулж явах болов уу гэж. Өөрөөр хэл хэлбэл үнэхээр нөгөө болдоггүй саяын хэлж байгаа тийм дадал шинжтэй ийм нөхдүүдийн тухайд бол тэгээд л хүндэрсээр байгаад л хорино гэсэн үг. Тэгэхээр мэдээж ийм ялын яг ямар ял ноогдуулах вэ гэдгийг бол шүүхэд олгоё гэсэн Засгийн газрын санал байгаа. Улсын Их Хурал дээр бас хэлэлцэх эсэхийг шийдсэний дараа бас ажлын хэсэг гараад энэ асуудал дээр нухацтай авч үзэж, хууль тогтоогч бас өөрөө ингэж нэлээн нухацтай хандаж мэргэн шийдвэр бас гаргах ийм боломж бас хууль тогтоогчийн бүрэн эрхэд байгаа гэж ингэж ойлгож байна. Таны маш тодорхой асуусан тэр асуултуудад манай Хууль зүйн хүрээлэнгийн захирал,

мөн эрүүгийн хууль тогтоомжид байнгын ажиллагаанд мониторинг хийх байнгын ажлын хэсгийн гишүүн Гантуяа нар хариулна.

**С.Одонтуяа:** Микрофоныхоо дугаарыг 87.

**Х.Эрдэм-Ундрах:** Тогтохсүрэн гишүүний асуултад хариулъя. Эрүүгийн хуулиар ер нь эцэг эхэд бас үүрэг хариуцлага хүлээлгэдэг үү гэсэн. Одоогийн Эрүүгийн хуулийн 16 дугаар бүлэгт байгаа. 16.11 дээр хүүхдийг асран хамгаалах үүргээ үл биелүүлсэн бол эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид хариуцлага хүлээлгэхээр заасан байгаа. Энэхүү үүргээ үл биелүүлснээс болоод хүүхдэд хөнгөн, хүндэвтэр, хүнд хохирол учирсан бол гээд дээд тал нь 2-8 жил хүртэл хугацааны хорих ял оногдуулахаар ийм гэмт хэрэг байдаг. Мөн 14-ийг 16 хүртэлх насны гэснээр үр дүнд хүрэх үү, ийм туршилага байдаг уу гэж. Бид энэ дээр бас Америкийн Нэгдсэн Улс болон Европын Холбооны орнуудыг судалж үзсэн. Иргэний эрх зүйн чадвар, чадамжийн асуудлыг бол иргэний хуулиар зохицуулдаг. Эдгээр орнуудад манайхтай адилхан эдгээр орнуудад болохоор бэлгийн амьдралд шийдвэр гаргах чадвар, чадамжийг бас насны хязгаарыг тогтоож өгсөн байдаг юм байна лээ. Эдгээрээс тухайлбал 15 хүртэлх, 16 хүртэлх насны хүүхэд бол бэлгийн амьдралын талаар бие даан шийдвэр гаргах боломжгүй гэж үздэг. Бүрэн бус чадамжтай гэж үздэг ийм орнууд байна. Тухайлбал: Хорват, Чех, Дани, Грек, Польш, Румын, Словак, Словен, Швед зэрэг орнуудад 15 хүртэлх гэж үздэг юм байна. 16 хүртэлх насны хүүхдийг Бельги, Литев, Латви, Нидерланд, Их Британи, Испани, Финлянд, Люксембург гэсэн эдгээр орнуудад ингэж үздэг юм байна. Энэ хуулийн төсөлд бол шууд 16 гэж хэлээгүй 16 хүртэлх насны хүүхдийг бага насны хүүхэд байна гэж ойлгож байгаа. Тэгэхээр 14 буюу 15 настай хүүхдүүд үүнд хамаарна гэсэн үг. Өмнө нь 14

хүртэлх гэж байсныг дээр нь 14-тэй, 15-тай хүүхдүүдийг ойлгож байгаа юм шүү. Хүлээлгэх хариуцлагын хувьд бас ялгамжтай зааж өгсөн байгаа. 10.1, 10.2 дугаар бүлэгт нэмэлт тайлбар байгаа. Тэр тайлбараар 18 нас хүрэхээс өмнө үйлдсэн хүнд бол хугацаанаас өмнө суллах, өршөөлд хамрагдахгүй байх гэсэн энэ хязгаарлалтуудыг бол тогтоож өгч байгаа. Нэгэнт хүүхэд энэ гэмт хэргийг үйлдэж байгаа биеийн хөгжил болон оюун санааны хөгжлийн хувьд насанд хүрсэн хүнтэй бол дүйцүүлж үзэж болохгүй. Энэ утгаараа. Насанд хүрээгүй хүн энэ төрлийн гэмт хэргийг үйлдвэл Эрүүгийн хуулийн 8 дугаар бүлэг дээр байгаа. Өсвөр насны хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлага гэсэн бүлэг байгаа. Хорих ялыг насанд хүрсэн хүнд оногдуулах ялаас 2 дахин бага оногдуулдаг. Эрүүгийн хуульд бас байгаа. 18 хүрээгүй хүнд бүх насаар хорих ял оногдуулахгүй гэх мэтчилэн энэ ерөнхий ангийн бусад зүйл зохицуулалтуудаараа энэ хамгаалагдах юм байгаа юм.

**С.Одонтуяа:** Нэр, байгууллагаа хэлээд протоколд тэмдэглэгдэж байгаа учраас. 82. Жавхлан сайд та хурал үймүүлээд байх юм.

**Б.Гантуяа:** Ажлын хэсгийн гишүүн Гантуяа Тогтохсүрэн гишүүний асуултад хариулья. Хүүхдийн эцэг эх байх эрхтэй холбоотой анхаарал халамж дутагдаж байгаатай холбоотой асуудлыг хөндсөн. Энэ дээр одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Эрүүгийн хуульд ол хүүхдийн бэлгийн халдашгүй байдал, тэгээд хүүхдийн эрхийн эсрэг хэд хэдэн зохицуулалтуудыг одоогийн хүчин төгөлдөр хуулиар зохицуулсан байдаг. Эрүүгийн хуулийн 12 дугаар бүлэг буюу бэлгийн халдашгүй байдал эрх чөлөөний эсрэг эрхийн бүлэгт хүүхдийн эсрэг үйлдсэн тохиолдолд үйлдлүүдийг бол хүндрүүлэхээр заасан байдаг.

Дараагийнх нь хүүхдийн эрхийн эсрэг бусад гэмт хэргийг тусгасан бүлэг нь 16 дугаар бүлэг байгаа. Энд хүүхдийг

хаях, төөрүүлэх, хүүхдээр гуйлга гуйлгах, хүүхдийг хайхрахгүй орхих гээд асран хамгаалагч, харгалзан дэмжигчдийн буруутай үйлдлүүдийг гэмт хэрэгт тооцож хариуцлага хүлээлгэхээр заасан байдаг. Түүнчлэн Эрүүгийн хуулийн эрх хасах ялыг зохицуулсан 5.7 дугаар зүйлд бол ялангуяа эдгээр бүлгүүдэд заасан гэмт хэргийг хүүхдийн эсрэг үйлдсэн тохиолдолд тухайн гэмт хэргийг үйлдсэн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид, асран хамгаалах эрх, эцэг эх байх эрхийг нь хасах ял оногдуулахаар бол хуульчилсан байдаг. Тэгэхээр энэ бол одоогийн хуулиар зохицуулалттай байгаа. Түүнчлэн Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль 2016 онд батлагдсан. Энэтэй уялдуулаад Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль 2019 онд батлагдсан байгаа. Эдгээр хуулиуд дээр бол Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл бол гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулахаар бол ийм шинэ зохицуулалтууд орж ирсэн байдаг.

**С.Одонтуяа:** Тогтохсүрэн гишүүн тодруулъя.

**Д.Тогтохсүрэн:** Би уг нь хууль асуугаагүй л дээ. Манайхан тэгээд л хууль тайлбарлаад л байх юм. Би энэ судлаач нараас яг өнөөдөр энэ хуулийг ингэж өөрчилснөөрөө гарах үр дүн ийм байна. Тооцоолол ийм байна. Олон улсын туршилага сургамж ийм байна Манай өнөөдрийн нөхцөл байдал ийм байна. Ийм судалгааны чиглэлтэй юм. Энэ судалгаа дээр үндэслэж бид нар 14-ийг 16 болгох гээд байгаа юм. Энэ судалгаа дээр үндэслэж бид нар согтуу жолоочийг ингэх гээд байгаа юм гээд тодорхой судалгаа тооцоолол нийгмийнхээ нөхцөл байдалд хамаарсан чинь би асуугаад байгаа болохоос биш би тэр хуулийн тэр заалтад ийм байдаг гэж би асуугаагүй байхгүй юу. Бид нар хамгийн гол нь нийгмийнхээ нөхцөл байдалд л тохирсон үр дүнгээ өгөх тийм л эрх зүйн орчныг бид нар бүрдүүлэх ёстой байхгүй юу.

Түүнээс биш хэт чангатгаад бид нар үр дүнд хүрэхгүй.

**С.Одонтуяа:** Тодруулгад сайд хариулъя.

**Б.Энхбаяр:** Би Тогтохсүрэн даргын гол болгоомжилж байгаа асуудлыг ойлгож байгаа юм. Энэ бага насны хүүхдийн насыг 14 байгааг 16 болгосноор амьдралтай зөрчилдөх асуудал гарч болзошгүй эрсдэл нь хүчиндэх гэмт хэрэг дээр үүсээд байгаа юм. Тэр нь юу вэ гэхээр 16 хүртэлх насны хүүхдүүд хоорондоо хайр сэтгэлийн үндсэн дээр бэлгийн харьцаанд ордог үйлдэл гэмт хэрэгтэн тооцогдоод тэдгээр нөгөө хүүхдүүд маань дурласныхаа төлөө бас шоронд орчих вий гэдэг болгоомжлол үнэхээр бодитой байгаа. Энэ болгоомжлол бас надад ч байсан. Манай бас олон гишүүд энэ зүйл дээр санал нэг байгаа ийм тохиолдлууд бас байгаа юм. Энэ нөгөө бодитой байгаа. Тийм учраас сая бас судлаач хэлж байна. Энэ насны асуудал өөрөө шинжлэх ухааны үндэстэйгээр бусад улс орны хууль тогтоомжид ялгамжтайгаар хуульчлагдсан байдаг. Өөрөөр хэлбэл тэр бэлгийн бойжилттой холбоотой. Энэ бол цэвэр иргэний эрх зүйн чадвар чадамжтай холбоотой биш ийм насны онцлог байгаа. Тийм учраас би бид яг хүчиндэх гэмт хэргийн тухайд энэ насыг 14, 16, 18 гэсэн 3 үе шатад хувааж ялгамжтайгаар зохицуулсан байгаа. Өөрөөр хэлбэл 14-ийг 16 болгосноор 14-16 насны хүүхдүүдийн тухайд хайр сэтгэлийн үндсэн дээр хүчинд автаагүй, өөрөө хоорондоо үерхсэн энэ асуудлуудыг бол хүчингийн гэмт хэрэгт оруулж өндөр ял шийтгэл ноогдуулах эрсдэлээс хамгаалсан зохицуулалттайгаар Засгийн газар хуулийн төслийг өргөн барьсан байгаа гэдгийг танд бас хэлье.

**С.Одонтуяа:** Балжиннямын Баярсайхан гишүүн асууна.

**Б.Баярсайхан:** Хүүхдийн эсрэг үйлдэгдэж байгаа гэмт хэргийн ялын

бодлогыг чангатгах гэдэг тал дээр бол миний бие дэмжиж байгаа. Улсын Их Хурал дахь хүчирхийллийн эсрэг лобби бүлэг өнгөрсөн 6 сарын 13-ны өдөр холбогдох байгууллагуудтай хэлэлцүүлэг хийж, энэ дээр бас байгууллагууд бол ерөнхийдөө дэмжих ийм саналтай байсан. Тийм учраас Хууль зүйн сайдад энэ хүсэлтээ бас явуулж байсан байгаа. Хэд хэдэн асуулт байна. Тэгээд ер нь бол сая манай гишүүд бас нэлээн асууж байна. Энэ бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэг, тэр дундаа яг хүүхэд хүчирхийлээд байгаа гэмт хэргийн шалтгаан нь яг энэ өнгөрсөн жилүүдэд яг юу байдаг юм бэ. Энэ яг та бүхний судалгаагаар юу гардаг юм. Энэ нь сэтгэцийн өөрчлөлт юм уу, эсвэл гаж дон юу гэж тодорхойлогддог юм. Эсвэл өөр шалтгаантай байдаг юм уу. Яагаад энийг яриад байна гэхээр шалтгааныг нь тодорхойлохгүйгээр бид нар урьдчилан сэргийлэх боломжгүй ээ. Тийм учраас энэ ямар шалтгаантай байдаг юм бэ. Ямар учиртай байдаг юм бэ гэдгийг судалгаа байна уу. Яг энэ төрлийн гэмт хэрэг үйлдэж байгаа гэмт хэрэгтнүүд ер нь засардаг юм уу. Ер нь засрах уу. Магадгүй засрахгүй учраас бүх насаар нь хорих ял шийтгэх ёстой гэдэг ийм шийдэлд хүрч байгаа гэж ойлгож байна. Гэхдээ энэ судалгаа шинжилгээ хийж байгаа байгууллагууд энийг яг юу гэж үздэг юм бэ. Сая 14-ийг 16 нас хүргэж байгаа энэ зүйл заалт дээр бид нар эцэг эхчүүдийн хараа хяналтыг илүү сайжруулахгүй бол энэ асуудлаас болж өнөөдөр нийгэм чангал, 16 болго, 18 болго, 21 болго ч гэж ярьж байгаа. Хүүхэд гэдэг нас хэдэн нас хүртэлх тодорхойлолтод байдаг юм. Монгол Улсад бол 18 нас гэж байгаа. Тэгээд үүнээс гарах яг тэр сөрөг үр дагавар юм уу, хүмүүсийг, хүүхдүүдийг хэлмэгдүүлэхгүй байх энэ тал дээр ямар зохицуулалт байна вэ гэдгийг бас дахиад асууя. Ер нь сая өмнөх гишүүд бол асуусан. Ер нь бол хүчирхийлэл үйлдээд гарч ирж байгаа, ял эдлээд дуусаад гарч ирж байгаа хүмүүсийг олон нийтэд мэдээлдэг, амьдарч байгаа оршин суух газарт нь ийм хүн гарч ирсэн шүү.

Амьдарч байгаа шүү гэдгийг мэдээлдэг. Энэ бол хөгжсөн орнуудад бол аль хэдийн жигдэрчихсэн ийм арга хэмжээ байдаг. Тэгээд энэ дээр манай Монгол Улс энэ зохицуулалтыг хийх бас боломжтой юу гэсэн ийм асуултуудыг асууя.

**С.Одонтуяа:** Хэн хариулах вэ. Энхбаяр сайд.

**Б.Энхбаяр:** Баярсайхан гишүүнд баярлалаа. Ер нь Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсоноосоо хойш яг энэ хүүхдийн эсрэг, гэр бүлийн хүчирхийллийн эсрэг Улсын Их Хуралд бас лобби бүлгийг 2000 оны намар санагдаж байна. Баярсайхан гишүүн бас гишүүдээр манлайлаад 2020 оных санагдаж байна. Ерөөсөө гишүүн болоод Улсын Их Хурал байгуулж энэ асуудлаар бас маш олон удаагийн хэлэлцүүлэг, асуудлуудыг хөндсөн байдаг. Манай Хууль зүйн байнгын хороо дээр ч гэсэн энэ асуудлаар олон удаа бас шаардлага тавьж, судалгаа хийж, эндээс урьдчилан сэргийлэх хүрээнд олон олон арга хэмжээнүүдийг бас авч ажиглаж байгаа манлайлагч гишүүн гэдгийг би бас онцолж, танд бас талархсанаа илэрхийлье ээ. Үнэхээр таны хэлсэнчлэн энэ хүчирхийллийн уг шалтгааныг бол бид их олон хүчин зүйлээс холбож авч үзэх ёстой. Хамгийн суурийн суурийн суурийн суурь шалтгаан бол би бол хайр гэж боддог. Хайр бол ямар ч хөлс мөнгө шаардахгүй, хүчээр албадлагаар хийгддэггүй. Тэгэхдээ хамгийн үнэтэй зүйл. Инээмсэглэл мөн адилхан. Энэ бол хамгийн хүнээр албадуулаад байхгүй, мөн хүчээр хэрэглүүлээд байхгүй, мөн хөлс мөнгө төлж явдаг тийм зүйл биш. Тийм учраас нэгнийгээ ойлгож, биеэ хайрлаж байгаа тэр хосын үр хүүхдүүд нүдэн дээр нь өөр байдаг. Цогтой байдаг, гэрэлтэй байдаг, жаргалтай байдаг. Жоохон гэр бүлийн хувьд асуудалтай тийм бие биедээ хүйтэн хөндий айлын хүүхдүүд цаанаа л нэг гал нь бөхчихсөн байдгийг бид бүхэн мэднэ. Бид нар хүүхдүүдийнхээ нүдийг үргэлж гал цогтой байлгах тийм л үүрэгтэй хүмүүс.

Тийм учраас хүн бүр, эцэг эх болгон энэ үүргээ ухамсарлахаас би энэ суурь нь эхэлнэ гэж бодож явдаг. Улам илүү их хайрыг түгээгээсэй гэж бодож явдаг. Үр хүүхдүүдээ хайрлаасай гэж бас бодож явдаг. Энэ бол албадлагаар бол ард нь гардаг зүйл биш. Би мэдэж байна. Тэгэхдээ яалт ч байхгүй энэ хүмүүсийн хувьд эдгэрдэггүй өвчин гэж үздэг юм байна. Америкийн Нэгдсэн Улс 1960-аад оны үед Дээд шүүх нь өөрөө ингэж үзсэн. Энэ бол өвчин гэж үзсэн. Тийм учраас энэ дээр ял шийтгэлийн хатуу чанга бодлого хэрэгжихээс өөр аргагүй ийм нөхцөл байдалд байгаа.

**С.Одонтуяа:** Гочоогийн Ганболд гишүүн. Уучлаарай Баярсайхан гишүүний асуулт нь нэмэлт хэддүгээр микрофон бэ. Хариулчихсан юм байна. Одоо Гочоогийн Ганболд гишүүн асууя.

**Г.Ганболд:** Оруулж ирж байгаа хуулиудыг бол ер нь дэмжиж байгаа. Сайд, ажлын хэсэг бол ер нь энэ төрлийн гэмт хэргүүдэд ялын бодлого сулдсан учраас гэж оруулж ирж байна гэж бодож байна. Тэгэхдээ би хэрэгжих хугацаа дээр ганцхан зүйл дээр. Хүүхдийн эсрэг гэмт хэрэг дээр бол би юм ярихгүй ээ. Энэ согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодох дээр бид нар өнөөдөр хууль баталчихлаа. Зарим хууль, энэ хууль батлагдсаныг тэр тусмаа хөдөөгийнхөн бол мэдэхгүй. Сүлжээ байхгүй, ямар ч мэдээлэл авахгүй хүмүүс бол явж байгаад л тэгээд л 12 сарын 31-нд шинэ жил болоод л 1 сарын 1-ээс эхлээд хэдэн зуугаараа шоронд явах нь ээ. Тэгэхээр зөвхөн энэ хэрэгжих хугацааг нь саяын заалтын хэрэгжих хугацааг нь ядаж 2024 оны 6 сарын 1 болгоод тэр хугацаанд нь гаднын улс орнууд шиг энэ хуулиа жаахан сурталчлахгүй юм уу. 6 сарын 1-ээс ийм гэмт хэрэг үйлдэх юм бол та гэмт хэрэгтэн болно шүү гэдгийг гаднын улс орнууд чинь нэлээн хугацаатай хуулиа баталж байгаад сурталчлаад, таниулаад, хүмүүс нэлээн ойлгуулсны дараа хэрэгжүүлдэг бол манайх гэнэтхэн

урьд өдөр нь батлаад л маргаашаас нь маш олон залуучууд ирээдүйд нь бид нар хар тамга тавих гээд байна л даа. Цаашидаа төрийн зарим байгууллагад орох эрхийг нь хааж байна. Насан туршидаа ялтан гэдэг энэ хар тамга тавих гэж байна. Бас гадаад дотоодын визэнд орохоос өгсүүлээд л ихэвчлэн залуучууд, тэр тусмаа хөдөөгийнхөн бол энд өртөж байгаа юм. Бид нар өөрөө их өвөрмөц ахуйтай ард түмэн. Ахуйн соёл нь шал өөр. Тэгээд би түрүүний Бат-Эрдэнэ гишүүний асуусан айргийг дахиад асуух гээд байгаа юм. Сайдаас бас ажлын хэсгээс яг энэ айргаас тэр согтолтын зэрэг гэдэг юм гардаг юм уу. Гардаг бол яг хэдэн хувь гардаг юм. Тэгэхээр гаднын улс орнуудын зарим улс оронд байна шүү дээ. Энэ согтолтын зэргийн чинь 0,4, 0,5-ыг хүлээн зөвшөөрдөг ийм улс орнууд байна л даа. Тэгэхээр ядаж айргаа жоохон ялгахгүй бол бид нар чинь архиа бага ууж, айргаа ахиу уу гээд л айргийн баяр хийгээд л энд тэндгүй айргийн баяр. Одоо Улаанбаатар хотын Сүхбаатарын талбайн энд тэндгүй л баахан айраг зарсан, айргийн баяр хийсэн нөхдүүд. Тэгээд тэр хүмүүс чинь хэрэглээ дээр нь үнэхээр гардаг бол энэ чинь цаашидаа бид нар нэлээн хүнд байдалд орно. Тэгэхээр зэрэг энийг жаахан ялгаж, энэ уламжлалт ахуй, хөдөө орон нутгийн иргэд чинь энэ айргаар чинь бараг зундаа хоол унд идэхгүй бараг цай чанахгүй шахуу хэрэглэдэг хэд хэдэн аймаг сумууд зөндөө байна шүү. Тэгээд энийгээ яг тов тодорхой болгоод, үнэхээр айргаас тэр зэрэг гардаг бол тэр хэмжээг нь жоохон тогтоох тал дээр бид нар анхаарч ажиллахгүй бол энэ уламжлалт ахуйгаа бодсон ч гэсэн сурталчлаад байгаа энэ айрагт чинь жишээлэх юм бол хүний биед ашигтай бактери асар их байна хэрэглэ гээд бүгдээрээ сурталчлаад л эмч наргүй бүх л байгууллагууд сурталчлаад байна шүү дээ. Тэгээд энэ тал дээр та бүхэн яг ямар бодолтой байгаа вэ.

Тэгэхээр энэ чиглэл рүү бас энэ гадаад улс орнуудын та бүхний

танилцуулга дээр шууд эрүүгийн ялтан болгоно гэхээсээ илүүтэй эдийн засгийн хөшүүргээр нь тэмцдэг арай жоохон бага тийм зэрэгтэй дээр нь эдийн засгийн хөшүүргээр нь, эрх хасах хөшүүргээр нь явахгүй бол би 1 сарын 1-ээс ядаж л хэрэгжих хугацааг нь жоохон хойш нь сунгаж байж сурталчилгаа хийхгүй бол маш олон залуучууд ирээдүйд нь хар тамга тавьсан ийм зүйл болох вий гэдэгт би жаахан болгоомжлоод байгаа юм. Тэгэхээр түрүүн маазралгүйгээр яг тодорхой хариултууд нэг өгөөдхөөч ээ. Энэ айраг дээр яг судалгаа хийсэн зүйл яг байгаа эсэх дээр.

**С.Одонтуяа:** Хэн хариулах вэ. 89. Мөнх-Эрдэнэ Хууль зүй, дотоод хэргийн сайдын зөвлөх.

**Д.Мөнх-Эрдэнэ:** Ганболд гишүүний асуултад Мөнх-Эрдэнэ хариулъя. Шүүх шинжилгээний ерөнхий газраас бид бас энэ асуудлаар судалгаа авсан байгаа. Энэ судалгаагаар бол ер нь хүний биед агуулагдаж байгаа спиртийн хэмжээгээр энэ согтуурлын зэргийг тогтоодог. Энэ бол юу гэдэг юм. Согтууруулах ундааны төрөл зүйлээс хамаараад харилцан адилгүй байдаг. Дээр нь тухайн хүний нас хүйс, биеийн жин, элэгний үйл ажиллагаа, хууч өвчин, хоол унд идсэн эсэх болон унтаж амарсан байдал гээд олон нөхцөл байдлаас хамаардаг. Айргийн хувьд бол бас юу гэдэг юм, нутаг орны онцлог, тэр битгий хэл айлуудынх нь хүртэл онцлогоос хамааран хатуулгийн хэмжээ сайхан айраг, муухай айраг, чанартай, чанаргүй гээд янз бүрийн байдлаа ярьдаг. Тийм учраас яг тухайлан нарийвчлан айраг бол ингэнэ гэсэн юм бол байхгүй. Харин спиртийн хувьд, архины хувьд, пивоны хувьд виноны хувьд тодорхой түрүүн бас хэлсэн байгаа. Тэгээд ер нь дэлхийн улс орнуудын байдлыг харахад бол янз бүрийн байдлаар зохицуулсан байна лээ. Франц улс бол жишээ нь 0,25 цусан дахь хэмжээ нь 0,25 промилл хүртэл байх юм бол хэвийн гэж үздэг байхад БҮгд Найрамдах Хятад Ард Улс бол 0,8, Дани

улс 0,5, Финлянд 0,5 гэх мэтчилэн янз бүрийн байдлаар зохицуулсан байгаа. Тэгээд бид нарын хувьд хуулийн төсөл дээрээ 0,5 промил гэж яг ингээж зохицуулахаар оруулсан байгаа гэдгийг хэлье.

**С.Одонтуяа:** Энхбаяр сайд нэмж хариулъя. Айраг л гэж асуугаад байна шүү дээ. Айргаа увал яах вэ гээд л.

**Б.Энхбаяр:** Сogтууруулах ундаа гэдэгт ямар төрлийн ундааг ойлгох вэ гэдэг нь Эрүүгийн хуулийн асуудал биш. Энэ асуудлыг бид өнгөрсөн онд Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачилсан. Сogтууруулахтай тэмцэх тухай хууль дээр ярьсан шүү дээ. Айраг оруулах уу, оруулахгүй юу гээд зөндөө ярьж ярьж байгаад энэ чинь орно шүү дээ. Айраг уухаар халдаггүй юм уу. 5 литр намрын айраг уучихвал энэ чинь бүр баларсан юм болно биз дээ. Тэгэхээр энэ хууль дээр айраг согтууруулах ундааны зүйлд орохгүй гэж бол бичихгүй. Шимийн архи орохгүй гэж бол бичихгүй. Тухайн тэр согтууралд нөлөөлөх хамгийн доод хэмжээг л бичнэ. Доод хэмжээ тэр нь айргаас болсон байна уу, архинаас болсон байна уу, пивоноос болсон байна уу тэр хамаагүй. Тэр хэмжээг давсан л бол та юу яасан байна л гэж Эрүүгийн хууль дээр зохицуулагдана. Хэрвээ айргийг ер нь оруулах ёсгүй гэж байгаа бол тэр өөр хууль дээрээ энэ асуудлыг л ярих ёстой юм байгаа юм. Энэ бол Эрүүгийн хуультай ямар ч холбоогүй асуудал гэж хэлмээр байна.

**С.Одонтуяа:** Хэрэгжих хугацаа гэсэн Энхбаяр сайдаа. Хуулиа сурталчлах хугацаа гэсэн.

**Б.Энхбаяр:** Үгүй ээ, одоо согтчихоод жолоо барьж болохгүй шүү гэдгийг сурталчлахад ер нь юу нь хугацаа шаардах юм бэ энэ чинь. Энийг сурталчилна гэхэд энэ чинь ганц өгүүлбэр л байгаа шүү дээ. Би хэлээд байгаа шүү дээ. Энэ 7 хоногийн хугацаанд энэ согтуу тээврийн хэрэгсэл чинь 42-47 буурчхаад

байна шүү дээ. Хууль яагаагүй байхад. Энэ чинь оччихоод байгаа байхгүй юу, сонсчихоод.

**С.Одонтуяа:** Одоо Жамъянхорлоогийн Сүхбаатар гишүүн асуулт асууна.

**Ж.Сүхбаатар:** Би бол Байнгын хороо дээр бол зарим саналаа бол хэлчихсэн. Мөрдөн шалгах ажиллагааны нууц л гэнэ. Тээврийн хэрэгслийн аюулгүй байдалтай холбоотой асуудал, бага насны хүүхдийн хүчирхийлэлтэй холбоотой асуудлууд гээд. Тэгээд энд нэг дурдагдаагүй юм яваад байгаа юм Энхбаяр сайд аа. Манай энэ холбогдох хүмүүс. Нөгөө согтууруулах ундаагаа бид яриад байна шүү дээ. Гэтэл нөгөө мансууруулах эм, бодис гээд байгаа юм. 1 сая 300 мянган литрээр борлуулалт буурсан гээд байгаа ч гэсэн би тэр өчигдөр Байнгын хороо дээр хэлж байгаа цаана нь нөгөө хар тамхины чинь хэрэглээ нэмэгдээд байгаа юм биш үү. Одоо ингээд л манай энэ хэвлэл мэдээллийнхэн чинь гаргаж тавиад байна шүү дээ. Тэр зарим баар саванд ингээд байна, хэрэглээ нь нэмэгдээд байна. Сүүлийн үед энэ хар тамхины асуудал чинь нэг их яригдахгүй байгаад байдаг. Нөгөө согтууруулах ундаа маань ч яах вэ ингээд янз бүрийн шалтгаанаар сайн мэдээж бид нарын Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Ерөнхийлөгчийн санаачилсан асуудлууд, би ч гэсэн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт анх энэ тэмцлийг эрчимжүүлье гээд оруулсан. Тэгэхээр энд бол мансууруулах бодис хэрэглэсэн үедээ жолоодсон бол шийтгэгдэнэ гэж байгаа юм.

Тэгэхээр 1 дүгээр асуулт ер нь мансууруулах эм, сэтгээд нөлөөлөх бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодоод баригдсан хүмүүс байна уу. Тэрийг чинь бид үлээлгэнэ гэхээр чинь үлээлтээр бол гарахгүй шүү дээ. Тэр хүн чинь дуниартчихсан ч гэдэг юм уу, инээчихсэн ч гэдэг юм уу, манарчихсан

байж байна. Тэгэхээр энэ хүмүүсийг чинь осол гарсан үед нь л барьж авах юм уу, яах юм гэдэг ийм сонин асуулт байгаа.

2 дугаарт энэ өөрөө архидан согтуурахтай зэрэглэлээр үзэх юм бол зарим нь энэ чинь бүрэн контролоо алдчихсан байлаа гэж бодоход энийг хуулийг хэрэглэх явцад энэ чинь бол шууд дандаа хорихгүй л дээ, бүгдийг нь бол хорихгүй. Энэ чинь хүнд гэмтэл учруулаад, хүний амь нас сөнөөчихсөн бол хорих тал руугаа орчихно. Эсвэл удаа дараа давтан хийсэн бол мэдээж орно. Наана нь бол торгох шийтгэл, нийтэд тустай хөдөлмөр, зорчих эрхээ хязгаарлах гээд байгаа л даа. Ер нь бол чангатгая гэдэг нь зөв л дөө. Замын хөдөлгөөний танхайрал бол нийслэл Улаанбаатар хотод бол хавтгайрчихсан байхгүй юу. 700 гаруй мянган автомашины хэрэгсэл бүртгэгдчихсэн байна шүү дээ. 704, 705 мянга гэж байсан. Бид нар заримыг нь хассан шүү дээ. Тэгэхээр энэ замдаа багтахгүй болчихсон. Тэгсэн хэр нь дүрэм журмаа барьдаггүй. Би тэрийг нь бол замын хөдөлгөөний танхайрал гэж томъёолсон. Тэгэхээр ийм учраас энэ удаагийн орж байгаа юм чанга үедээ чанга байх ёстой юм байна лээ. Яагаад вэ гэхээр энэ Солонгос мэтийн бусад улс орнууд, ер нь улс орнууд ийм хатуу чанга хуулиуд гаргаад нэг бол туйлираад бүтэлгүйтсэн юм байдаг. Гэхдээ нэлээн цэгцэд оруулсан юм нь бол ихэнхдээ байдаг юм байна лээ. Яагаад гэвэл нэлээн хэдэн хүн шийтгэгдээд хариуцлага хүлээчихээр бусад хүмүүс нь энэ ноцтой юм байна гээд болдог. Тэгэхээр энэ утгаараа бол дэмжиж байгаа юм. Тэгээд би тэр акцентаа дахиж өгөөд байгаа юм нь болохоор мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын асуудал байгаа шүү. Манай хуулийн салбарынхан байж байна. Ганц машин бариад явж байгаа асуудал дээр бид энийг бас ярьж байгаа ч гэсэн цаашидаа анхаарах ёстой. Тэгэхдээ түрүүний хэлснээрээ ийм тохиолдлууд хэр байна. Тэгээд л үнэхээр тэр орой үдэш бар саванд хэрэглэж байгаа бол

тэр чинь гараад л машинаа унаад явчхаж байгаа шүү дээ. Эсвэл зарим нь аягүй бол мотоцикл унаад л явчхаж байгаа байх. Удахгүй мотоциклын хэрэглээ бас бага багаар нэмэгдээд л байх шиг байгаа юм. Зүгээр бусад оронд чинь бол тэгдэг шүү дээ. Тэгээд бид нар кинон дээр ч хардаг. Нөгөөдхийгөө хэрэглээд л хурд мотоцикл дээр суугаад л давхиж байгааг кино дээр зөндөө л харж байдаг. Тэгэхээр энэ юм чинь ер нь юу болж байгаа бол. Ер нь тэр жил 1980-аад оны сүүлээр Польшид бол архины хэрэглээ буурахад, мансууруулах бодисын хэрэглээ нэмэгдсэн гээд л би уншиж байсан байхгүй юу. Оюутан байхдаа. Аль 30-аад жилийн өмнө уншиж байсан. Тэгэхэд бас тийм тийм асуудлууд бас байгаа шүү. Тэгэхээр энэ хуульд чинь нөгөө мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хэрэглэсэн үедээ гэдэг юм яваад байгаа учраас өнөөдрийн нийгмийн энэ юм дээр та хэд маань хэлэх ярих юм юу байна. Бас энэ Их Хурлын индэр дээрээс хууль санаачлагч талаас асууя гэж бодож байна.

**С.Одонтуяа:** Хэн хариулах вэ. Сайд, дараа нь 86 дугаар микрофон.

**Б.Энхбаяр:** Мансуурах эм, сэтгэцэд нөлөөлөх бодистой тэмцэх тухай асуудал ер нь бол сүүлийн 4, 5 жил бол парламентын танхимд яг ил байдлаар бол яригдаагүй. Тэгэхдээ Улсын Их Хурлын дэд дарга Одонтуяа бол энэ асуудлаар маш тодорхой нэлээн мэдээлэлтэй, нэлээн хатуу арга хэмжээ авах шаардлагатай зохицуулалтын талаар бол хандаж байсан. Мөн Аюулгүй байдлын байнгын хороонд Энх-Амгалан гишүүн даргалаад энэ асуудлаар бас хаалттай мэдээлэл сонсож, холбогдох байгууллагууд үүрэг чиглэл болгож байсан. Хавар, энэ хавар шүү. Би энэ асуудлаар бол нэг их ил айхтар хүмүүсийг цочоосон тоо ярьж сенсац үүсгэж ярихаас түдгэлзэж байна. Мансуурах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой асуудал үндэсний аюулгүй байдлын хүрээнд ноцтой



хэмжээнд сэтгэл түгшээсэн асуудал бол бодит байдал бол болсон. Тийм учраас энэтэй 2 янзын аргаар тэмцэнэ гэж бодож байгаа.

1 дүгээрт бол эрүүгийн ял шийтгэлийн бодлого дээр уян хатан байдлыг хангана. Өөрөөр хэлбэл энэ чиглэлийн юмыг өөрөө худалдан борлуулах, ашиг олох зорилгоор бус хэрэглэсэн, хэрэглэдэг донтой үйлийг ер нь бид гэмт хэрэгтэн гэж үзэх үү, өвчтөн гэж үзэх үү гэдэг зарчмын асуудал байгаа. Харин энэ төрлийн үйлийг ашиг олох зорилгоор, зохион байгуулалтаар үйлдэж байгаа ял шийтгэлийн бодлогыг яах вэ гэдэг асуудал байгаа. Мөн энэ төрлийн гэмт хэргийн зөвхөн ялын бодлогыг өндөрсгөх байдлаар биш гол нь нууц далд аргаар үйлдэгдэж байгаа учраас нууц далд аргаар илрүүлэх тэр арга ажиллагаа технологийн асуудлууд бас байгаа. Мөн дэд бүтэц буюу энийг өвчтөн гэж үзсэн тохиолдолд эмчлэх төвүүдийн асуудал яригдана. Энэтэй холбоотой менежментийн асуудал яригдана. Би энийг төр хийх ёсгүй гэж боддог. Менежментийн шүү. Дэд бүтцийг нь төр байгуулна. Менежментийг нь их тийм орчин үеийн загвар хэлбэрээр ажиллуулах шаардлагатай. Тэгэхгүй болохоор ирэхгүй байгаад байгаа юм.

**С.Одонтуяа:** 86 дугаар микрофон.

**Ц.Чинзориг:** Тээврийн цагдаагийн алба Чинзориг. Нийт 2022 онд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон нийт 16 зөрчил, мөн тээвэрлэсэн 2, тээврийн хэрэгслээр зорчигч 4, 2023 онд бол эхний 9 сарын байдлаар тээврийн хэрэгсэл жолоодсон 3, тээвэрлэсэн 6, зорчигч 1 гэсэн ийм тоон мэдээтэй байгаа.

**С.Одонтуяа:** Сая ингэж асуусан шүү дээ. Гол нь энэ нөгөө жолоочийн согтууруулах ундаа хэрэглэсэн үед тогтоодог. Гэтэл яг энэ сэтгэцийн

бодис, мансууруулах бодис хэрэглэчихсэн үед илрэх үү. Энийг тогтоож чадах уу гэж асуусан тийм үү.

**Ц.Чинзориг:** Энийг бол яг Эрүүл мэндийн сайд, Хууль зүйн сайдын 2021 оны хамтарсан тушаалаар зохицуулсан байгаа. Энийг бол цусаар болон шээсээр 2 аргаар авч тодруулдаг. Хэрэглэсэн нь тогтоогдсон тохиолдолд эрх бүхий албан тушаалтан хуульд заасан үндэсний дагуу эрхийг хасах, мөн одоогийн хуулиар бол 400 мянгаар торгохоор ингэж зохицуулагдаад шийдээд явж байгаа.

**С.Одонтуяа:** Сүхбаатар гишүүн тодруулъя.

**Ж.Сүхбаатар:** Тэгэхээр түрүүн би сайн сонссонгүй. Зөвлөхөн хэлээд байхаар чинь. Тэгэхээр та хэд яг цусаар, шээсээр шинжилнэ гэхээр бол яг тухайн үед тээврийн хэрэгсэл жолоодож байгаа хүнийг зөрчил гаргасны дараа л үндсэндээ тогтоох нь байна шүү дээ. Зөрчил гаргаагүй үед нь тогтоохгүй гэдэг юм ойлгогдож байна.

2 дугаарт сая хэлж байна. Тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг нь хасаж байна гэж байна. Тэгтэл тэнд цаашаагаа нөгөө тийм мансууруулах бодис хэрэглэчихсэн асуудлуудаараа цаашаагаа үргэлжлээд тэр чинь бас тусдаа хэрэг болоод явах ёстой шүү дээ. Тэгээд тэр асуудлууд нь бас ямар байгаа юм бол. Ер нь энэ төрлийн тээврийн хэрэгсэл жолоодож байгаа энэ төрлийн гэмт хэргийн байдал ер нь цаашидаа өсөх үү. Юу гэж боддог вэ. Эсвэл илрэхгүй байгаа юу. Манайд эсвэл бага байгаад байгаа юм уу. Энэ талаар мэргэжлийн талаасаа та бүхэн бас хэлээч.

**С.Одонтуяа:** Хэн хариулах вэ. 86. Жоохон ойрхон ярихгүй бол таны яриа ерөөсөө сонсогдохгүй байна.

**Ц.Чинзориг:** Түрүүний сая хэлсэн тэр Эрүүл мэндийн сайд, Хууль зүйн сайдын хамтарсан тушаал дээр

зохицуулчихсан байж байгаа юм байна. Алба хаагч тээврийн хэрэгслийг зогсоогоод шалгасан тохиолдолд шалгаад тандагч драйвер багаж хэрэглэсэн тохиолдолд ямар нэгэн заалт гарахгүй байгаа тохиолдолд тухайн хүний биеийн байдал хэлэмж мөн өөрөө би хэрэглэсэн гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа тохиолдолд бид нар шээс, цуснаас нь шинжилгээ аваад хар тамхитай тэмцэх газар руу шилжүүлж, мөн тээврийн хэрэгсэл жолоодсон дээр нь эрх бүхий албан тушаалтан эрх хасаад, давхардсан зүйлчлэлээр зөрчлийн хуулиар арга хэмжээнүүд тооцогдоод явж байгаа. Энэ дээр тухайн хүний өөрөө хүлээн зөвшөөрсөн мөн биеийн хэлэмж, бусад юмнууд нь байдлаас нь шалтгаалаад энэ шинжилгээг авдаг байж байгаа.

**С.Одонтуяа:** Одоо Жамбын Батсуурь гишүүн асуултаа асууна.

**Ж.Батсуурь:** Би энэ Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд бол дэмжиж байгаа юм. Тэгэхдээ яг энэ нийгмийн уур амьсгал ийм халсан үед оруулж ирж байгаа нөхцөл байдал нь цагаа олсон нь зөв үү, үгүй юу. Яаралтай горимоор хэлэлцэж байгаа нь бол би бас буруу гэж ингэж үзэж байгаа юм. Яагаад вэ гэхээр би Эрүүгийн хууль, Татварын хууль энэ тэрийг бол улс төрчид нийгмийн санаа гэхээсээ илүүтэй мэргэжлийн болон мэргэшсэн хүмүүсийн олон дахин шүүлтүүрээр орж ирсэн ийм төслүүд танилцуулагдах ёстой байхгүй юу. Тэгэхээс тэр нэг салбарын сайд өөрчлөгдмөгц байдаг юм уу, нийгэмд халалт үүсэнгүүт шууд хууль санаачлан орж ирж байгаа нь бол би яарвал даарна гэсэн ийм зүйл рүү орчих вий гэж ингэж бодож байгаа.

Нөгөө талаар энэ мөрдөн шалгах үйл ажиллагааны нууц задруулах гэдэг энэ байдлаар бол ял завишх үйл ажиллагаа бий болдог. Ер нь Монгол Улсын өнөөдрийн үүсчхээд байгаа нөхцөл

байдал бол нууц гэдэг зүйлээс л Монгол орон сүйрчхээд байгаа юм. Нууц нөгөө нууцаас болж ногоон автобус, нууцаас болж Хөгжлийн банк, нууцаас болоод оффтейк гэрээнүүд нууцаас болоод ЖДҮ-нүүд, нууцаас болоод нүүрсний хулгай. Үгүй ээ, тэгээд ил л байх хэрэгтэй шүү дээ. Харин гэмт хэрэгтнийг барих чинь ил байх юм бол олон талаас нь төр түмэн нүдтэй төрсөн бие 2 нүдтэй гэж үг байдаг. Бүгдээрээ олон талаас нь тэрийг чинь хурдан түргэн илрүүлэх барих гээд ийм зүйл байж байгаа юм. Тэгэхээр энэ нууцын доор нууц гэдэг талаас нь албан тушаалтан хууль завишх, авлига, хээл хахууль тэрүүгээр илүү төгөлдөржих ийм үйл явц болох юм биш байгаа гэсэн ийм зүйлийг хэлж байна.

Дээр нь энэ согтуугаар тээврийн хэрэгсэл. Тээврийн хэрэгсэлд мэдээж машин орох байх. Мотоцикл орох байх. Моторт дугуй, унадаг дугуй орох байх. Морин тэрэг орох уу, түрдэг тэрэг орох уу, морь орох уу. Мөн техник хэрэгсэл түрж явж байгаад орвол энэ орох уу. Зах дээр энэ ачаа үүрч байгаа чинь тээврийн хэрэгсэл мөн үү мөн. Халамцуу түрж явж байгаад хүн гэмтээвэл яах юм. Хүний аминд орвол яах юм. Хүний амь чинь яг эрсдэхээ болохлоор бол өчүүхэн л зүйл шүү дээ. Тэгэхээр энэ ер нь яаж тодорхойлогдох юм бэ.

Дээр нь энэ хуулийн үйлчлэл бол Улаанбаатар хотын төвлөрсөн газруудад бол бас учиртай. Камер үзэх харах гээд. Хөдөөд утасгүй, мэдээлэлгүй, дэд бүтэцгүй хүмүүсийн боловсролын түвшинд хэлмэгдэл гарах юм биш байгаа. Сая асууж байна. Согтуурлын зэрэг гээд шүүх шинжилгээний байгууллага тодорхойлно гэж байна. Тэр аймагт байх уу, тэр сумд байх уу, хөдөөгийн өрхөд энэ байх уу. Тэрийг тогтоох гэсээр байтал нөгөө архи нь гарчихдаггүй юм уу. Ийм зүйлүүд байж байгаа юм. Тэгэхээр энэ тээврийн хэрэгсэл гэдэгт чинь морь унаа, түрдэг тэрэг техник хэрэгсэл, цас арилгадаг машин

согтуугаар түрж явж байгаад хүн гэмтээвэл яах вэ. Хүний амь эрсдүүлбэл яах вэ. Энэ мэтчилэн байдлуудаас болж байгаад торгуулийн ял гэдэг юм авах нь ээ. Тэгээд торгуулийн ял байх юм бол нөгөө сонгох сонгогдох эрх, нөгөө гадаад дотоод явах, нөгөө ажилд орох, нөгөө намтар түүхдээ гөлөмцүү зах дээр тээврийн хэрэгслээ тэрэг түрж явж байгаад ял аваад бүх насаараа ийм хар дансанд орох юм биш байгаа гэсэн. Би бол юу талаас нь ийм яарвал даарна гэсэн ийм талаас нь би асуултуудыг асууж байна.

Ер нь тэгээд энэ Татварын хууль, Эрүүгийн хууль энэ тэр бол мэргэжлийн, хүмүүсийн, мэргэшсэн хүмүүсийн олон дахин шүүлтүүрээр орж ирсэн л ийм л төсөл байх ёстой. Ялангуяа камерын өмнө улс төрч нар бол аль болох л энэ халсан нийгмийг хөргөх гэж буруу зүйл хийж, маш олон хүний амьдрал ахуйгаар тоглох вий гэсэн ийм л зүйл.

**С.Одонтуяа:** Хэн хариулах вэ. Микрофоныхоо номерыг дээшээ өргөөрэй. 89. Мөнх-Эрдэнэ Хууль зүй, дотоод хэргийн сайдын зөвлөх.

**Д.Мөнх-Эрдэнэ:** Асуултад хариулъя. Авто тээврийн тухай хуульд авто тээврийн хэрэгсэл гэж тодорхойлолт байдаг. Үүнд бол зорчигч, ачаа тээвэрлэхэд зориулсан бүх төрлийн автомашин, чиргүүл, цахилгаан тээврийн хэрэгслийг ойлгоно гэж заасан байгаа. Тэгэхээр энэ таны асуусан морь, морин тэрэг эд нар орохгүй гэдгийг хэлье.

Бусад улсын жишээний хувьд бол бас манай энэ Хууль зүйн үндэсний хүрээлэнгийнхэн судалгаа хийсэн байгаа. Ер нь бол энэ согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон тохиолдолд бол дийлэнх орон энийг гэмт хэрэг гэж үзэж байгаа. Энэ дээр бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасахаас эхлэн торгох мөн хорих гэх мэтчилэн олон хариуцлагын асуудлыг Эрүүгийн хууль тогтоомждоо тусгасан байдаг. Энэ улс

орнуудын жишээ хэлэх юм бол Австри, Бельги, Хорват, Дани, Эстони, Финлянд, Франц, Герман, Грек, Унгар, Латви, Швед, Англи, Их Британи, Япон гэх мэт улс орнуудын жишээг харьцуулан судалсан байгаа. Бид нар энэ хурлын дараа танд энэ харьцуулсан судалгааг өгье.

**С.Одонтуяа:** Мэдээлэл задруулах нууцад хамааралтай асуултуудад хэн хариулах вэ. 81. Чинбат прокурор.

**М.Чинбат:** Батсуурь гишүүний асуултад хариулъя. Ер нь сая гишүүд бас асуугаад байна. Мөрдөн шалгах ажиллагааны нууц гэж ер нь юу юм бэ. Энийгээ тодорхой болгож өгөөч гэсэн ийм асуудал тавиад байна л даа. Тэгэхээр Эрүүгийн хуульд мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулснаас үүсэх, үүсэхээс сэргийлж энэ хариуцлагажуулсан хэрэг байгаа юм. Тэгэхээр энэ Эрүүгийн хуулийн 21.9 дүгээр зүйл дээр бол мөрдөн шалгах ажиллагааны нууцад хамаарах мэдээ мэдээллийг олж авч мэдсэн хүн, албан тушаалтан хариуцлага хүлээхээр энэ түрүүн Энхбаяр сайд хэлсэн. Үе үеийн хуульд бол энэ байгаа юм. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд мөрдөн шалгах ажиллагааны нууцлалыг хангаж ажиллахыг тэр мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа мөрдөгч, албан тушаалтан, бусад этгээдүүд бол үүрэгжүүлээд өгчихсөн байгаа юм. Тэгэхээр энэ үүргээ биелүүлээгүйгээс гэдэг юм уу, өөр бусад байдлаар мөрдөн шалгах ажиллагааны явцад цуглуулсан мэдээ, баримтат мэдээ, мэдээлэл, олж авсан үйл ажиллагааны үр дүн, явц төлөвлөлтийг задруулахыг хориглоод байгаа юм. Тэгэхээр энэ мөрдөн шалгах ажиллагаа бол мөрдөгч өөрөө бие дааж аль эсвэл прокурорын зөвшөөрлөөр явуулдаг энэ ажиллагааг хэлээд байгаа юм. Энэ бол өргөн хүрээнд явагдаж байгаа. Тухайн хэргийг шуурхай илрүүлэхэд чиглэсэн ажиллагаа байгаа юм. Тэрнээс энэнээс бол яг энийг нь нууц гэнэ, энийг нь биш гэнэ гэж та бүхэн

хууль тогтоогч тодорхойлж өг гэж ингэж нарийн шаардаад байна л даа. Тэгэхээр энэ бол хуульд заасан тэр ажиллагааг ер нь нууцлах ёстой. Тэгээд нууцалсан нөхцөлд, нууц алдагдсан нөхцөлд эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг. Хүлээлгэдэг нь эрүүгийн хариуцлагыг чангатгахын тулд л энэ 21.9-ийг хөндөж Засгийн газраас оруулж ирж хариуцлагыг нь нэмэгдүүлж байгаа юм.

Согтуурлын зэргийг гэдгийг архи ууж согтуурсан, мансуурсан хүний зэргийг тэр анагаах ухааных нь тэр үндэслэл, тэгээд тэр цус, шээсний шинжилгээний байдлаар нь тогтоож байгаа юм л даа. Шинжилгээний байгууллагаар. Тэрнээсээ гадна энэ бол шинжээч томилж хийгдэх ажиллагаа. Түүнээс гадна орон нутагт гэдэг юм уу, мөрдөн шалгахын хэрэг шалгахад гэрч, хохирогчийн мэдүүлэг, бусад нотлох баримтуудын хэмжээгээр тухайн хүн согтууруулах ундаа хэрэглэсэн үү, үгүй юү гэдгийг бас давхар шалгаж тогтоосны үндсэн дээр хэргийн бүрдлийг хангуулах, мөрдөн шалгах ажиллагааны бүх талаас нь бүрэн дүүрэн явагддаг юм. Түүнээс ганцхан шинжээчийн дүгнэлтээр асуудал шийдэгдэхгүй гэж хэлэхээр байна.

**С.Одонтуяа:** Батсуурь гишүүн тодруулъя. 1 минут.

**Ж.Батсуурь:** Үгүй ээ, би яах вэ, яарвал даарна гэж энийг л хэлээд байгаа юм л даа. Асуултуудад жишээлэх юм бол бүрэн хариулагдахгүй байгаа байхгүй юу. Жишээлэх юм бол морин тэргийг бид нар жолоодох гэж ярьдаг шүү дээ. Морин тэргээр явж байгаад үйлдэл хийвэл яах юм. Түрдэг тэргээр энэ зах дээгүүр согтуу үйлдэл хийгээд хүний амь хохироовол яах юм. Дээр нь согтуурлын зэргийг тогтооно гэж байна. Хөдөөд, багт, ууланд, хадлан дээр яаж тогтоох юм. Тогтоох гэсээр байтал чинь тэр чинь архи нь гарчихдаг юм биш үү. Тэнд хүний амь эрсэдсэн бол яах юм гэх мэтчилэн бэлэн биш байна. Яагаад вэ

гэхээр мэргэжлийн хүмүүс маш нухацтай удаан хугацаанд суугаагүй, энэ яг нийгмийн халалтыг дарах гэж орж ирж байгаа. Тэгээд энэ батлагдаж болно. Батлагдсаных нь дагуу энэ олон үйлдлүүдээр маш олон хүмүүс энгийн иргэн хохирох юм шүү. Хэлмэгдэх юм шүү гэсэн талаас нь анхаараарай гэж хэлж байна.

**С.Одонтуяа:** Сайд хариулъя.

**Б.Энхбаяр:** Батсуурь гишүүний хөндөж байгаа асуудлыг бол их сайн ойлгоод байгаа юм аа. Тэр хөдөө эзгүй тал дээр тэгээд 1 юм уучихсан, ганцаараа мотоцикл барьчихсан, тэгээд тэрийг чинь хэн шинжлээд, хэн бариад, хэн торгох юм бэ л гээд байна л даа. Тэгээд жоохон халчихсан, морь уначихсан юмыг тэгээд яах гээд байгаа юм бэ та нар гээд байна шүү дээ. Ойлгож байна, ойлгож байна. Бэлэн биш байна. Тэгээд айл болгоны гадаа цагдаа аваачих юм уу, хэзээ архи уух вэ, хэзээ морио унах гэж байна гээд тавих юм уу. Тийм бэлэн байдлаар нэхээд байгаа юм уу. Эсвэл айл болгоны гадаа камер тавих гээд байгаа юм уу. Тэгвэл бүр утгагүй болно шүү дээ. Хууль бэлэн байна гэдэг юманд байдаггүй байхгүй юу. Жишээлбэл манай Эрүүгийн хуульд усан онгоц хууль бусаар үйлдвэрлэх, онгоц хулгайлах гээд гэмт хэрэг байж л байгаа шүү дээ. Бид нар нэг удаа хэрэглэж байгаагүй. Бид нар усан онгоц хулгайлаад тийм юм гарч байгаагүй. Үйлдвэрлэж байсан. Тэгэхдээ Эрүүгийн хууль гэдгийг чинь би хэлээд байна шүү дээ. Зорилго нь бас урьдчилан сэргийлэх зорилготой гэж. Ганцхан цээрлүүлэх зорилго биш. Та цээрлүүлэх зорилго талаас нь хараад байгаа байхгүй юу. Бид нөгөө талаас нь урьдчилан сэргийлэх зорилго талаас нь бас хараад байгаа байхгүй юу. Хууль хөдөө болон хотод өөр өөр байгааг ойлгож байна. Бүгд ойлгож байгаа. Энэ хөдөө ер нь ямар хэцүү байх бол гэдгийг маш сайн ойлгож байна. Үгүй ээ, тэгээд хөдөө үйлчлэхгүй хотод л үйлчилнэ гэдэг хууль бид гаргаж болохгүй байгаад байна шүү

дээ. Хотод бол бүр чангалмаар байна. Хот суурин газар согтуугаар тээврийн хэрэгсэл.

**С.Одонтуяа:** Батсуурь гишүүн тайлбар хангалтгүй гэж үзэж байна. 1 минут.

**Ж.Батсуурь:** Би хөдөө гэж яриагүй л дээ. Энд 2 өөр зарчим үйлчилж байна шүү дээ. 1 нь машин унаж явж байгаад хүний амь насыг хохироосон байна. Ял авах юм байна. Морин тэрэг унаж явж байгаад зах дээр хүнд гэмтэл учруулбал энэ чинь биш л гэж байгаа шүү дээ. Би хөдөөг яриагүй байна. Нарантуул зах дээр том том тэргүүдээр ачаа түрээд явдаг, тэрийг жолоодох гэж ярьдаг Тэгээд хүний амь нас эрсдүүлбэл тэр чинь хэрэг хүлээхгүй нь байна шүү дээ. 1 нь болонгуут хэрэг хүлээхгүй нь согтуугаар адилхан үйлдэл хийсэн. Тэгэхээр ийм ийм зүйлүүдэд бэлэн биш байгаа. Нууц дээр бол би шалга, нотол, ялла гэмээр л байгаа. Шалга, тэгээд нотол, ялла. Тэгэхээс өөр бид нар нууна гээд. Одоо энэ телевизүүд дээр чинь сонин сонин юмнууд гарч байгаа шүү дээ. Бараг юм ярихгүй. Мөрдөн байцаах албаны нууц. Мөрдөн байцаах албаны нууц. Мөрдөн байцаах албаны нууц гээд л дуусчихдаг. Мэдээлэл хийнэ гэчхээд. Шал худлаа. Тэрний цаана авлига, хээл хахууль, албан тушаалтны .../минут дуусав/

**С.Одонтуяа:** 86 дугаар микрофон. Хэн хариулж байгаа билээ. Нэрээ хэлээрэй.

**Л.Нямдаваа:** Цагдаагийн ерөнхий газар Нямдаваа. Гишүүний асуултад хариулъя. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 3.1 дээр бол тээврийн хэрэгсэл гэж хүн, ачаа суурилагдсан тоног төхөөрөмжийг замаараа тээвэрлэхэд зориулсан хэрэгслийг гэж хэлсэн байгаа. Та зах дээр явж байгаад морин тэрэгтэй хүн хүн дайраад гэдэг юм уу гэмтээчихсэн бол ямар зүйлчлэлээр явах вэ гэдэг нь 27.10-

аар биш. Эрүүгийн хуулийнхаа 11 дүгээр бүлэг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээр явна. Тэр хүнд хөнгөн гэмтэл учруулсан байх бол хөнгөн гэмтэл гэдгээр нь, хүнд байх юм бол хүндээр нь хүндэвтэр байх бол хүндэвтэр. Магадгүй тэр хүн морин тэрэгтэй явж байгаад хүний амь нас хохироохвол болгоомжгүй байсан уу, санаатай байсан уу гээд энэ зүйлчлэлээр явчихна. Энэ нь өөрөө тээврийн хэрэгсэлдээ орохгүй. Зүйлчлэлийн хувьд өөр гэсэн үг.

**С.Одонтуяа:** Энхбаяр сайд нэмж хариулъя

**Б.Энхбаяр:** Согтуугаар тээврийн хэрэгсэл унаад бусдад хохирол учруулаагүй бол тээврийн хэрэгсэл жолоодсон гэдгээр ял шийдэгдэнэ. Та ярьж байна шүү дээ. Морь унаж байгаад хүн дайрчихвал хохирол учруулчихвал гэж. Бусдын бие махбодод санаатайгаар хөнгөн гэмтэл учруулах, хүндэвтэр гэмтэл учруулах, хүнд гэмтэл учруулах бүгд гэмт хэрэг мөн. Бусдын бие махбодод болгоомжгүйгээр хөнгөн гэмтэл учруулах, хүнд гэмтэл учруулах, хүндэвтэр гэмтэл учруулах мөн гэмт хэрэг. Тэгэхээр тухайн санаа сэдэл, нөхцөл байдлуудаас хам хамаарч энэ асуудал зүйлчлэгддэг. Практик дээр согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсоны улмаас бусдын амь нас хохирсон үйлдэл дээр шүүх энэ асуудлыг тухайн хэргийн нөхцөл байдалтай холбож авч үзэж байгаа. Тухайлбал, Монгол Улсын дээд шүүх саяхан тээврийн хэрэгслийг согтуугаар жолоодсоны улмаас бусдын амь нас хохирсон үйлдлийг санаатай гэмт хэрэг гэж үзэж зүйлчилж шийтгэсэн асуудал гарсан. Яагаад ингэж шийтгэсэн бэ гэдгийг тодруулж авч үзэхэд тухайн этгээд найз охинтойгоо муудсаны улмаас уурандаа машины хамгийн дээд хурдан дээр хааз гишгэж маши тийм тахир зам дээр өндөр хурдаар явж, осол аваар хийж, хүний амь насанд хүрсэн. Энийг бол тухайн этгээд ухамсарлах

боломжтой байсан. Өөрөөр хэлбэл өөрийнх нь энэ аюултай үйлдлийн улмаас бусдын амь нас хохирох боломжтой гэдгийг тухайн хүн мэдэх боломжтой байсан гэж үзсэн. Тийм учраас энэ хэргийг тухайлбал болгоомжгүй үйлдсэн гэмт хэрэг гэж зүйлчлээгүй. Санаатай хүн амины хэрэг гэж зүйлчилж Улсын дээд шүүх жишиг тогтоож байгаа. Тийм учраас тухайн хэргийн нөхцөл байдлаасаа хамаарч энэ асуудлууд зүйлчлэл нь яригдаж, ял шийтгэдэг гэдгийг танд хэлье.

**С.Одонтуяа:** Цэндийн Сандаг-Очир гишүүн асууя.

**Ц.Сандаг-Очир:** Баярлалаа. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, 3 нэр төрлийн ялын бодлогыг чангалж байгаа юм байна. Оногдуулах ялыг зарчмын хувьд дэмжиж байна. Гэхдээ бас эргэж харах, нягталж үзэх, тооцоо судалгаан дээр тулгуурлах, мэргэжлийн хүмүүсийн санал хүсэлтийг сонсох гээд зүйлүүд байгаа юм байна гэж харж байна. Тухайлбал манайд чинь нэг жилдээ дунджаар 6, 7 мянган орчим ялтнууд ял эдэлж байгаа байх. Энэ хууль батлагдаад, хэрэгжээд эхлэхээр ер нь ялтнуудын тоо нэлээн нэмэгдэх шинжтэй юм болов уу гэж би харж байна. Ялын бодлогыг чангалснаар ер нь гэмт хэргийн гаралтыг бууруулах зорилгоор хийж байгаа боловч, нөгөө талаасаа энэ чиглэлийн гэмт хэргийн гаралт нь буурахгүй л байна л даа. Тэгэхээр ялтнуудын тоо эрс нэмэгдэх ийм логик харагдаад байна. Тэгээд яах вэ, ялын бодлого сул байгаа учраас энэ чиглэлийн гэмт хэрэг үйлдэгдээд буурахгүй байгаа. Тийм учраас чангалж байна гэж. Нөгөө талаас бас нийгэмтэй авч үзэх ёстой. Нийгэм ажилгүйдэл, ядуурал ихтэй байгаа учраас гэмт хэргийн гаралттай шууд л холбоотой. Шууд холбоотой. Тэгээд үүний цаана тухайн хүний хувь заяа, амь амьдралын асуудал яригдаж байгаа юм. Энэ асуудлыг бас сэтгэл хөөрлийн гэдэг юм уу нэг сошиал давлагаагаар үүссэн

асуудалтай холбогдуулж бас асуудалд хандах нь бас хэт түргэдсэн гэдэг юм уу, дутуу дулимаг болчих вий. Нягталж үзэх нь юу вэ гэхээр жишээ нь согтууруулах ундаа хэрэглэсэн нөхдүүд тэгээд баригдвал бүх шатын сонгуульд нэр дэвших эрх нь байхгүй болох нь. Бүх шатын төрийн албанд ажиллах эрхгүй болох нь насаараа нэг удаагийн гаргасан үйлдлээс болж гэдгээс авхуулаад нягталж үзэх, эргэж харах юмнууд бас байгаа юм биш үү. Яагаад гэхээр хүний амь, амьдралын асуудал, ажил төрлийн хувь заяаны асуудал яригдаж байгаа учраас. Нөгөө талаар энэ хүчиндэх гэмт хэрэг. Бага насны хүүхдийн хүчиндэх гэмт хэрэг тэр 14, 16 насны тооны хоорондын ялгаа асар их зөрүүтэй юм байна лээ шүү. Энийг хэр тооцож нарийн нягталж үзсэн юм. Юм их нээлттэй болчихсон. Дэлхий даяарчлагдсан. Хүүхдүүд гар утаснаасаа л ерөөсөө бүх мэдээллийг үздэг, хардаг болчихсон. Хүүхдийн биеийн өсөлт бойжилт энэ цаг үед ямар болчихсон байгаа билээ. Өсвөр насны 2 хүүхэд 15-тай 2 хүүхэд үерхэж, дурлаад бэлгийн харьцаанд орсон тохиолдолд л өсвөр насны насны залуучууд хүүхдүүд маань л шоронгийн хаалга татах ийм үүд хаалгууд нээгдэж байна шүү дээ. Энэ хүчиндэх гэмт хэргийн чинь гаралтын 60, 70% нь гэр бүлийн орчинд үйлдэгдээд байна л гэж байна. Тэгэхээр тэнд байгаа эцэг эхчүүдийн хараа хяналт сул байгаатай шууд холбоотой л байна шүү дээ. Нөгөө талаар Монгол амьдрах орчин нөхцөл, сум, хөдөө, хөдөөгийн хүүхдүүд, эцэг эхчүүд хүүхдээ сумын төв дээр авчраад л нэг айлын хашаанд гэр барьж өгөөд л буулгаж байгаа юм. Нэг түрээсийн байр олж өгөөд л явж байгаа юм. Амьдрал дээр хууль бол өөрөө бас хэрэгжих бодит нөхцөл байх ёстой шүү дээ. Шууд нийтээр нь.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Хэн хариулах вэ. Энхбаяр сайд хариулъя.

**Б.Энхбаяр:** Үнэхээр согтуугаар тээврийн хэрэгслийг жолоодож байгаа

энэ олон мянган зөрчлийг гэмт хэрэгт тооцоноор гэмт хэргийн статистик хамгийн багадаа 2 дахин нэмэгдэнэ. Намайг Хууль зүйн сайдаар ажиллах яг энэ хугацаанд гэмт хэрэгтний тоо статистик 2 дахин нэмэгдсэн ийм тоо гарна. Би зүгээр ингээд гэмт хэрэг намайг сайд байх үед буурч байгаа, багасаж байгаа гээд хар амиа хоохойлоод бас улс төрийн хариуцлага мариуцлагаас өнгөлөн далдлалт хийгээд, нуугдаад явах сонирхол алга байгаа юм. Муу нуухаар сайн илчил гэдэг. Үнэхээр энийг нэг зөв дадал болгочихъё гэсэн бодол байна. Тухайлбал Исланд улс чинь бол ер нь архидалтаараа бол дэлхийд бас л толгой цохиж байсан улс юм байна лээ шүү дээ. 5 жилийн дотор бол ер нь эрс багасгасан. Яасан гэхээр ерөөсөө л хүүхэд залуучуудынхаа зөв боловсон өнгөрүүлэх орчнуудыг бүрдүүлсэн. Маши их хүүхдийн тоглоомын талбай, спорт заалууд, хөл бөмбөгийн талбайнууд байгуулсан юм байна лээ. Ерөөсөө ийм гоё орчин бүрдүүлдэг юм байна лээ. Сонголтыг нь өгдөггүй. Тэгээд нэгэнт тийм орчинд өөрийгөө эрүүл мэндийн хувьд хөгжүүлээд ингэж байгаа өсвөр насны залуучууд бол хэзээ ч тийм муу муухай юманд дурладаггүй. Одоо бол гэмт хэргийн гаралт бүх юмаараа өөр болчихсон. Та бүхэн хэрвээ санаж байгаа бол хөл бөмбөгийг нь шигшээд шилдэг 16-д үлдсэн шүү дээ. Хэзээ ч тэгж байгаагүй. Хаалгач нь шүдний эмч байсан шүү дээ. Тэгээд энэ юу хэлж байна вэ гэхээр бид нар ер нь энэ та тал руугаа явах үүрэг хариуцлагаа их сайн ойлгох ёстой юм байна лээ. Үнэхээр энэ хатуу тусна. Бүр хэнээс илүү хатуу тусах вэ гэхээр Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн гэдэг юм уу энэ сонгодог албан тушаалтнуудаас эхлээд илүү хүнд тусна. Яагаад гэхээр согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож байгаад л тэгээд л ял шийтгэдэг юм бол Их Хурлын гишүүнээсээ эгүүлэн татагдана шүү дээ шууд. Үр дагавар нь бол зүгээр тэр торгууль, нийтэд тустай ажил хийхээсээ илүү үр дагавартай. Үүний цаана бүх хүмүүс сигнал өгөх гэж байна

гэсэн үг. Тухайлбал манай хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиар шүүгч, прокурор, цагдаагийн байгууллагад урьд нь ял шийтгээж байгаагүй хүнийг ажиллуулдаг. Энэ бол ерөөсөө бүх түвшиндээ дээрээсээ эхлээд хуулийн байгууллагуудад ийм өндөр түвшний шаардлага цаашаа тавих гэж байна л гэсэн үг. Тэгээд өнөөдрөөс эхэлъе.

**С.Одонтуяа:** Сандаг-Очир гишүүн тодруулъя.

**Ц.Сандаг-Очир:** Баярлалаа. Ер нь бол хот суурин газарт энэ дуудлагын жолоочийн зах зээл орон зай бий болох юм байна гэж харж байна. Дуудлагын жолоочийн ийм тусгай үйлчилгээ эрхэлдэг байгууллага гэж байдаг юм уу. Зөвшөөрөл гэж өгдөг юм уу. Хэрхэн яаж. Тэр дуудлагын жолооч одоо таксинд явж байгаа таксины жолооч нар чинь бас хүчингийн хэрэг үйлдээд байгаа гээд яриад байгаа шүү дээ. Тэгвэл дуудлагын жолооч нар чинь гэмт хэрэг үйлдэхгүй байх баталгаа юм нь юунд байгаа юм. Ийм зохион байгуулалтад орсон юм байна уу, үгүй юу. Тэр хэн ирж аюулгүй байдлыг хангаж авч явах юм бэ гэдэг баталгаа юмыг хэн гаргах юм. Энэ талаар хууль юманд судалж барьж байгаа юм юу байна вэ гэдэг энийг нэг тодруулж өгөөч гэж тодруулж асууя.

**С.Одонтуяа:** Баттөмөрийн Энхбаяр сайд хариулъя.

**Б.Энхбаяр:** Бидний энэ өргөн барьсан төсөлд такси үйлчилгээ эрхлэх гэж залилах замаар хүчиндэх гэмт хэргийг үйлдэх юм бол хүндрүүлэх нөхцөлтэйгөөр ял шийтгэлийг нь чангалахаар 1 дүгээрт оруулж ирсэн байгаа.

2 дугаарт өнөөдөр Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Нямбаатар дарга нийслэл Улаанбаатар хотыг түгжрэлээс бууруулахтай холбоотой багц хуулийн

төслийг Засгийн газрын хуралдаанаар танилцуулсан байгаа. Энэ бодлогын хүрээнд Нямбаатар дарга бол Зөвшөөрлийн хуульд такси үйлчилгээг тусгай зөвшөөрөлтэй болгох, шаардлагыг нь өндөржүүлэх чиглэлд бас холбогдох хуулийн төслийг бол танилцуулсан. Ирэх 7 хоногт бас энэ асуудал бүлгүүдэд бас танилцахаар шийдсэн. Даваа гарагт. Тийм учраас энэ яг такси үйлчилгээтэй холбоотой асуудал бол хууль тогтоомжийн хүрээнд зарим нь эрүүгийн ял дээр бол хүндрүүлэх нөхцөл дээр орж ирсэн. Тэр зөвшөөрөлтэй холбоотой асуудал, стандарттай холбоотой асуудал бас орж ирэхээр өнөөдөр Засгийн газрын хурал дээр яригдсан гэдгийг та бүхэнд хэлье. Дуудлагын жолоочтой холбоотой мэдээлэл нэмж хэлэх мэдээлэл байгаа юу.

**С.Одонтуяа:** 89. Мөнх-Эрдэнэ зөвлөх.

**Д.Мөнх-Эрдэнэ:** Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Мөнх-Эрдэнэ. дуудлагын жолоочтой холбоотой яг одоо бол зөвшөөрөл авдаг зохицуулалт байхгүй. Сая Энхбаяр сайдын хэлсэн түгжрэлтэй холбоотой багц хуулийн төслүүд яригдаж байгаа. Энэ дээр бас энэ асуудлыг оруулахаар судалж ярьж байгаа гэдгийг хэлье. Түрүүн бас асуусан тэр согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсоноос болоод төрийн албанд орох боломжгүй болох ийм эрсдэл байна гэж асуусан. Энэ дээр бол хэлэхэд 2018 онд Улсын Их Хурлаас баталсан Төрийн албаны тухай хуульд төрийн жинхэнэ албан хаагчид тавигдах шаардлага дээр өмнө нь авлига, албан тушаалын гэмт хэрэгт ял шийтгүүлж байгаагүй байх гэж тодорхойлсон байгаа. Тэгээд үүн дээр нэмэх нь мөн түрүүний хэлдэг шүүгч, цагдаа, прокурорууд гээд өөр өөрийнх нь хууль дээр өмнө нь ял шийтгүүлж байгаагүй байх гэж заасан байдаг. Баярлалаа .

**С.Одонтуяа:** Жигжидийн Батжаргал гишүүн асууна.

**Ж.Батжаргал:** Баярлалаа. Тэгэхээр Эрүүгийн хуульд тодорхой төрлийн гэмт хэргүүдийн ялын бодлогыг чангатгасан ийм нэмэлт орж ирж байна. Хуулийн үзэл баримтлалынх нь хувьд дэмжиж байна. Тэгэхдээ бид хэд бодмоор бас анзаармаар юмнууд байх шиг байна гэж. Ер нь согтуурлын зэрэг гэдэг юм өөрөө хүний сэтгэх, самбаачлах, хянах чадварт ямар түвшинд хүрэхээр сулардаг юм л гэдэг л асуудлыг л тэр зэрэглэлийн босго гэж юм яриад байх шиг байна. Та хэд 0.5-аар оруулж ирж байгаа гэж ярьж байна шүү дээ. Тэгээд тэр шинжлэх ухааны үндэслэл юмнууд нь хэр хоорондоо уялдаж холбогдсон энэ эрүүл мэндийн гэдэг юм уу байгууллагуудад чинь тогтоосон барьсан юм байдаг юм уу гэдэг нэг ийм асуулт байна.

2 дахь зүйл.Аливаа зүйл өөрөө тогтоогдох боломжийн тухай л асуудал. Тэгэхээр зэрэг согтуурлын зэрэг тогтоодог юм бол байна. Одоо манай тээврийн цагдаагийнхан гэдэг юм уу эд нарт байна. Тэр мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх эмийг хөдөлгөөнд оролцож яваа хүн дээр тогтоодог юм гэж байна уу. Яах вэ, илт үнэхээрийн асуудал байна гэвэл тэр цус шээс 2-оор нь авдаг юм байж. Хүн болгоныг аваачаад эмнэлгийн гаднах лаборатори дээр аваачаад зогсоогоод байж чадахгүй юм байгаа биз дээ энэ чинь. Тэгэхээр үүнийг хялбаршуулсан байдлаар тогтоож чаддаг тийм тоног төхөөрөмж ашиглагддаг юм байна уу. Манайд тийм чадамж байгаа юу. Яагаад би энийг асууж байна гэхээр зэрэг түгжрэл янз бүрийн юмандаа 1 дүгээрт сөрөг нөлөөтэй, 2 дугаарт хүн хэлмэгдэх аюултай. Одоо бол энэ цаг үед дандаа нотолгоонд техник технологи дээр тулгуурласан нотолгоонд суурилсан юмны тухай л яриад байгаа байхгүй юу. Тэгэхээр бид тийм хэмжээний чадамжийг бий болгож чадсан уу гэдэг



асуудал. Энэ дээр тодорхой хариулт авъя.

Дараагийн нэг зүйл. Дээр үед бол шүүн таслах ажлын хүмүүжлийн үр нөлөө гэж ярьдаг байсан. Эрүүгийн хуулийг урьдчилан сэргийлэх гэдэг юм уу, хүмүүжлийн үр нөлөөтэй тухай түрүү сайд үгэн дотроо оруулна лээ. Тэгэхээр Ганболд гишүүн түрүүн хөндчихнө лээ. Зарим хуулиудын шинэчлэлийг тодорхой хугацааны ар дээр үйлчлэхээр заагаад, тэр хугацаанд бэлтгэл ажлуудыг нь хангаад хэрэгжүүлэх юм бол энэ нийгмийг шинэ мэдээллээр хангах, сэрэмжлүүлэг өгөх, тэгээд хүн болгоныг энэ төрлийн гэмт хэргээр асуудал шийдээд байхгүй байх бололцоо байгаа юм. Энэ чинь бид захиргааны зөрчлийг гэмт хэргийн ангилал руу татаж авч байгаа зүйл шүү дээ. Тийм биз дээ. Одоо бол Зөрчлийн хуулиар шийдэгдээд, цагдаа асуудлыг нь шийдээд яваад байгаа зүйл шүү дээ. Одоо ийм асуудал үүсэх юм бол наадах чинь бүгдээрээ шүүх дээр очиж шийдэгдэх гээд байгаа юм байна гэж би ойлгоод байгаа шүү дээ мөн биз дээ. Тэгэхээр энд бол нэлээн том ялгаа гарч байгаа. Тэгээд үүнийг бол нэг тийм хөнгөхөн хэлбэрээр ярьж боломгүй. Тийм учраас үүнийг энэ сурталчлан таниулах, сэрэмжлүүлэх, энэ үйл ажиллагааг ер нь ямархуу байдлаар хийж хэрэгжүүлнэ гэж бодоод байна вэ гэдэг ийм зүйлийг би асуумаар байна.

3 дахь миний асуумаар байгаа зүйл. Ялын бодлого интервал нь нэлээн л зайтай юм даа. 1 сая 300-аас 10 сая ч гэдэг юм уу. Мэдээж хөнгөрүүлдэг гэдэг юм уу, хүндрүүлдэг гэдэг юм уу, янз бүрийн нөхцөл нөгөө Эрүүгийн хууль юугаараа зохицуулагдаад явдаг л байх. Ер нь энэ өөрөө интервал хоорондоо холдох тусам дээд доод хязгаар нь холдох тусам ялгамжтай үйлчлэл хэрэгжээд байх нөхцөлийг бий болгоод байдаг зүйл.

**С.Одонтуяа:** Хэн хариулах вэ. Энхбаяр сайд.

**Б.Энхбаяр:** Батжаргал гишүүний хөндөж байгаа энэ болгоомжлолтой ер нь дав дув гээд л ер нь хуулийг хурдан түргэн батлаад л юу юугүй л байх ёсгүй гэдэгтэй би бол санал нэг байна. Ямар хугацааны дараа хуулийн хэрэгжилтийг хугацааг шийдэх вэ гэдэг дээр бол бас хууль тогтоогч бас ярих байлгүй дээ. Байнгын хороо дээр ажлын хэсэг гараад бас ярих байх гэж бодож байна. Бэлтгэл ажлын хүрээнд бол би цагдаад үүрэг өгөөд ер нь бэлтгэл ажлыг хангуулах чиглэлд бас зохион байгуулалтын арга хэмжээ аваад эхэлсэн. Үүнтэй холбоотой бас тээврийн цагдаа дээр ч гэсэн бас бүтэц, зохион байгуулалтын шинжтэй өөрчлөлтүүд хийгдэж таарна. Ялын интервалын хувьд бол энэ зайтай байдаг юм нь өөрөө шинжлэх ухааны бас үндэслэлтэй. Яагаад гэхээр амьдрал баялаг байдаг. Гэмт хэрэг болгон дахин давтагдашгүй байдаг. Яг адил гэмт хэрэг гэж байдаггүй. Гэмт хэрэгтний тэр явсан замнал, түүх, хувийн онцлог, санаа сэдэл, нөхцөл байдал, хохирол, хохирогчийн байдал, хохирлоо барагдуулж байгаа байдал, хохирлоо барагдуулаагүй байдал. Тийм учраас 2015 оны Эрүүгийн хууль дээр ялын интервалыг 2002 оны хуулиас бол илүү олон сонголттой, ял хоорондын зай илүү тэлсэн байдалтайгаар баталсан юм. Үүний үр дүн бол өгч байгаа гэж боддог 2002 оны тэр Эрүүгийн хуулийн ялын интервалын зай чинь ерөөсөө 3 жил байхгүй юу. Ингэвэл 5-8 өөр сонгох байхгүй. Хорих ял. Тэгээд манай шоронд дүрээд байсан учир нь тэр. Илүү гэмт хэрэгтэн болгоод л гаргаад байсан. Манай улс байна шүү дээ 2002 оны Эрүүгийн хуулиа баталснаас хойш 5 удаа Өршөөлийн хууль баталсан. Ер нь Өршөөлийн хуулийг тийм ойр ойрхон гаргаад байдаггүй байхгүй юу. Уг нь бол. Манайх арга буюу шорон дүүрээд гаргаад байсан. Энэ юу хэлээд байсан гэхээр манай Эрүүгийн хуулийн ял хоорондын санкц хэт уян хатан биш байна гэсэн үг. Өөр өөр олон төрлийн хэргүүдтэй юмыг нэг уутанд хийгээд байсан гэсэн үг.

2 дугаарт хэт богино байхаар хохирогчийнхоо хохирлыг барагдуулдаггүй. Хаашдаа би 5 жил авах юм чинь гээд хохирлоо барагдуулсан ч би 5-ыг авна, барагдуулаагүй ч 5-ыг авна гэхээр хохирогчийн зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирол барагдуулах механизм ерөөсөө ажилладаггүй байсан юм. Хуучин Эрүүгийн хуулиар 5 хохирогчийн 1 нь л хохирлоо барагдуулдаг байсан. Одоо шинэ Эрүүгийн хуулийн энэ ялын механизм ажилласнаар 5 хохирогчийн 4 нь, 3 нь хохирлоо барагдуулдаг болчихсон байхгүй юу.

**С.Одонтуяа:** Батжаргал гишүүн тодруулъя.

**Ж.Батжаргал:** Зарим асуултуудын хариу дутуу байгаад байна л даа. Тэр тоног төхөөрөмж нотолгооны тухай асуудал дээр тодорхой хариулт авмаар байна. Өөр өөрсдийнхөөрөө л ярьдаг байх. Энэ интервал холдох тусам ялгамжтай байдлыг бий болгоод байгаа юм яг үнэнийг хэлэхэд. Харин тийм учраас тэр зүйлчлэл дотроо авч үздэг юмнуудаа арай тодорхой болгож үүнийгээ задалдаг байдаг юм уу тийм хэлбэрээрээ асуудлаа ер нь шийдэх нь эрх зүйн шинэчлэл талд ч магадгүй зөв ч байхыг үгүйсгэхгүй гэж би ингэж хэлмээр байгаа юм. Энэ гэр бүл, хүүхдийн хүчирхийллийн асуудал дээр бид чангатгах ёстой. Гэхдээ анхдагч харилцаа нь гэр бүл дээрээ байгаад байдаг. Энэ дээр ямар бодлого, үйл ажиллагаа байх юм бэ гэдэг асуудал их чухал байгаад байгаа юм. Үүнийг тэр дараагийн орж ирэх асуудлаараа бодвол нэлээн их тодорхой яригдах болов уу гэж байгаа. Түрүүн Сандаг-Очир хөндөнө лээ. 14-ийг 16 болгож байгаа. Бид нэг талаасаа харахаар хохирогч талаасаа харвал зөв, үйлдэл талаасаа харах юм бол наадах чинь тийм эргэлзээтэй асуудал болоод байгаа юм. Үүнд бол нэлээн том дүн шинжилгээ хийж байж энэ 2 насны интервалаар үр дүн нь юу байгаа юм, үр дагавар нь юу байгаа юм гэдэг юмаа нэлээн сайн л харах ёстой

доо. Яаж харцгаасан юм. Бодвол харсан л гэж тайлбар өгөх байлгүй дээ.

**С.Одонтуяа:** 86 дугаар микрофон хариулъя. 86.

**Л.Нямдаваа:** Цагдаагийн ерөнхий газар Нямдаваа. Гишүүний асуултад хариулъя. Өнөөдөр цагдаагийн байгууллагын хэмжээнд Стандартчилал, хэмжил зүйн газраас 6 сар тутам баталгаажсан ХБНГУ-д үйлдвэрлэсэн Драгер брэндийн 95.10 гэсэн маркийн брэндийг бол улсын хэмжээнд зөвхөн замын цагдаа дээрээ хэрэглэж байна. Зөвхөн ч юу байх вэ, Замын цагдаагийн газар, алба дээр бол 697 тандагч, 324 драгер, 1 суурин драгер гэсэн ийм юуг төв, орон нутгийн хэмжээндээ бол хэрэглэж байна. Сogтолтын зэрэг ямархуу байдаг юм бэ. Хүнд яаж үйлчилдэг юм бэ гэдэг дараагийн асуултад нь хариулъя. Энэ нь олон улсад судалгаанаас согтолтын зэрэг, түүний нөлөөлөл нь бол 0,5-1% байх юм бол архи уусны дараа хэдэн минут болоод булчин нь суларч, ядрах нь багасаж сэтгэлийн хөдөлгөөн нь бол нэмэгддэг юм байна. 1,5-2,5 байх юм бол илэрхий биш зохицуулалт нь буурч янз бүрийн адал явдал гэдэг юм уу тэмцэл дор түрэмгийлэх шинж бол илэрдэг юм байна хүний биед. 2,5-3 бол энэ шатад байх юм бол өнгөрсөн зүйлийг хэсэгчлэн эсвэл бүрэн санахгүй байх, учирсан үйл явдлын дараа шинэ дурсамжаа хадгалах чадваргүй байх явдал нь бол нэмэгддэг юм байна. 3-4%-тай байх юм бол хүн хөдөлж, ярих чадваргүй. Энэ шатад тухайн хүн бусад хүмүүсийг танихгүй бөгөөд юу болж байгаагаа ер нь ойлгохгүй болсон ийм шинжтэй болдог юм байна. 5-6 дахь буюу 5 дахь шатан дээр бол этилийн спиртийн агууламж бол хэт их мэдрэлийн систем болон зүрх, элэгний гэмтлийн улмаас хүний биед хүчтэй хордлогыг даван туулах чадваргүй буюу хөлд хүргэх ийм шинжтэй болдог юм байна.

Түрүүн хар тамхи, мансууруулах бодистой холбоотой юуг яаж шалгадаг юм бэ гэсэн. Манай дээр бол нэг удаагийн тандагч төстийг бол бас мөн адил ашиглаж байна. Энийг бол иээснээс, цуснаас, эсвэл амны арчдас гэдэг юм уу ийм хэлбэрээр бол ашиглаж байна. Эндээсээ гаргаж ирээд хар тамхи мансууруулах бодистой холбоотой бодис илэрсэн гэж 13 төрлөөр үздэг. Энэ илэрсэн гэж үзэх юм бол дараагийн шатынхаа шүүхийн шинжилгээний байгууллагад шинжээч томилж явуулж ингэж баталгаажуулаад энэ яг аль төрлийн бодис вэ, синтетик уу, нийлмэл үү.../минут дуусав/

**С.Одонтуяа:** 82. Нэрээ хэлээрэй.

**Б.Гантуяа:** Ажлын хэсгийн гишүүн Гантуяа. Батжаргал гишүүний ялын интервалтай холбоотой асуултад хариулъя. Тэгэхээр 2002 оны Эрүүгийн хууль бол ялын интервалын хувьд бол 2-3 жил, 1 жил гээд маш богино байсантай холбоотойгоор тухайн гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдалд тохируулан ял оногдуулах боломжгүй нөхцөлүүд үүссэн ийм практик туршилага байсан учраас энэ туршилагатай холбогдуулаад шинэ Эрүүгийн хуульд ялын интервалыг илүү өргөн хүрээнд оруулж ирсэн байгаа. Мэдээж энэ ялын интервал илүү өргөн хүрээнд байхтай холбоотойгоор эрх бүхий албан тушаалтан, шүүгчдэд нөлөөлөл үүсэх боломжтой гэж үзсэн учраас Улсын дээд шүүхээс ял оногдуулах аргачлал буюу *entencing guideline* гэдгийг гаргах Их хурлын тогтоолын төсөл тухайн үед Эрүүгийн хуультай хамт батлагдсан байдаг. Тэгэхээр энэ ял оногдуулах аргачлалыг шүүхийн хэмжээнд гарч хэрэгжүүлснээр энэ нөлөөлөл бусдын нөлөөлөлд автахаас урьдчилан сэргийлэх боломжтой, ялгамжтай байдал арилах боломжтой гэж үзсэн байгаа.

**С.Одонтуяа:** Ширнэнбандийн Адьшаа гишүүн асуултаа асууна.

**Ш.Адьяа:** Монгол Улсын Засгийн газраас яаралтай горимоор бага насны хүүхдийн үйлдсэн гэмт хэрэг, түүнтэй холбогдох нийгмийн харилцааг зохицуулсан энэ хуулийн төслийг өнөөдөр оруулж ирж байна. Би Улсын Их Хурлын гишүүнийхээ бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн төслийг яаралтай горимоор хэлэлцүүлэх саналыг Улсын Их Хурлын нэгдсэн чуулган дээр тавьсан. Энэ миний саналыг дэмжсэн Засгийн газар, Оюун-Эрдэнэ Ерөнхий сайд, Хууль зүйн сайд Энхбаяр нарт бас талархал илэрхийлье.

Энэ 2 асуудал дээр л бид анхаарлаа хандуулах шаардлагатай байгаа гэж ойлгож байгаа. Яагаад гэхээр тэр бага насны хүүхэд түүнчлэн энэ мөрдөн шалгах үйл ажиллагааны нууцтай холбоотой асуудал. Би Монгол Улсын Ерөнхий прокурорын орлогч Чинбатаас нэг асуулт асууя. Энэ мөрдөн шалгах ажиллагааны нууцтай холбоотой асуудлыг Засгийн газраас өргөн барьсантай холбогдуулж нийгэмд янз бүрийн мэдээлэл тарсан байгаа. Хууль зүй, дотоод хэргийн сайд энэ талаар өөрийн байр сууриа илэрхийлсэн. Энэ мөрдөн шалгах ажиллагааны нууц задруулах явцад хүн гэдэг ойлголт байна гэдэг ийм асуудлыг нийгэмд тавьж, үүний дотор ялангуяа хэвлэл мэдээллийн хэрэгслийн боомлох хүний мэдэх эрхийг боомилсон, нийгэмд шүгэл үлээсэн хэвлэл мэдээллийнхнийг нухчин дарах ийм ажиллагаа байна гэдэг ийм ойлголтыг өнөөдөр тодорхой зорилготойгоор нийгэмд явуулж байгаа гэж би ойлгож байгаа. Энэ дээр бол Хууль зүй, дотоод хэргийн сайд энд байр сууриа илэрхийлсэн. Харин Монгол Улсын Ерөнхий прокурорын байгууллагын хувьд, энэ ажлын хэсэгт орж ажиллаж байгаагийн хувьд энд ямар байр суурьтай байна. Үнэхээр энэ хуульд тэр хэвлэл мэдээллийн байгууллагыг хүн гэдэг ойлголтын доор боомлох ийм санаатай зорилго байна уу, байхгүй юу. Ялангуяа энэ улсын нууц задруулсан гэмт хэргийн субъект болох энэ мөрдөн шалгах байгууллагын хүмүүстэй холбоотой энэ

асуудал өнөөдөр зайлигүй яаралтай горимоор оруулж ирж шийдэх хэмжээнд бий болсон уу гэдэгт Прокурорын байгууллагын байр суурийг нь сонсмоор байна. Энэ дээр нэг хариулт авъя.

Түүнчлэн өнөөдөр энэ Эрүүгийн хууль гэдэг энэ хуулийн үг, үсэг нэг бүрчлэн дээр бид анхааралтай, шийдэл гаргаж олон талаас нь ярилцаж шийдэх ёстой асуудал байгаа. Энд бол хүний амьдралын асуудал, хүний эрхийн асуудал байгаа учраас энд олон асуудлыг шийдэх ёстой гэж ойлгож байгаа. Хэлэлцүүлгийн явцад засаж залруулах шаардлагатай олон асуудал байна. Үүний нэг нь жолоодох эрхийг бүх насаар нь хасна гэсэн ийм заалт байгаа. Энэ дээр би Хууль зүйн байнгын хороо дээр ярьсан. Энэ дээр ямар байр суурьтай байна вэ гэдгийг хууль санаачлагчаас бас нэг тодруулга авъя. С

Согтууруулах үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон асуудал бол зөвхөн архи уусантай холбоотой гэж ойлгож байгаа. Гэтэл энэ мансуурах гэдэг энэ асуудлыг энд оруулж ирсэн байгаа. Мансуурна гэдэг бол энэ хар тамхитай аливаа асуудлыг үнэрлэж мансуурна гэдэг ойлголт энд давхар яваад байгаа юм шиг байна. Энэ дээр хууль санаачлагчийн зүгээс ямар бодолтой байна. Өчигдөр гутлын тос, цавуу, бензин гэх мэтийг үнэрлэсэнтэй холбоотой асуудал энд яригдана гэсэн ийм тайлбарыг хэлж байсан. Тэгэхээр энэ төрлийн асуудлыг өнөөдөр энэ энэ хуулиар чинь зохицуулж болох уу, болохгүй юу. Энийг тодорхой заах шаардлага байна.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Хэн хариулах вэ. Чинбат прокурор 81 дүгээр микрофон.

**М.Чинбат:** Адъяаа гишүүний асуултад хариулъя. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах байгууллага, албан тушаалтан, хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын төлөвлөлт,

явц, үр дүнгийн нууцлалыг хангаж ажиллахаар үүрэгжүүлсэн. Энэ талаар би түүрүн бас тодорхой хэлсэн. Мөрдөгч төрийн бол албаны нууц. Албаны нууц гэхээр байгууллагын нууц гэсэн үг. Хүний эмзэг мэдээлэлтэй холбоотой ажиллагаанд оролцож байсан, байлцсан хүмүүст нууцыг задруулахгүй байх үүргийг сануулж, бичгээр баталгаа гаргуулж ажиллаж байгаа. Энэ хэрэг мөрдөн шалгах ажиллагааны явцад зайлигүй хийгдэх ёстой ажил юм. Энэ нь өөрөөр хэлбэл мөрдөн шалгах ажиллагааны явц төлөвлөлт, үр дүнг бас алдагдахаас сэргийлж хийгддэг ажиллагаа. Энэ оруулж ирж байгаа хуулийн төсөлд бол энэ мөрдөн шалгах ажиллагааны нууц задруулсны улмаас үүсэх үр дагаврыг сэргийлж байгаа нэг заалтууд. Энэ дээр хариуцлагыг нь хүндрүүлж байгаа юм. 2002 оны хууль, 1986 оны хууль, 2002 оны Эрүүгийн хуульд мөн адилхан хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүгч, прокурорын зөвшөөрөлгүйгээр мөрдөн байцаалтын мэдээ баримтыг задруулсан бол хэн ч байсан хариуцлага хүлээдэг энэ хуулийн тогтолцоо явж ирсэн. Түүнээс 2017 оны хууль дээр ч гэдэг юм уу, өнөөдөр оруулж ирж байгаа хууль дээр хүлээх субъектийг өргөжүүлж байгаа ийм асуудал байхгүй гэж хэлье.

**С.Одонтуяа:** Адъяаа гишүүн тодруулъя.

**Ш.Адъяаа:** Тэр мөрдөн байцаалтын нууцыг задруулахтай холбоотой энэ асуудал зайлигүй шийдэх ёстой байгаа. Тэгэхдээ яаралтай горимоор оруулж ирэх ийм зайлигүй шаардлага үүссэн гэж ойлгож байгаа. Энэ ямар ийм шаардлага үүссэн бэ. Энэ талаар түүрүн хариулт авсангүй. Энэ дээр тайлбар авмаар байна.

**С.Одонтуяа:** Хэн хариулах вэ. Сайд.

**Б.Энхбаяр:** Мөрдөн байцаалтын нууцыг задалснаас бас авлигачид оргож

байна. Том хулгайчид хилийн гадагшаа зугтаад байна. Хэрэг илрүүлэхэд саад болж байна. Бага насны хүүхдийн хохирогчдын нэр төр, ирээдүйг алж байна. Тэр хүүхэд том болно. Насанд хүрнэ. Гэр бүлтэй болно. Ямар урагдалттай хүчиндүүлсэн тухай зарлаад байна шүү дээ энэ чинь. Хэрэг болгон өөр. Би түрүүн хэлсэн хүн алах гэмт хэрэг гэдэг бол реалити шоу биш. Ямар ч санаа сэдэлтэй байж болно. Хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийг илрүүлэх боломжийг алдагдуулж байна. Тийм учраас шаардлага гэж яривал би их олон юм яриаар байна.

**С.Одонтуяа:** Батсүхийн Саранчимэг гишүүн асуултаа асууя.

**Б.Саранчимэг:** Баярлалаа. Тэгэхээр хүүхдийн эсрэг гэмт хэрэг бол жилээс жилд нэмэгдээд байгаа. Тэгэхээр энэ хүүхдийн аюулгүй орчинд амьдрах нөхцөлд ийм эрсдэл учирч байгаа энэ цаг үед хүүхдийн эсрэг ноцтой гэмт хэргүүдийн ялын бодлогыг чангатгасан нэмэлт, өөрчлөлт оруулж ирэхийг бол дэмжиж байгаа юм. Тэгэхээр төсөлтэй холбоотой бас зарим зүйлийг асуумаар байна. Хүүхэд хамгаалал, гэмт хэрэг, хүчирхийллээс урьдчилан хамгаалахад олон улсын жишгийн дагуу бол 8 мянга хүүхэд тутамд 1 байцаагч байхаар орон тоог 103-аар нэмэгдүүлж, 2021 оноос төсвийг бас шийдвэрлэсэн байгаа. Нөгөө талаас 2016 онд сонгогдсон эмэгтэй гишүүд санаачлаад, хүүхэд хамгааллын төсөв байдаггүй байсан бол урьдчилан сэргийлэх зорилгоор эхлээд 5 тэрбумыг тавьсан. Тэгээд өнөөдрийн энэ судалгаануудаас хараад байхад урьдчилан сэргийлэх зүйл дээр орон тоо нэмэгдүүлж байна, төсөв бас нэмэгдүүлсэн. Тэгсэн мөртөө энэ ажил маань үр дүнд хүрэхгүй байна гэж салбарын яам үзэж байгаа энэ цаг үед салбарын яам өөрсдөө дүн шинжилгээ хийсэн үү. Хүүхдийн байцаагчдын ажлын үр дүнг дээшлүүлэх арга хэмжээ бас авч байгаа юу гэсэн ийм асуулт байна.

Нөгөө талаар согтуугаар машин барьсан жолоочийг гэмт хэрэгт тооцохоор орж ирж байна л даа. Тэгэхээр жилд бол 35 мянган хүмүүс согтуугаар барьсан тохиолдол байдаг гэсэн ийм судалгаа, статистик мэдээ байна. Тэгэхээр энэ 35 мянган хүн чинь бүгдээрээ ямар нэгэн гэмт хэрэг хийсэн гэж үзээд ийм ялтай болох нь байна. Тэгэхээр эндээс харахад бол бас мөрдөн байцаагчид нь энэ дээр ачаалал өгөх нь байна. Энэ ийм боломжтой байгаа юм уу. Энэ санкцаа бол ер нь зүгээр гэмт хэрэгт тооцохгүйгээр зөрчлийнхөө хуулиар согтуугаар барьсан хүмүүсийнхээ 5 жилээр эрхийг нь хасах ч юм уу, мөн өндөр торгууль өгөх юм уу энэ дээр ингэж харж үзэж болдоггүй юм уу. Ер нь гэмт хэргийн гол шинж бол нийгэмд аюултай хор учирсан байхыг шаарддаг. Тийм учраас өнөөдөр согтуугаар барьсан хүнд өнөөдөр ял өгнө, төрийн албанд ажиллахыг нь хориглоно, дээрээс нь 3 янзын юмнууд нэг дор орж ирж байгааг хараад байна. Тэгэхээр энэ дээрээ бас нэг дахиж эргэж харах ийм боломжтой юу гэсэн нэг ийм асуулт байна.

Нөгөө талаар согтуугаар машин барьснаас бол олон гэмт хэргүүд үүсэж байгаа. Энийг бол үгүйсгэхгүй. Тэгэхдээ энийг зөрчлийн хуулиар дахиад чангатгаад явах бүрэн боломж байгаа гэж би харж байгаа учраас энэ саналаа хэлж байна. Нөгөө талаар бол согтуугаас гадна энэ замын бас чанаргүй байдал, замаа нөхсөн байдал, энэ замын аюулгүй байдлаас болоод маш олон хүмүүс бас үхэж үрэгдэж байгаа. Тэгэхээр Өмнөговь, Дундговийн зам гэхэд л үнэхээр аймаар маш олон хүмүүс амь үрэгдэж байгаа шүү дээ. Энэ дээр бол хүмүүс ч надад эргэж ханддаг. Тийм учраас энд хэн хариуцлага хүлээх юм бэ. Энэ зам дээр, замын аюулгүй байдал дээр би бас илүү анхаарч ажиллана гэж бодож байгаа юм.

Дараагийн нэг асуулт бол хүчиндэх гэмт хэргийн гаралт сүүлийн 3

жилд огцом нэмэгдэж байгаа бас танилцуулга нь дурдсан байгаа. Тэгэхээр 2020 онд 505, гэмт хэрэгт бол 248, 2021 онд 439 гэмт хэрэгт бол 278, 2022 онд 550 гэмт хэрэгт 362 хүүхэд хохирсон гэж байгаа юм. Тэгэхээр энэ гэмт этгээдийн ихэвчлэн гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай байдаг гэсэн ийм судалгаа байгаа. Тэгэхээр энэ дээр асран хамгаалагч болоод эцэг эхийн тал дээр ямар бодлого бас барьж байгаа вэ гэсэн ийм асуулт байна. Баярлалаа.

**С.Одонтуяа:** Хэн хариулах вэ. 86.

**Л.Нямдаваа:** Гишүүний асуултад хариулъя. Цагдаагийн ерөнхий газар Нямдаваа. Цагдаагийн байгууллага энэ төрлийн зөрчлийг гэмт хэрэг болгосонд ажиллах хүч бэлэн үү гэсэн асуулт асууж байх шиг байна. Өнөөдөр цагдаагийн байгууллагад улсын хэмжээнд гэр бүл, хүүхэд, хүүхдийн эсрэг урьдчилан сэргийлэх чиглэлээр 241 албан хаагч, ажилтан ажиллаж байна. Бид нар бол урьдчилан сэргийлэх нэг бодлого цонхтой болгох зорилгоор урьдчилан сэргийлэх хэлтсийнхээ бүтцэд өөрчлөлт оруулаад гэр бүл хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх Экологийн цагдаагийн алба, Тээврийн цагдаагийн алба дээр байсан салангид бодлогыг нэгтгээд сайдаас өгсөн чиглэлийн дагуу бүтцийн өөрчлөлт зохион байгуулалтаа хийж байгаа.

2 дугаарт нь. Зөрчлийн хуулиасаа тэр согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон нэг зөрчил, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодоод хүний биед хөнгөн гэмтэл учруулсан нэг зөрчил, нэг үйлдэл, дээрээс нь шалгуулахаас зайлсхийсэн энэ 3 үйлдэлтэй холбоотой зөрчлийг гэмт хэрэгтэн болгож байгаатай холбогдуулан өнөөдөр нийслэлийн 6 дүүрэг дээр энэ зөрчлийг шалгадаг 3 байцаагч байдаг. Тэрний 1 нь бол дангаараа яг согтуу жолоочтой холбоотой зөрчлийг шалган шийдвэрлэдэг. Энэ зөрчлийг шалгадаг, согтуу жолоочийг шалгадаг зөрчлийн

байцаагчаар бид нар Тээврийн цагдаагийн албаны Мөрдөн шалгах хэлтэс рүүгээ 6 дүүргээсээ татаж байгаа. Доторх бүтцийн зохион байгуулалтаа хийж байна. Дээрээс нь өдөртөө гардаг 10-аад согтуу жолоочтой холбоотой асуудлыг тухайн дүүргийнх нь цагдаагийн хэлтсийн мөрдөн шалгах хэлтэст нь тасагт нь бол шилжүүлэн өгөөд ажиллахаар байгаа. Энэ дээр бол ямар нэгэн байдлаар ажлын ачаалал гэдэг юм уу, доголдол бол гарахгүй гэж тооцож байгаа.

**С.Одонтуяа:** Нэмж хариулах хүн байна уу. 3 асуулт асуусан. Сайд нэмэх үү. Энхбаяр сайд.

**Б.Энхбаяр:** Саранчимэг гишүүн бол үнэхээр бодит байдал бас тоо статистикуудыг бас хэллээ. Үнэхээр үнэн. Ялангуяа энэ бага насны хүүхдийн хүчингийн хэрэг гэр бүлийн ойрын хүрээнд бас үйлдэгдэж байгаа ийм мэдээлэл байдаг. Би бол энэ танилцуулгаас тэр хэсгийг нь бол бас жоохон хасаад, ер нь бол бага ярихыг л хүсээд байгаа юм. Өөрөөр хэлбэл үгүй ээ, ийм юм байж болохгүй зүйл шүү дээ. Хүний бүүр толгойд багтахгүй. Тэгэхээр нөгөө ийм юм байдаг ингэсэн, ингэсэн гээд байхаар бүр байж болдог юм байна гэдэг ийм хэвийн үзэгдэл мэт бүр ойлголт төрүүлэхийг л хүсэхгүй байгаа учраас л ярихыг түдгэлзээд байгаа юм. Энэ Эрүүгийн хуулийн бидний санаачилж байгаа өөрчлөлт дээр гэр бүлийн хамаарал бүхий 16 насанд хүрээгүй хүнийг хүчиндсэн гэмт хэрэгт одоо 8-15 жилийн ял шийтгэж байгаа. Энэ хуулийн өөрчлөлтөөр 8-15 жил ял шийтгэж байгааг 12-25 жил, эсвэл бүх насаар хорих ял болгож чангаруулах гэж байгаа юм. Өөрөөр хэлбэл тэр дагавар хүүхэд гэр бүлийн орчинд энэ үйлдлийг гаргаад байгаа тэр нөхдүүдийг ер нь тэгээд цоожлоод гаргахгүй л гэдэг ийм хатуу ял шийтгэлийн бодлого хэрэгжүүлэх гэж байгаа юм.

**С.Одонтуяа:** Саранчимэг гишүүний хариулт дутуу байна гээд байна. 81. Дараа нь 89. Чинбат прокурор.

**М.Чинбат:** Тэгэхээр Саранчимэг гишүүний асуултад хариулъя. Энэ зөрчлөөр шалгаж байсан ажил эрүүжээд ирэхээр ажил нэмэгдэх үү гэж асуулаа гэж ойлголоо. Тэгэхээр жилд дунджаар 50 орчим мянган согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчил статистик мэдээ бид гаргаж байна л даа. Өнөөдрийн 2023 оны эхний 3 дугаар улирлын байдлаар 36 мянган хүн согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон байна. Энэ бүхэн бол энэ төсөл дэмжигдэх юм бол эрүүгийн хэрэг болоод тэрийг нь шалгадаг мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн ажлын ачаалал одоо байгаа ажлын ачааллаасаа 3 дахин нэмэгдэх тооцоо гарч байгаа юм. Яагаад гэвэл өмнө нь бид 36-47 мянган хэрэгт жилдээ хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулдаг. Одоо энэ дээр нэмж 50 мянган хэрэг орж ирэх юм бол энэ ажил маань 2,5 дахин үндсэндээ нэмэгдэж байна. Тэгэхээр энд хүний нөөц, боловсон хүчин, тэгээд техник хэрэгсэл, мөрдөн шалгах ажиллагааны зардал хүртэл ороод явах, энэ дээр бол бид бас бодит ийм нэмэгдэх нөхцөл бол бүрдэж байна. Тэгээд энийг бас даван туулах бэлтгэлтэй л байх ёстой гэж би бодож байгаа юм.

**С.Одонтуяа:** Мөнх-Эрдэнэ зөвлөх нэмж хариулъя. 89.

**Д.Мөнх-Эрдэнэ:** Саранчимэг гишүүний асуултад хариулъя. Тэр одоо энэ зөрчил гаргачхаад байгаа 35 мянган хүний хувьд бол энэ Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлт хэрвээ батлагдах юм бол буцаж үйлчлэхгүй. Тэр утгаараа та бас энэ хүмүүсийн асуудал ингээд гэмт хэрэгт тооцогдоод, хариуцлага нь чангараад явах юм уу гэж асууж байвал энэ бол буцаж үйлчлэхгүй гэдгийг хэлье. Нөгөө талаасаа Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлт нь батлагдаад ялын бодлого чангарч байна гэдэг нь түрүүн бас яриад байсан урьдчилсан сэргийлэх

энэ эффект, үр нөлөө бол гарч эхэлнэ. Юу, юугүй энэ том, олон тоо бүгдээрээ согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодоод гэмт хэрэгт ял шийтгүүлнэ гэсэн үг биш. Энэ бол нөгөө ялын урьдчилан сэргийлэх үр нөлөө хэрэгжиж эхэлнэ. Хүмүүсийн ухамсарт тодорхой үр нөлөө үзүүлнэ гэж тооцож байгаа. Зөвхөн түрүүн бас сайдын танилцуулж байсан 7 хоногийн хугацаанд гэхэд л 46 орчим хувиар согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчлийн тоо буурсан байна гэдэг ийм үр нөлөө үзүүлж байгаа гэдгийг хэлье.

Нөгөө талаасаа та бас асуусан. Төрийн албанд ажиллах эрхийг нь хязгаарлах гээд байгаа юм биш үү. Хориглох гээд байгаа юм биш үү гэж. Тэгэхээр Улсын Их Хурлаас 2018 онд баталсан Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгаар бол зөвхөн авлига, албан тушаалын гэмт хэрэгт ял шийтгүүлсэн тохиолдолд төрийн жинхэнэ албанд ажиллахыг нь хориглосон байгаа. Үүн дээр мэдээж бас Шүүхийн тухай, Прокурорын тухай, Цагдаагийн албаны тухай хуулиудад тухайлан бас заасан ийм урьд нь ял шийтгүүлж байгаагүй гэсэн ийм зохицуулалт байгаа гэдгийг хэлье.

**С.Одонтуяа:** Тодруулга 1 минут.

**Б.Саранчимэг:** Би уг нь маш тодорхой асуулт асуусан. Одоо энэ хүүхдийн эсрэг гэмт хэрэг буурахгүй байна гэдэг дээр яам ямар дүгнэлт өгсөн бэ. Төсвийг нь нэмүүлсэн, орон тоог нэмэгдүүлсэн энэ тохиолдолд яг ямар дүгнэлт хийсэн бэ гэсэн нэг асуулт байсан. Нөгөө талаар сая тэглээ шүү дээ. Мөрдөгчид ачаалал очих уу гэсэн нэг нь ачаалал байхгүй, учрахгүй ээ, хүндрэл байхгүй гээд. 1 талаасаа үгүй ээ, энэ чинь төсөвт бас дахиад мөнгө сууна шүү гэдэг бодит байдлыг бас хэлж байна шүү дээ. Тэгэхээр та нар яг энэ дээрээ бас нэг бодит хариулт өг л дөө. Дээрээс нь тэр нэг төрийн алба, дээрээс нь жолооны эрхээр хасах, мөн энэ 3 санцр хэлээд

байгаа шүү дээ. Тэгэхдээ энэ согтуугаар барьсан хүмүүсээ эргээж үйлчлэх нь гол нь биш, цаашидаа энэ 35-50 мянган хүмүүс чинь бүгдээрээ гэмт хэрэгт тооцох гэж байна. Тийм учраас зөрчлийнхөө хуулиар энийгээ чангатгаад явж болохгүй юм уу гэсэн би ийм яг тодорхой.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Хэн хариулах вэ. Энхбаяр сайд хариулъя.

**Б.Энхбаяр:** Миний хувьд бол энэ криминологи талаас нь өөрөөр хэлбэл Хууль зүйн сайдын эрхлэх асуудалд холбогдох ял шийтгэлийн бодлого талаас нь хариултыг нь өгөөд байна. Өөрөөр хэлбэл энэ хүүхдийн эсрэг гэмт хэрэг, хүчирхийллийн шалтгаан нөхцөл, үүний гаралт, урьдчилан сэргийлэхтэй холбоотой асуудал дээр. Энэ хуулийн дараа бид Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэлэлцэх эсэх асуудлыг шийднэ. Энд бол бас нийгмийн хамгааллын бодлого талаас нь, хүн ам зүйн талаас нь хууль санаачлагч бас нэмж хариулах байх гэж бодож байна. Түүнчлэн ирэх 7 хоногт Засгийн газар Гэр бүлийн тухай хуулийг Шүүх байгуулах тухай хуультай хамт хэлэлцэнэ. Улсын Их Хуралд өргөн барьсны дараа мөн энэ асуудлыг бас гэр бүл төлөвлөлт, эцэг эхийн үүрэг, хариуцлагатай холбоотой асуудлыг нь бас ярих юм. Тийм учраас би нэг амьсгаагаар 32 цагаан лонх тоолж чадахгүй байгаад байгаа байхгүй юу.

**С.Одонтуяа:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүдийн нэрсийг авъя. Дэмжсэн 3, дэмжээгүй 3. Саранчимэг гишүүнээр тасаллаа. Ширнэнбандийн Адьшаа гишүүн үг хэлнэ.

**Ш.Адьяа:** Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай энэ 3 өөр заалттай хуулийн төсөл орж ирсэн. Ялангуяа энэ бага насны хүүхдийг хүчирхийлэх түүнтэй холбоотой гэмт хэргийн ялын бодлого, мөрдөн шалгах ажиллагааны нууц задруулах гэмт

хэргийн ялын бодлогын тухай өнөөдөр оруулж ирсэн энэ заалтуудыг бол зарчмын хувьд дэмжиж байгаа. Энийг бол яриад хэлээд, ялангуяа энэ шийдээд явах нь өнөөгийн үндэсний эрх ашгийн асуудал болчихоод байна. Энэ хүүхдийн гэмт хэргийн асуудал бол. Нөгөө талаасаа энэ мөрдөн шалгах ажиллагааны нууц задруулах асуудал бол Энхбаяр сайд сая ярилаа. Энэ авлигачид зугтаадаг. Түүнчлэн авлигачдыг өмөөрдөг, хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хамтарч улс төрчид хүнийг гүтгэдэг, доромжилдог, мөрдөн байцаалтын нууцыг задруулдаг, түүнээс гарах үр дагавар бол нийгэмд олон талаар хор уршигтай байна гэдгийг ярьсан. Энийг хэлэлцэхийг дэмжиж байгаа.

3 дахь энэ асуудал энэ согтуугаар тээврийн хэрэгслийг жолоодож гэмт хэрэгт холбогдох энэ асуудлыг бид олон талаас нь сайн хэлэлцэх шаардлагатай байна. Сайн хэлэлцэх шаардлагатай байна. Энийг энэ төслөөр оруулж ирвэл Зөрчлийн хууль гээд бид сүүлийн 5, 6 жилийн хугацаанд л энэ зөрчлийн хуулийн тухай ард иргэдтэйгээ, ард түмэнтэйгээ энийг шүүмжилдэг, үүнээс гарах үр дагаврын тухай олон талаас хэлэлцээд ямар ч үр дүнд хүрэхгүй байдаг ийм энэ Зөрчлийн хуулиар чинь адилхан ийм асуудал дагуулсан ийм нэг заалт энд орж ирэх гээд байна гэсэн ийм болгоомжлолтой байна.

Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож хүний амь хохироох, нийгэмд хор уршиг тарих энэ гэмт үйлдлийг өмөөрч байгаа юм биш. Гэхдээ үүнийг бид олон талаас нь ярьж хэлэлцэх шаардлагатай байна. Өнөөдөр хөдөө орон нутагт олон гишүүд ярилаа шүү дээ. Айраг уугаад, мотоцикл бариад явж байгаад цагдаад баригдвал хэчнээн мянган хүн өнөөдөр гэмт хэрэгтэн болох вэ, Хэчнээн олон хүний эрх ашиг, ял шийтгэлийн тухай, гэмт үйлдлийн тухай асуудал яригдах вэ гэдэг энэ асуудлыг бид олон талаас нь ярьж, хэлэлцэж, тодорхой судалгаан дээр шийдэл дээр



ярилцаж, шийдэх ёстой гэж бодож байгаа юм.

Хүнийг хуулиар шийдэх асуудал амархан. Хэрэг бүрдүүлээд, шүүх рүү өгөөд, алх цохиулаад хүний эрхийг хязгаарлах ишг амархан юм байхгүй. Гэтэл нийгмийн үр дагавар энэ гэмт хэргийг үйлдсэн хүмүүст тооцох ял шийтгэлтэй холбогдуулж гарах үр дагаврын асуудал. Нийгэмд нөлөөлөх нөлөөллийн асуудал, энд оролцож байгаа хүмүүсийн эрхийн асуудал. Цаашилаад энэ хүмүүс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнчлэн гэмт үйлдэл гаргах энэ нөхцөлийн тухай асуудлыг бид олон талаас нь судалж шинжилж, тодорхой судалгаан дээр, тодорхой шийдэл дээр ярьж шийдэхгүй бол энэ нөхцөл байдлаар өнөөдөр орж ирвэл нийгэмд олон асуудал, олон үр дагавар бий болгоно шүү гэдгийг хууль тогтоогчийн хувьд би хэлж байна. Энийг бид хэлэлцүүлгийн явцад нэр томъёо бусад бүх зүйл дээр олон талаас нь шинжилгээ судалгаа, ямар архины хэмжээг тогтоох юм, хэн тогтоох юм, айраг уусан хүнийг яах юм, архи уусан хүнийг яах, юм пиво уусан хүнийг яах юм, тэр гутлын тос үнэрлэсэн, цавуу үнэрлэсэн хүнийг яах юм гээд энэ талаар нарийн сайн ярьж шийдэхгүй бид өнөөдөр энэ архи уусан гэдэг үндэслэлээр нийгмийг айдас хүйдэст автуулсан олон ийм эрсдэлтэй, олон ийм шүүмжлэл дагуулсан, иргэдээ хохироосон, иргэдээ хэлмэгдүүлсэн ч ийм асуудал байхыг үгүйсгэхгүй байна. Тийм учраас энэ 3 дахь заалтыг бид олон талаас нь ажлын хэсэг дээр ярилцаж, төсөл санаачлагчид, бусад судалгаа шинжилгээний байгууллагыг оролцуулж байж үүнийг нэлээн сайн ярилцаж шийдэх шаардлагатай байна гэсэн ийм л байр суурьтай байна.

**С.Одонтуяа:** Батсүхийн Саранчимэг гишүүн үг хэлнэ.

**Б.Саранчимэг:** Энэ хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байгаа юм. Тэгээд би түрүүн бас яг асуусан

асуултууддаа яг тодорхой хариулт аваагүй учраас бас үг хэлж байна. Тэгээд ер нь бол сая та нар өөрсдөө ч хэллээ. Жилд 50 мянган хүн согтуугаар жолоо барьдаг гэсэн ийм баримт байгаа. Тэгэхээр энэ согтуугаар барьсан 50 мянган хүн чинь бүгдээрээ гэмт хэрэгтэн болоод Монголоор дүүрэн л гэмт хэрэгтэн болох нь байна шүү дээ. Тийм учраас энийгээ эргэж хараад нэг зөрчлийн хуульдаа улам чангатгаад 5 жилээр жолоог нь хасах ч юм уу, хэдэн саяар торгох ч юм уу энэ дээрээ эргэж хараач гэсэн нэг ийм санал байгаа юм. Тэгэхгүйгээр ингээд явах юм бол эргээд тэр мөрдөгчдийн тоо ч хүрэхгүй, өөр санхүүжилт бас хүрэлцэхгүй гэдгийг хэлж байна шүү дээ. Тэгэхээр энэ дээрээ энийг дахиж эргэж хараад оруулж ирсэн хуулиа бүр тулгаад байх биш, та нар эргээд хэлэлцээд явах хэрэгтэй байна шүү дээ.

Нөгөө талаар бол согтуугаар бариад олон хүний амь эрсдэж байгаа нь үнэн. Тэгэхээр бид нар энийг өнөөдөр чангатгах гээд сууж байгаа нь бас л зөв. Гэхдээ бид нар бас дахиж эргэж харах хэрэгтэй гэж байгаа юм. Согтуугаар барихаас гадна тэр замын чанаргүй хийцээс болдог юм уу, тэр нүх сүв гаргаад хүмүүс маш их гэмтэж байгаа. Энэ дээр хэн хариуцлага хүлээх юм бэ. Энэ тал дээр та нар бас замын чанар, замын хариуцлага дээрээ бас илүү их анхаарч ажиллаасай гэж хүсэж байна.

Бас нэг гол зүйл бол нөгөө хүүхдийн эцэг эхчүүд ганц энэ хүүхдийн хамгаалал гэдэг бол нийгмийн хамгааллын асуудал Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны асуудал биш. Бүх л энэ салбарын яам байгаа учраас та нар ямар дүн шинжилгээ хийсэн бэ гэдэг дээр хариулт авсангүй ээ. Энэ дээрээ яг нэг тодорхой дүн шинжилгээ хийгээд бид нарт бас эргэж танилцуулаарай гэж хүсэж байна. Баярлалаа.

**С.Одонтуяа:** Гишүүд үг хэлж дууслаа. Одоо санал хураалттай шүү

гишүүд ээ. Байнгын хорооны саналаар Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураана. Санал хураалт. Гишүүдийн олонх буюу 67,5 хувийн саналаар төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлээ.

18.21 цаг.

**2 дахь асуудал байгаа. Яаралтай горимоор оруулж ирсэн Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд Засгийн газар 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр өргөн мэдүүлсэн.**

Баярсайхан гишүүн горимын санал гаргах юм уу. Баярсайхан гишүүн горимын санал гаргая гэж байна.

**Б.Баярсайхан:** Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл бол маш чухал. Өчигдөр Нийгмийн бодлогын байнгын хороогоор энэ хуулийн төслийг хэлэлцсэн, маш хангалтгүй байсан. Тэгэхээр өнөөдөр цаг яг ингээж түлж хэлэлцэх нь учир дутагдалтай. Тэгээд энэ хэлэлцэх эсэх асуудлыг нь бас хойшлуулж өгнө үү гэсэн ийм саналтай байна. Өчигдөр шөнө энэ ер нь бол бүр хуулийн зорилго, үндсэн концепц, яг энэ шинэчлэл, өөрчлөлтийг хийж чадах хэмжээнд боловсруулагдаж орж ирээгүй байна гэж Байнгын хорооны гишүүдийн ихэнх нь үзсэн учраас өнөөдөр 12 цагийн

дотор бол сайжраад ороод ирсэн гэж бол харахгүй байна. Тийм учраас энэ хуулийг хэлэлцүүлэх асуудлыг хойшлуулж өгнө үү гэж хүсэж байна. Маш чухал хууль учраас нухацтай хандах шаардлагатай гэж.

**С.Одонтуяа:** Тэгэхээр хуралдаан зохион байгуулалтын нийтлэг журмын 9.1-ээр санал хураая. Товлосон асуудлыг ажлын цагт багтаан хэлэлцэж дуусаагүй бол хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар хуралдааны цагийг сунгаж болно.

Тэгэхээр гишүүдээ санал хураая. Цаг сунгаж Хүүхэд хамгааллын хуулийг хэлэлцэхгүй гэснээр. Цаг сунгаж хуралдъя гэснээр санал хураая.

Баярсайхан гишүүний саналаар энэ чухал асуудал учраас маргааши өглөө хуралдъя гэдгээр санал хураая. Санал хураалт. Өнөөдөр хэлэлцэх асуудалд орчихсон байсан байхгүй юу. Гишүүдийн олонх Баярсайхан гишүүний горимын саналыг дэмжсэн тул маргааши өглөө Хүүхэд хамгааллын тухай хуулийг хэлэлцэнэ ээ.

Өнөөдрийн хуралдаан хаасныг мэдэгдье.

18.25 цаг.

**ДУУНЫ БИЧЛЭГЭЭС  
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧИЙН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ**

**Э.СУВД-ЭРДЭНЭ**